

ЛГБТИК+ ХҮНИЙ ЭРХ

НИЙГМИЙН АЖИЛТАН, СЭТГЭЛ ЗҮЙЧ НАРТ
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот

2024 он



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



The Asia Foundation

Энэхүү гарын авлагын энэ удаагийн хэвлэлийг Америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн хэвлэв. Тус бүтээлд илэрхийлэгдсэн агуулга нь зохиогчийн үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсвэл дээрх агентлаг, сан, байгууллагуудын албан ёсны байр суурь биш болно.



ДАА 340
ННА 67
Ө-741

Зохиогчид:

Б.Алунгоо, ЛГБТ Төв
Н.Анараа, ЛГБТ Төв
Л.Баянтөгс, Онол - Арга
Б.Батхишиг, доктор (Ph.D) МУИС
Г.Доржжанцан, ЛГБТ Төв
М.Нямдорж, МУБИС
Х.Өлзийтунгалаг, НАБСХ

Хянан тохиолдуулсан:

Х.Өлзийтунгалаг, НАБСХ
М.Нямдорж, МУБИС

ISBN 978-99978-977-8-7

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Г.Сүрэнхор

Улаанбаатар хот 2024 он

Copyright © 2018, Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙГ ОЙЛГОХ НЬ	8
1.1 Бэлгийн чиг баримжаа	8
1.2 Хүйсийн баримжаа.....	11
1.3 Хүйсийн илэрхийлэл	12
1.4 Интерсекс байдлын талаарх үндсэн ойлголт.....	19
1.5 ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдал.....	21
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БЭЛГИЙН ЦӨӨНХ ХҮМҮҮСТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ПРАКТИК	25
2.1 Бэлгийн цөөнх олон нийттэй ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага.....	26
2.2 Ялгаатай байдал	33
2.3 ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээ.....	43
2.4 Олон улсын сайн туршлагууд.....	
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БЭЛГИЙН ЦӨӨНХ ХҮМҮҮСТЭЙ АЖИЛЛАХ СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ.....	73
3.1 Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж.....	
3.2 Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж.....	
ДӨРӨВ. МОНГОЛ ДАХЬ БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	
4.1 Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, институцууд	
4.2 ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхэд хамаарах Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ	
4.3 Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн хүрээнд Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг.....	
ХАВСРАЛТ	
Хавсралт 1. Түгээмэл асуултууд.....	
Хавсралт 2. Судалгааны үр дүн	
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	133
ЛГБТ ТӨВИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	135

ӨМНӨХ ҮГ

Бүх хүн нэр төр, эрхийн хувьд эрх чөлөөтэй, тэгш төрдөг. Хүний бүх эрх нь түгээмэл, харилцан хамааралтай, хуваагдашгүй, хоорондоо уялдаа холбоотой байдаг. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хүн бүрийн нэр төр, хүн байхын мөн чанарын салшгүй хэсэг бөгөөд эдгээр нь ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн үндэс болох ёсгүй. Бүх хүн тэгш эрх, чөлөөтэй төрдөг ба нэр төр, эрхийн хувьд ч тэнцүү байдаг. Бүх хүний эрх нь түгээмэл, хоорондоо харилцан хамааралтай, хуваагдашгүй. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хүн бүрийн эрхэм чанар, хүний мөн чанарын салшгүй нэг хэсэг байдаг утгаараа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн үндэс болох ёсгүй (Олон улсын хүний эрх, эрх зүйн Жогжакартын зарчмууд)

Бэлгийн цөөнх буюу ЛГБТИК+ хүмүүс бусдын адил эрх тэгш, эрүүл, аюулгүй амьдрах эрх бүх шатанд ноцтой зөрчигдсөн хэвээр байна. Үүний анхдагч ба үнэмлэхүй шалтгаан нь ялгаварлан гадуурхалт бол үүнийг нөхцөлдүүлэгч хүчин зүйл нь мэдлэггүй байдал юм. ЛГБТИК+ хүмүүсийн талаарх шинжлэх ухаанч бус, буруу ташаа мэдээлэл олон нийтийн дунд хүчтэй байх тусам ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл мөн адил ихсэж, энэ нь цаашлаад дан ганц ЛГБТИК+ хүмүүс биш, тэдний гэр бүл, ойр дотнынхон, найз нөхдийн сэтгэл санаа, эрүүл мэнд, амьдралын сайн сайхан бүхнийг үгүй хийсээр байна. Тиймээс нийгэмд үнэн зөв, шинжлэх ухаанч мэдээллийг олгохын тулд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх шаардлага зайлшгүй тулгараад байгаа юм.

Нийгмийн ажил, сэтгэл судлалын шинжлэх ухаанд ЛГБТИК+ хүмүүстэй ажиллах нь эн тэргүүнд хүний эрхийн зарчимд үндэслэсэн байх ёстой хэмээх олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг харгалзан үзээд, энэхүү шинжлэх ухааны орчин цагийн замнал, хөгжил, практик ба ёс зүй нь нийгмийн болон бусад шинжлэх ухааны салбар хоорондын хөгжилд суурилж буйг ойлгон, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хэтийн зорилгыг ойлгож хүн бүрт ээлтэй, хүнлэг нийгмийг бүрдүүлэх алсын харааг хэрэгжүүлэх үүднээс энэхүү гарын авлагыг онол, практикийн үүднээс боловсруулсан болно.

Нийгмийн ажилтнуудын ЛГБТИ хүмүүстэй ажиллах чадавхыг бэхжүүлэх “ЛГБТИ - ХҮНИЙ ЭРХ” гарын авлагыг Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр “Монголын Нийгмийн Ажлын Багш Сургагчдын Холбоо” ТББ, “Онол-Арга” ТББ, “ЛГБТ Төв” ТББ хамтран боловсруулж та бүхний гарт хүргэж буй анхны бүтээл юм.

Энэхүү гарын авлага нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч та бүхэнд ЛГБТИ хүмүүсийн талаарх шинжлэх ухаанч, үнэн, зөв ойлголтыг өгснөөр ЛГБТИ хүмүүст бүх шатны мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлээд зогсохгүй, олон нийтийн дунд үнэн, зөв ойлголтыг нэмэгдүүлж, Монголын нийгэмд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээс үл хамааран хүн бүрт ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэхэд нөлөө үзүүлнэ гэдэгт найдаж байна.

Зохиогчид



***Нийгмийн ажлын багш нар, хөтөлбөрийн албаны
мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт-2017 он***

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

ЛГБТИК: лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйир гэсэн үгсийн товчлол. ЛГБТИК+ хэмээх үг нь бүх бэлгийн болон хүйсийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог. ЛГБТИК хэмээх товчлолыг хэрэглэхдээ хүмүүсийг төөрөлдүүлэхгүйн тулд заавал бүрэлдэхүүн үгсийг нь мөн задлан тайлбарлах нь зүйтэй.

Бэлгийн чиг баримжаа: бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдах төрөлхийн үзэгдлийг бэлгийн чиг баримжаа гэнэ. Бэлгийн чиг баримжаа нь төрөлхийн ба өөрчлөгдөшгүй байдаг тул өөрчлөгдөх шинж чанартай гэсэн утгыг агуулдаг “хандлага” хэмээх үгийг бэлгийн чиг баримжааны хувьд хэрэглэхээс зайлсхийх ёстой. Хүн бүр бэлгийн чиг баримжаатай.

Хүйс: хүмүүсийг эр, эм хэмээн ялгах ангилал. Хүүхэд төрөхөд түүний бие махбодын өгөгдөл болох хромосом, даавар нөхөн үржихүйн дотоод ба гадаад эрхтэнд үндэслэн түүний хүйсийг тогтоодог.

Хүйсийн баримжаа: өөрийн хүйсийг эрэгтэй эсвэл эмэгтэй гэдгээ мэдрэх хувь хүний дотоод мэдрэхүй. Хүн бүр хүйсийн баримжаатай.

Хүйсийн илэрхийлэл: хүйсийн баримжааны гадаад илэрхийлэл. Энэ илэрхийлэл нь хүн биеэ авч явахдаа эмэгтэйлэг, эрэгтэйлэг эсвэл хүйсийг нь тодорхойлох боломжгүй байдлаар илэрхийлж буй байдлууд болох хувцаслалт, үс засалт, хоолой болон бие махбодын шинжээр илэрдэг.

Сизжендэр: өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйстэй ижил мэдэрч, тодорхойлдог хүмүүсийг хамарсан, тэмдэг нэрээр хэрэглэгддэг нэр томьёо.

Трансжендэр: өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрч, тодорхойлж, илэрхийлдэг хүмүүсийг хамарсан, тэмдэг нэрээр хэрэглэгддэг нэгдсэн нэр томьёо. Трансжендэр хүмүүс хүйсээ өөрийгөө мэдэрч буй дотоод хүйсийнхээ мэдрэмжтэй нийцүүлэн илэрхийлдэг.

Нонбайнари: эрэгтэй эмэгтэй гэх хүйсийн хоёр туйлд өөрсдийгөө багтааж үздэггүй, эсвэл өөрийгөө аль аль хүйсэд хамааруулж мэдэрдэг хүмүүсийн хувьд хэрэглэдэг олон улсын нэр томьёо юм.

НЭГ. ЛГБТИК+ ОЛОН НИЙТИЙГ ОЙЛГОХ НЬ

1.1 БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА

“Бэлгийн чиг баримжаа” нь эсрэг, ижил эсвэл нэгээс илүү хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй зүрх сэтгэлийн дотно ба бэлгийн харилцаа үүсгэх хүн бүрийн гүн гүнзгий мөн чанар, чадвар юм (*Жогжакартын зарчмууд 2010*). Хүний бэлгийн чиг баримжааг төрөлхийн ба олон талт мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч Америкийн сэтгэц, эмгэг судлалын холбоо 1973 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний ангиллаас албан ёсоор хасаж, үүний дараа 1974 онд Америкийн сэтгэл зүйчдийн холбоо ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн үзэж сэтгэцийн өвчин биш гэдгийг мөн зарлажээ.

Олон улсын түвшинд 1990 оны 5-р сарын 17-ны өдөр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч сэтгэцийн өвчнөөс албан ёсоор хассанаа зарласан байна. Үүнээс өмнө 1948 онд ДЭМБ-аас олон улсын өвчний 6-р ангиллыг хэвлүүлсэн ба энэ нь сэтгэцийн өвчний жагсаалт бүхий анхны ангилал байсан юм. Хэдийгээр энэхүү 6-р ангилалд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хувь хүний хөгжилтэй холбоотой бэлгийн гажуудал хэмээн ангилсан боловч маш олон судалгаагаар энэ нь батлагдаагүй (*Hooker E. Reflections of a 40-year exploration. A scientific view on homosexuality. Am Psychol. 1993;48(4):450-3.*).

Түүнээс хойших олон судалгаануудаар ижил хүйсийн зан үйл нь хүний бэлгийн мөн чанарын маш өргөн тохиолдох нэг хэлбэр ба илэрхийлэл гэдэг нь нотлогдсон. Өнгөрсөн 50 жилийн дотор өвчнийг ангилах олон тогтолцооноос ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа гэсэн ойлголтыг ашиглахгүй болсон. Энэхүү өөрчлөлт нь хүний эрхийн хэм хэмжээ болон бэлгийн чиг баримжааны илэрхийллийг эмгэг гэж авч үзэх анагаахын үүднээс эмпирик нотолгоо байхгүйтэй холбоотой (*Drescher J. Out of DSM: Depathologizing Homosexuality. Behav Sci (Basel). 2015 Dec; 5(4): 565-575.*).

Бэлгийн чиг баримжаа хэрхэн, яагаад бүрэлддэгийг шинжлэх ухаан бүрэн тогтоогоогүй ч ген, ургийн хөгжилд эхийн хэвлий дэх дааврын нөлөө, удамшил гэх мэт маш олон хүчин зүйлээс үүддэг гэж үзэж байгаатай холбоотой. Түүнчлэн бэлгийн чиг баримжаа нь сайн дураараа сонгож болох зүйл биш гэдгийг шинжлэх ухааны үүднээс бүрэн хүлээн зөвшөөрсөн билээ. (*АНУ-ын Сэтгэл зүйчдийн холбоо, Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаарх*

асуулт, хариулт <http://www.apa.org/topics/lgbt/orientation.aspx>

Шинжлэх ухааны хувьд хүний бэлгийн чиг баримжааг ерөнхийд нь 3 ангилж үздэг ба үүнд эсрэг хүйсийн (heterosexual), ижил хүйсийн (homosexual), аль аль хүйст чиглэсэн (bisexual) бэлгийн чиг баримжаа багтдаг. Түүнээс гадна хүйсийг хоёр туйлт зүйл хэмээн үздэггүй хүмүүс өөрийн бэлгийн чиг баримжааг энэ гурван ангиллын аль нэгт багтаахыг үгүйсгэдэг ба хоёр ба түүнээс илүү хүйсээр өөрийгөө тодорхойлдог, мөн нэгээс илүү хүйсийн хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжааг пансексуал, панромантик, полисексуал, омнисексуал гэх мэтээр нэрлэх нь 1990-ээд оноос хойш нэлээд түгээмэл болсон.

Бэлгийн чиг баримжааг 2000 он гарсаар өөр нэгэн байдлаар ангилахыг сэтгэл зүйчид санал болгох болсон нь мөн л хүйс гэдэг нь хоёр туйлт зүйл биш ба ялангуяа трансжендэр хүмүүсийн бэлгийн чиг баримжааны мөн чанарыг илэрхийлэх зорилготой байсан. Тухайн хүний өөрийнх нь хүйсээс үл хамааран эмэгтэй хүн ба эмэгтэйлэг байдалд татагдахыг гинэфилик (gynephilic) бэлгийн чиг баримжаатай, эрэгтэй хүн ба эрэгтэйлэг байдалд татагдахыг андрофилик (androphilic) бэлгийн чиг баримжаатай, аль алинд болон аль ч байдалд татагдахыг амбифилик (ambiphilic) бэлгийн чиг баримжаатай хэмээн нэрлэж эхэлсэн байна. (Shackelford, T. and Hansen R, ed. *The Evolution of Sexuality*. 2015).

Гетеросексуал: эсрэг хүйсийн хүнд сэтгэл, хайр дурлал бие махбод, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй зүрх сэтгэлийн дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар буюу эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаа юм. Гетеросексуал бэлгийн чиг баримжааг мөн “стрэйт” гэж хэлдэг.

Гомосексуал: ижил хүйсийн хүнд сэтгэл, хайр дурлал бие махбод, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй зүрх сэтгэлийн дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар буюу ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа юм. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрэгтэй хүмүүсийг гей, эмэгтэй хүмүүсийг лесбиян гэж нэрлэдэг.

Бисексуал: хоёр болон түүнээс олон хүйсийн хүнд сэтгэл, хайр дурлал бие махбод, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй зүрх сэтгэлийн дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар буюу аль ч хүйсийн хүнд татагдах бэлгийн чиг баримжаа юм.

Шинжлэх ухааны үүднээс шалтгаан ба явцыг нь тодорхойлж, чиглүүлэх огт боломжгүй, хүн бүрийн төрөлхийн, тухайн хүний салшгүй мөн чанар буюу бэлгийн чиг баримжааг биологийн шинжлэх ухаануудын үүднээс авч үзэхээс илүү эрх зүйн шинжлэх

ухааны үүднээс авч үзэх ёстой судлагдахуун буюу эрх хэмээн 1994 оноос хойш олон улсын эрх зүйд үзэх болсон. НҮБ-ын Иргэний болон улс төрийн олон улсын пактын хэрэгжилтийг хянадаг Хүний Эрхийн Хорооноос 1994 онд анх удаа “хүйс” хэмээх ойлголтод хүйстэй холбоотой, хүний хайр дурлал болон бэлгийн амьдралын илэрхийлэл болсон бэлгийн чиг баримжаа гэдэг ухагдахуун багтана хэмээн заасан ба өдгөө 2011, 2014 ба 2016 онуудад НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг хүний эрхийн томоохон зөрчил мөн ба зогсоох ёстой үзэгдэл талаар гурван тогтоол гаргаад байгаа билээ. (*Human rights, sexual orientation and gender identity A/HRC/RES/17/19, Human rights, sexual orientation and gender identity A/HRC/RES/27/32, Protection against violence and discrimination based on sexual orientation and gender identity A/HRC/RES/32/2*)

Бэлгийн чиг баримжаа нь сонголт биш бөгөөд хүүхэд төрөхдөө бэлгийн чиг баримжаагаа заяагдмал байдлаар олж төрдөг. Бэлгийн чиг баримжаагаа олж мэдэх нас нь хувь хүн бүрд харилцан адилгүй ч хүнд татагдаж, дурлах мэдрэмж эхэлсэн үеэс, ялангуяа бэлгийн бойжилтын үед илүү тодорхой мэдэрдэг байна. Бэлгийн чиг баримжаа нь нэгэнт сонголт биш, төрөлхийн, салгаж болдоггүй мөн чанар гэдгийг шинжлэх ухаан хүлээн зөвшөөрсөн учир уруу татагдах, олдмол байдлаар бий болох, ЛГБТИК+ болох гэх мэт ойлголтууд нь шинжлэх ухаанч бус, худал бөгөөд хор уршигтай, буруу мэдээлэл юм. Эдгээр шинжлэх ухаанч бус, ам дамжсан, буруу ойлголт олон нийтийн дунд хүчтэй байдгаас ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг үзэн ядалт их болж, үүнээс үүдэн ЛГБТИК+ хүмүүс өдөр тутамдаа ялгаварлан гадуурхагдаж, гэмт хэргийг хохирогч болсоор байна.

1990 оны 05-р сарын 17-нд ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай байхыг ДЭМБ-ын өвчний ангиллаас хасаж өвчин гэж үзэхээ больсон билээ. 2004 оноос дэлхий даяар энэхүү өдрийг Гомофоби, трансфоби, бифобийн эсрэг олон улсын өдөр (IDAHOT) хэмээн ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг дэмжих үнэн зөв шинжлэх ухаанч мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор тэмдэглэлт өдөр болгожээ.

1.2 ХҮЙСИЙН БАРИМЖАА

Хүйсийн баримжаа нь хүн бүр хувь хүнийхээ үүднээс өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйстэйгээ адилаар эсвэл өөрөөр гүн гүнзгий мэдрэх мэдрэмж ба өөрийн биеийн тухай мэдрэмж (үүнд чөлөөт сонголтод үндэслэн биеийнхээ үзэгдэх байдлыг эм, хагалгаа болон бусад байдлаар өөрчлөх өөрчлөлт багтана). Хүн бүр хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй. Хүйсийн баримжааг сизжендэр, трансжендэр хэмээн ерөнхийд нь ангилдаг.

Сизжендэр гэдэг нь өөрийн хүйсийг төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэйгээ адилаар мэдэрч, тодорхойлдог хүмүүсийг хэлнэ.

Трансжендэр гэдэг нь өөрийн хүйсийг төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрч, тодорхойлдог хүмүүсийг хэлнэ.

Хэдийгээр хүний хүйсийн баримжааг сизжендэр болон трансжендэр гэж ерөнхийлөн авч үздэг боловч жендэрийн хувьд ялгаатай маш олон хүмүүс байдаг. Эдгээр хүмүүсийн хувьд хэрэглэдэг олон нэр томьёо байдаг. Нонбайнари, жендэркүйр, ажендер, жендэрфлүйд гэх мэт. Тийм учраас хүйсийн баримжааны хувьд ямар нэр томьёо хэрэглэдгийг нь тухайн хүнээс асуух нь чухал бөгөөд хэний ч өмнөөс харагдах байдлаар нь хүйсийн баримжааг нь тодорхойлж, дуудах ёсгүй. 1985 оноос хойш АНУ-д ЛГБТИК+ хүмүүсийн төлөө ажиллаж буй GLAAD байгууллагаас 2017 оны эхээр хэвлүүлсэн судалгаанд АНУ-ын хүн амын 18-34 хүртэл насны залуучуудын 20% нь өөрсдийгөө трансжендэр, эсвэл хүйсийн хувьд ялгаатай, эсвэл жендэркүйр хэмээн тодорхойлжээ (<http://www.glaad.org/publications/accelerating-acceptance-2017>).

Хүйсийн хувьд ялгаатай хэмээн өөрсдийгөө тодорхойлдог хүмүүс өөрсдийгөө эрэгтэй, эмэгтэй гэх хүйсийн хоёр туйлын аль нэгт хамааруулж үздэггүй, эсвэл эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хувьд өөрийгөө мэдэрч, тодорхойлдог хүмүүс юм.

Хүйсийн хувьд цөөнх болсон трансжендэр болон жендэрийн хувьд ялгаатай хүмүүсийн талаар үнэн зөв, шинжлэх ухаанч мэдээлэл дутмаг байдгийн улмаас, мөн 2000 он гартал бэлгийн цөөнхийн үл үзэгдэх, үл сонсогдох хэсэг байсан утгаар бэлгийн цөөнх олон нийт ч, нийт нийгэм ч эдгээр хүмүүсийн талаар буруу ташаа, сөрөг ойлголттой байсаар байна.

ДЭМБ-ын Өвчний Олон Улсын Ангиллын 2019 оны хувилбар 11 (ICD-11)-т өмнөх хувилбар (ICD-10)-т тусгагдсан “транссексуализм”, “хүйсийн баримжааны эмгэг” гэх зэрэг оношийг өөрчлөн “хүйсийн үл нийцэл” хэмээх ангиллыг шинээр оруулсан байна. Хамгийн гол анхаарах зүйлсийн нэг нь “хүйсийн үл нийцэл” оношийг “сэтгэцийн болон зан үйлийн эмгэг” бүлгээс гаргаж “бэлгийн эрүүл мэндтэй

холбоотой нөхцөл байдал” гэсэн шинэ бүлэгт оруулсан юм.

“Энэ нь транс болон хүйсийн олон янз байдалд багтах хүйсийн баримжаа нь сэтгэцийн эрүүл мэндийн өвчний нөхцөл байдалд хамаарахгүй гэдгийг нотолж байгаа бөгөөд тэднийг ийм ангилалд оруулах нь асар их гутаан доромжлолд хүргэж болзошгүй юм.” ДЭМБ (Европын товч мэдээлэл - ICD 11-ийн хүрээнд трансжендэр эрүүл мэнд, 2019)

1.3 ХҮЙСИЙН ИЛЭРХИЙЛЭЛ

Хүйсийн илэрхийлэл нь хүн биеэ авч явахдаа эмэгтэйлэг, эрэгтэйлэг эсвэл хүйсийг нь тодорхойлох боломжгүй байдлаар илэрхийлж буй байдлууд болох хувцаслалт, үс засалт, хоолой болон бие махбодын шинжээр илэрдэг.

Хүйсийн илэрхийлэл нь хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөн, дуу хоолойны өнгө гэх мэт эрэгтэйлэг, эмэгтэйлэг эсвэл холимог, эсвэл аль нь ч бишээр илэрхийлэгдэж болно. Хүнийг гаднах хэв байдлаар нь бэлгийн эсвэл хүйсийн цөөнх хэмээн шууд таамаглах боломжгүй бөгөөд хүйсийн илэрхийлэл нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг тодорхойлохгүй юм.

Хүйсийн баримжаатай холбоотой трансжендэр хүмүүсийн онцлог асуудлууд

1. Хүйсийн шилжилтийн тухай
 - a. Сэтгэл зүйн үйлчилгээ
 - b. Даавар болон дааврын эмчилгээ
 - c. Трансжендэр хүмүүст хийгдэх мэс заслууд
2. Харагдах байдлаа өөрчлөх буюу нийгмийн шилжилт
3. Трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд

1. Хүйсийн шилжилтийн тухай

Өөрийн мэдэрч буй хүйсдээ нийцэхийн тулд трансжендэр хүмүүс хүйсийн шилжилтэд ордог. Хүйсийн шилжилтэд олон төрлийн эмнэлгийн ажилбар болон эмчилгээ багтдаг. Мэргэжлийн хүмүүс трансжендэр хүмүүсийн шилжилтийг сэтгэл зүйн, дааврын эмчилгээ, мэс ажилбар гэсэн дарааллаар хийлгэхийг зөвлөдөг боловч хувь хүн өөрөө аль эмчилгээг хийх вэ гэдгээ өөрөө сонгох эрхтэй. Трансжендэр хүмүүс өөрийн хүсэл зоригоор л эмнэлгийн ажилбар, эмчилгээнд орох ба бусдын албан шахалтаар дааврын эмчилгээ, бусад ажилбар хийлгэх ёсгүй (Жогжакартын зарчмууд, 18-р зарчим ‘Хэнийг ч бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа, илэрхийлэлд нь үндэслэн аливаа хэлбэрийн эмчилгээ

эсвэл сэтгэл зүйн эмчилгээ, туршилтад албадан оруулах ёсгүй бөгөөд хүчээр эмнэлгийн байгууламжид хорих ёсгүй”).

Эрэгтэйгээс эмэгтэй хүйс рүү шилжсэн трансжендэр хүнийг трансжендэр эмэгтэй харин эмэгтэйгээс эрэгтэй рүү шилжсэн трансжендэр хүнийг трансжендэр эрэгтэй гэнэ.

Трансжендэр хүн ямар эмчилгээ сонгох нь түүний сонголт ба эрх боловч эмч болон анагаахын мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдсөнөөр шилжилтийн бүх шатны эмчилгээний эерэг болон сөрөг талыг нарийн сайн ойлгох боломжтой. Трансжендэр хүмүүс дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртэх шаардлагатай байдаг. Үүнд:

а. Сэтгэл зүйн үйлчилгээ: Трансжендэр хүмүүс харилцан адилгүй хугацаагаар хүйсийн тавгүйцэл болон олон нийт, гэр бүлээс ирэх өдөр тутмын ялгаварлан гадуурхалт, үзэн ядалт, түүнээс үүдсэн бүх төрлийн дарамт, хүчирхийлэл мэдэрдгээсээ болж ихэнх тохиолдолд сэтгэл зүйн хувьд хүнд хэлбэрийн сэтгэл гутрал, дарамтад орсон байх нь олонтоо. Тиймээс сэтгэл зүйн хувьд цөөнхийн стресст байнга өртдөг төдийгүй, амьдралын бусад бүх салбартаа их эмзэг байх талтай. Тиймээс сэтгэл зүйчийн тусламж маш чухал байдаг. Сэтгэл зүйч, мэргэжилтнүүдийн хувьд трансжендэр хүмүүсийн сэтгэл гутрал болон хүйсийн тавгүйцлийг үнэлэн, мэргэжлийн хүрээнд тусламж үзүүлэхээс гадна тухайн хүнд хүйсийн баримжаа, илэрхийлэл ба шилжилтийн процессын талаарх олон төрлийн мэдээлэл өгөхийн сацуу хүйсийн шилжилттэй холбоотой үүсэж болох эерэг болон сөрөг талуудыг ойлгуулах давхар үүрэг хүлээдэг. Зөвхөн бүрэн мэдээллийн үндсэн дээр трансжендэр хүн нь хүйсийн шилжилттэй холбоотой цаашдын шийдвэрээ гаргах ёстой. Монголын хувьд трансжендэр хүмүүс хүйсийн шилжилттэй холбоотой сэтгэл зүйн үйлчилгээг СЭМҮТ (Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв) дээр тодорхой хугацаагаар мэргэжлийн эмчээс авдаг болсон.

б. Дааврын эмчилгээ: даавар гэдэг нь хүний дотоод шүүрлийн булчирхайнуудад үүсдэг өвөрмөц бүтэц бүхий нэгдэл юм. Дааврын тусламжтайгаар хүний бие бие махбодын бүхий л үйл ажиллагаа зохицуулагдах бөгөөд сэтгэл санааны байдал, мэдрэмжээс авхуулаад нөхөн үржихүйн тогтолцоо гэх мэт бүхий л үйл явц дааврын оролцоотой явагддаг. Дотоод шүүрлийн эрхтэн систем нарийн зохион байгуулалттай ба

бэлгийн болон нөхөн үржихүйн үйл ажиллагааг бэлгийн булчирхайнаас ялгарах бэлгийн дааврууд зохицуулдаг.

Эмэгтэйчүүдэд бэлгийн даавар өндгөвчид (эстроген, прогестерон), (эрэгтэйчүүдэд бэлгийн даавар төмсөгт (тестостерон) тус тус боловсордог.

(Бэлгийн дааврын тусламжтайгаар хүний бэлгийн хоёрдогч шинж тэмдгүүд ялгаран хөгжих бөгөөд бидний ойлгодгоор эрэгтэйлэг ба эмэгтэйлэг шинжүүд, бүтцүүд (эмэгтэйчүүдийн хувьд: сүүний булчирхай томрох буюу хөх ургах, биеийн ерөнхий бүтцүүд тогтох үүнд бэлхүүс нарийсах, тааз өргөсөх гэх мэт, эрэгтэйчүүдийн хувьд: биеийн үс, сахал ургах, хоолойн хөвч өргөсөх буюу дуу хоолой бүдүүрэх, биеийн ерөнхий бүтцүүд тогтох үүнд мөр өргөсөх, мөч томрох гэх мэт) бий болдог юм.

Дааврууд

Трансжендэр хүмүүсийн эн тэргүүнд эхлүүлдэг шилжилтийн процессын нэг нь дааврын эм, бэлдмэл хэрэглэх явдал. Маш олон трансжендэр эмэгтэйчүүд өөрийгөө тодорхойлдог хүйст илүү ойртохын тулд даавар хэрэглэж эхэлдэг бол трансжендэр эрчүүд ч мөн ялгаагүй.

Транс эмэгтэйчүүдийн хувьд эстроген даавар хэрэглэдэг бөгөөд энэ нь хөхний ургалтыг дэмжих ба мөн физиологийн хувьд ялгарч буй эр бэлгийн даавар болох тестостероныг дарангуйлах Anti-androgen буюу эр бэлгийн дааврын эсрэг эмийг бас давхар уудаг.

Транс эрэгтэйчүүдийн хувьд тестостерон дааврыг ихэвчлэн хэрэглэдэг бөгөөд энэ нь үс сахал ургах, хоолой бүдүүрэх гэх мэт эрэгтэйлэг шинжүүдийг үүсгэхийн сацуу физиологийн хувьд ялгарч буй эм бэлгийн дааврыг дарангуйлж өгдөг.

Дааврын эмчилгээнээс үүдэх сөрөг талууд

Дааврын эмчилгээг эхлэх гэж байгаа тохиолдолд мэргэжилтнээс зөвлөгөө авч, биеийн ерөнхий байдлаа хянуулах нь нэн чухал байдаг. Өөрт тохирох бэлгийн дааврын талаар тодруулахын зэрэгцээ зүрх судас, элэг, бөөрний үйл ажиллагаа, цусан дахь сахар ихдэх гэх мэт биеийн ерөнхий байдлаа бүхэлд нь хянуулж, биеийн ерөнхий байдлыг илтгэх шинжилгээнүүдийг (ЭХО, зүрхний бичлэг, цусны шинжилгээ, биохимийн шинжилгээ, шээсний шинжилгээ гэх мэт) өгөх ёстой. Мөн архаг болон хууч өвчтэй тохиолдолд эмчийн зааврын дагуу илүү нарийн шинжилгээнүүд өгөх шаардлага үүсэж болно.

Зүрх судасны эрүүл мэнд: дааврын хэрэглээнээс шалтгаалан зүрх судасны үйл ажиллагааны ачаалал нэмэгддэг. Трансжендэр хүмүүс тамхи татдаг, илүүдэл жинтэй, цусны даралт ихдэлттэй, мөн чихрийн шижин зэрэг өвчтэй бол зүрхний шигдээс, цус харвалтын эрсдэл нэмэгддэгийг санах ёстой.

Хоргүй болон хортой хавдар: дааврын эмчилгээнээс үүдэн хоргүй болон хортой хавдар үүсэх нь ховор хэдий ч эмчийн хяналтад байнга байх ёстой. Хэрэв хүйсийн шилжилтийн мэс ажилбарууд хийгдээгүй байгаа тохиолдолд эмч нар бэлэг эрхтэнд үүсэж болох хавдрын эрсдэлийг тооцож үнэлэх нь их чухал. Дахин сануулахад хорт хавдар үүсэх нь ховор боловч тогтмол шалгуулж, үзлэг хийлгэж байх ёстой зүйлсийн нэг юм. (Allison R.A, 10 Things Transgender Persons Should Discuss With Their Health Care Providers 2012)

с. Мэс ажилбарууд: энэ нь трансжендэр хүмүүс өөрийн илэрхийлж буй хүйсийн баримжаатайгаа өөрийн хүйсээ нийцүүлэхийн тулд хийж буй бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтнүүдийн мэс ажилбарууд юм. Трансжендэр хүмүүс хүйсийн шилжилтийн мэс заслыг хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд бусад трансжендэр хүмүүсийн туршлагаас сонсоход илүүдэхгүй. Яг ямар үр дүн хүсэж буй болон ямар мэс ажилбар нь тухайн хүнд илүү чухал гэдгийг сайтар судалж, шийдвэрээ гаргах хэрэгтэй. Мэргэжлийн хүмүүс болон мэс засал хийх эмчээсээ асуухыг хүссэн бүх асуултаа санаа зоволтгүйгээр дэлгэрэнгүй асуух нь чухал.

Транс эмэгтэйчүүдийн хувьд:

- Төмсөг авах мэс засал: энэ мэс заслыг хийлгэсэн тохиолдолд та үргэлжлүүлэн эр бэлгийн даавар дарангуйлагч эмийг уух шаардлагагүй болох бөгөөд эстроген дааврыг хэрэглэх тун ч мөн багасна.
- Шодой авах мэс засал: энэ мэс засал дангаараа хийгддэггүй бөгөөд үтрээ бий болгох мэс ажилбарын эхний шат гэж хэлж болно.
- Үтрээ бий болгох мэс засал: энэ нь цогц мэс засал бөгөөд үүнд тухайн хүний бэлгийн мэдрэмжийг сэргээх зорилго бас багтана.
- Төвөнхөө хусуулах, бусад гоо сайхны мэс ажилбарууд багтаж болно.

Транс эрэгтэйчүүдийн хувьд:

- Үтрээ авах авах мэс засал
- Методиопласти буюу жижиг хэмжээний эр бэлэг эрхтэн бий болгох мэс ажилбар

- Фаллопласти буюу эр бэлэг эрхтний үйл ажиллагаа, хэмжээг сайжруулах мэс засал
- Хуухнаг үүсгэх мэс засал
- Шээсний сүв бий болгох мэс засал
- Умай авах мэс засал
- Өндгөвч авхуулах мэс засал
- Сүүний булчирхай авхуулах цээжний мэс засал болон хоолойн хөвчний гэх мэт мэс ажилбарууд багтаж болно (Asia Pacific Transgender Network, Blueprint for the Provision of Comprehensive Care for Trans People and Trans Communities in Asia and the Pacific 2015).

2. Харагдах байдлаа өөрчлөх буюу нийгмийн шилжилт

Нийгмийн шилжилт гэдэг нь өөрийн хүйсийн баримжаагаа өдөр тутмын амьдралдаа нийцүүлэн илэрхийлж эхлэх алхам бөгөөд трансжендэр хүмүүсийн хувьд хүйсийн шилжилтээ эхлэхээс ч өмнө зарим тохиолдолд өөрийгөө мэдэрч эхлэх тэр үеэс эхэлдэг ойлголт юм. Энэ энэ үсний засалтаа өөрчлөх, өөрийн хүйсийн баримжаагаамэдэрчбуйтэрхүйсдээтохируулжхувцаслах,биеийн хөдөлгөөн, үйлдэл, дуу хоолойгоо илүү эрэгтэйлэг эсвэл илүү эмэгтэйлэг байдалд нийцүүлэх гэж оролдох гэх мэт ойлголтуудыг багтааж болно. Энэ бүхэн нь чухамдаа хувь хүний сонголт бөгөөд өөрийгөө илүү эрэгтэйлэг эсвэл эмэгтэйлэг илэрхийлэх нь өөрт нь чухал ч байж болно үгүй ч байж болно. Энэ нь эмнэлгийн бус шилжилтийн алхмууд бөгөөд зарим трансжендэр хүмүүс өөрийнхөө харагдах байдлыг ийнхүү өөрчилдөг. Энэ нь тухайн хүний өөрийн мэдэрч буй хүйсийн баримжаагаа илэрхийлж буй анхдагч хэлбэр бөгөөд өөрийн сонголт дээр үндэслэдэг гэдгийг мартаж болохгүй. Хүйсийн баримжаа нь хүн бүр өөрийн хүйс, биеэ мэдрэх гүн гүнзгий, төрөлхийн мэдрэмж учир хүүхэд маш бага наснаасаа үүнийгээ мэдэрч илэрхийлж байдаг. Хүйсийн баримжаа ихэнхдээ бага насанд илрэх ч транс байдал илрэх тодорхой насыг заах боломжгүй (Asia Pacific Transgender Network, Blueprint for the Provision of Comprehensive Care for Trans People and Trans Communities in Asia and the Pacific 2015).

3. Трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд

Эн түрүүнд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа хоёрыг ялгаж ойлгох хэрэгтэй. Трансжендэр хүмүүс нь хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх болсон хүмүүс бөгөөд тэд ч гэсэн бусад хүмүүсийн адил ерөнхий 3 төрлийн бэлгийн чиг баримжаатай гэдгийг мартаж болохгүй. Тиймээс тухайн трансжендэр хүний хүйсийн баримжаанаас гадна давхар бэлгийн

чиг баримжаатай холбоотой асуудлууд тухайн хүний бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд шууд нөлөөлдөг болохыг санах ёстой. Нийтлэгээр дараах асуудлууд трансжендэр хүмүүсийн хувьд үүсдэг.

Хүйсийн шилжилттэй холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүртэх асуудлууд: трансжендэр хүмүүс ихэвчлэн эрт, орой хэзээ нэг цагт хүйсийн шилжилтэд орохыг сонгодог ба энэ талаар бүрэн мэдээлэл, эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүртэх асуудал хүндрэлтэйбайгааньөнөөгийнМонголынэрүүлмэндийнсалбарын трансжендэр эрүүл мэндээр ойлголт, мэдлэг тун бага байгаатай холбоотой. Нэгэнт трансжендэр хүн эмнэлгийн журмаар хүйсийн шилжилтэд орохыг сонгосон бол дааврын хүртээмж, тун, цаашдын мэс заслуудын төлөвлөгөө гэх мэт нарийн асуудлуудыг төлөвлөх, энэ талаар зөвлөгөө шаардлагатай болдог учир трансжендэр эрүүл мэндийн асуудлаар мэргэшсэн ЛГБТ Төв ТББ-д хандахыг зөвлөх нь одоогоор хамгийн оновчтой шийдэл юм.

Нөхөн үржихүйн эрхтэй холбоотой асуудлууд: хүн бүр гэр бүл зохиох, хүүхэд гаргах, өсгөх гэх мэт эрхийг нь нөхцөлдүүлж өгдөг нөхөн үржихүйн эрхээ эдлэх ёстой ч харамсалтай нь нөхөн үржихүйн тогтолцооны асуудал трансжендэр хүмүүсийн хувьд ярвигтай байсаар байна. Трансжендэр эмэгтэйчүүдийн хувьд хүйс шилжүүлэх мэс заслуудаа хийлгэсэн ч жирэмслэх боломжгүй. Одоогийн шинжлэх ухааны түвшинд трансжендэр эмэгтэйчүүдэд сав ургуулах, шилжүүлэн суулгах мэс засал бүрэн төгс хийгдэх боломжгүй.

Барууны орнуудын туршлагаас харахад трансжендэр хүмүүс шилжилтийн процессоо эхлэхээс өмнө өөрийн бэлгийн эсийг хадгалуулах боломжтой байдаг бөгөөд тодорхой хугацааны дараа тээгч эх хөлслөн хүүхдээ тээлгэх боломжтой. Гэвч бэлгийн эсийн донор банк болон тээгч эх хөлслөх зэрэг үйл явц нь маш үнэтэй, одоогоор дэд бүтэц хүртээмжгүй байдлаас үүдэн трансжендэр хүмүүс нөхөн үржихүйн эрхээ эдлэх боломж байдаггүй. Монгол орны хувьд бэлгийн эсийг хадгалах үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн байгууллага одоогоор байхгүй байна. Хэдийгээр үр шилжүүлэн суулгах ажиллагааг хэд хэдэн эмнэлэг амжилттай хийдэг (трансжендэр эмэгтэйчүүдэд үр шилжүүлэн суулгах боломжгүй) боловч бэлгийн эсийн донор байхгүй тул өөрсдөө донор болох хүмүүсээ олно гэсэн шаардлагыг тавьдаг байна.

Нийгэмшилтэй холбоотой сэтгэл зүйн болон бусад асуудлууд: трансжендэр хүмүүсийн хувьд хүйсийн тавгүйцэлтэй холбоотой олон жилийн ужиг сэтгэл зүйн асуудлууд байдаг дээр нэмэгдээд дотнын харилцаа болон нийгмийн харилцаануудаас үүдсэн асуудлууд үүсэж байдаг. Энэ нь тэр тусмаа трансжендэр

хүмүүсийн гэр бүлийн гишүүд болон дотнын хамтрагчтайгаа байх харилцаанд илэрдэг ба тухайн хүнийг трансжендэр гэдгийг нь үгүйсгэх, хүйсийн шилжилттэй холбоотой хүсэл зоригийг нь үл хүндэтгэх, трансжендэр байдлыг нь бусдад илчлэх, түүгээр нь гутаан доромжлох гэх мэт гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрт хүргэх онцлог нөхцөл байдгийг нийгмийн ажилтнууд болон сэтгэл зүйчид анхаарах ёстой. Давхар давхар ялгаварлан гадуурхалтыг даван туулах үйл явцад нь трансжендэр хүмүүсийн гэр бүлийн гишүүд болон дотнын хамтрагч ойлгож, хүлээн зөвшөөрөх, бүх талын дэмжлэг үзүүлэх нь чухал нөлөөтэйг мэргэжилтнүүд ойлгох ёстой.

Аюулгүй бэлгийн харилцаа: трансжендэр хүмүүс, ялангуяа залуу трансжендэр хүмүүс идэвхтэй бэлгийн амьдралтай байх нь маш энгийн зүйл учир БЗДХ/ДОХ-д өртөх эрсдэлтэй. Ялангуяа трансжендэр эмэгтэйчүүд болон трансжендэр гей эрчүүд ХДХВ-ийн халдвар авах эрсдэл өндөр байдаг боловч аюулгүй бэлгийн харилцаа (бэлгэвч хэрэглэх) бэлгийн замаар дамжих халдвараас хамгаалж чадна.

Гепатит вирусийн шинжилгээ болон дархлаажуулалт: трансжендэр эмэгтэйчүүд болон трансжендэр гей залуучуудын хувьд бэлгийн замаар элэгний хавдар үүсгэгч вирусээр халдварлах эрсдэл мөн өндөр байдаг. Энэ халдвар нь амь насанд аюултай нөхцөл байдал үүсгэх эсвэл элэгний өөрчлөлт, хавдар гэх мэт урт хугацаагаар явагдах, маш ноцтой өвчнүүдийг шалтгаан болдог.

Хүний папиллома вирус: шинж тэмдгийн хувьд хүчтэй илэрдэггүй ч бэлэг эрхтний үү, шулуун гэдэсний хавдар үүсгэдэг ноцтой вирус юм. Шулуун гэдсээр хавьталд ордог хүмүүст энэ вирусээр халдварлах магадлал хамгийн өндөр бөгөөд энэ талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх шаардлагатай юм (Allison RA, 10 Things Transgender Persons Should Discuss With Their Health Care Providers 2012).

1.4 ИНТЕРСЕКС БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Интерсекс гэж ямар хүнийг хэлэх вэ?

Интерсекс гэдэг нь эр эсвэл эм биологийн хүйсийн хэвшмэл ойлголтод багтдаггүй хүйсийн шинж тэмдэгтэй төрсөн хүнийг хэлдэг. Бэлгийн хромосомын түвшинд болон дааврын өөрчлөлт нь бэлгийн хоёрдогч шинж тэмдгээр илэрч буй хэв байдал учир анатомийн хувьд гаднаас нь хараад эрэгтэй эсвэл эмэгтэй гэж шууд хэлэх боломжгүй байдал юм. Интерсекс шинж тэмдэг нь хүний бие организмын ялгаатай байдлын энгийн, биологийн илрэл. Интерсекс байдал олон янзаар илэрч болно. Бүх интерсекс хүмүүсийн интерсекс шинж тэмдэг төрөхөд нь, эсвэл нялхад нь илэрдэггүй. Интерсекс байдал эхийн хэвлийд, анх төрөхөд, бэлгийн бойжилт эхлэхэд, эсвэл насанд хүрсний дараа илэрч болдог. Магад хүүхэдтэй болох гэж оролдох үед энэ байдлыг оношлох ч бий.

Интерсекс хүмүүс хүн амын хэдэн хувийг эзэлдэг вэ?

Хамгийн багаар баримжаалсан нь интерсекс хүн 2,000 хүнд нэг төрдөг гэсэн тоо байдаг ч илүү бодит тоо нь хүн амын 1,7% гэсэн тоо байдаг (Jones T. The needs of students with intersex variations. Sex Education. 2016 Mar 11;16(6):602- 18.).

Интерсекс хүмүүс ямар асуудалтай тулгардаг вэ?

Интерсекс хүмүүс бие эрхтний ялгаатай байдлаасаа үүдэн ялгаварлан гадуурхалт, ичгүүр, траума, хүний эрхийн олон зөрчилтэй тулгардаг. Үндсэн асуудлууд нь тухайн интерсекс хүнийг нялхад нь, эсвэл насанд хүрээгүй байхад нь “засаж”, аль нэг хүйст хамаатуулах эргэлт буцалтгүй бие эрхтнийг нь өөрчлөх хагалгаанд оруулах, их тунгаар дааврын эмчилгээ хийх мөн интерсекс ургийг “хүйсийн гаж хөгжил” хэмээн үзэн үр хөндүүлэх гэх мэт.

Интерсекс хүмүүст яагаад хагалгаа хийдэг вэ?

Интерсекс хүмүүсийг эр эсвэл эм биологийн хүйсийн хэм хэмжээнд нийцүүлэх зорилгоор бие эрхтнийх нь гаднах байдлыг засварлах нэрийдлээр ийм хагалгаануудыг хийдэг ба ихэнхдээ эрүүл мэндийн тулгамдсан шаардлагагүй байдаг. Ихэнхдээ хагалгаануудыг хүүхдийг нялхад нь хийдэг ба эцэг эхэд нь эдгээр хагалгаанаас үүдэн хүүхдийнх нь эрүүл мэндэд ирээдүйд үүсэх асуудлуудыг бүрэн тайлбарладаггүй. НҮБ болон олон улсын байгууллагууд эдгээр мэс заслыг тун хор хөнөөлтэйг хүлээн зөвшөөрсөн.

Интерсекс хүмүүс ямар хүйсийн баримжаатай байдаг вэ?

Интерсекс байдал нь биедээ амьдрах насан туршийн туршлага ба хүмүүс бие болон хүйсээ янз янзаар ойлгож, мэдрэх явц. Интерсекс хүмүүс бусдын л адил бүх төрлийн хүйсийн баримжаатай буюу өөрийн хүйсийг төрсөн хүйстэйгээ ижлээр тодорхойлдог сизжендэр ч, эсрэг болон өөрөөр тодорхойлдог трансжендэр интерсекс хүмүүс ч бий. Зарим интерсекс хүмүүсийн хүйсийн баримжаа гадна төрхтэй нь нийцэхгүй ч байж болно.

Интерсекс хүмүүс трансжендэр гэсэн үг үү?

Нэг үгээр хэлбэл үгүй. Интерсекс гэдэг нь биологийн, бие эрхтний л ялгаатай байдал (бэлгийн хромосом, гонад, даавраас үүдэлтэй бэлгийн эрхтнүүдийн хөгжил гэх мэт). Харин трансжендэр гэдэг бол өөрийн хүйсийг төрөхөд өгөгдсөн хүйснээс өөрөөр, эсрэгээр мэдэрч тодорхойлж буй асуудал (бэлгийн хромосом, гонад, даавартай холбоогүй).

Интерсекс хүмүүс гей, лесбиян эсвэл куййр байж болох уу?

Интерсекс хүн бүр өөр. Зарим интерсекс хүн лесбиян, гей, асексуал байхад ихэнх нь стрэйт. Интерсекс хүмүүс ЛГБТИК+ олон нийттэй нэг талаараа ижил нь аль аль нь хэвшмэл хүйс ба нийгмийн хүйсийн хэм хэмжээний гадна байдаг явдал. Интерсекс хүмүүс бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаагаараа биш, ЛГБТИК+ олон нийттэй ижил үндэстэй ялгаварлан гадуурхалтад өртдөг утгаараа ЛГБТИК+ олон нийтэд багтдаг.

Кэйс

“Би эрэгтэй байхаар заяагдсан ч интерсекс байдлаас минь болж 5 настайд минь хагалгаа хийж эмэгтэй хүүхэд хэмээн бүртгэсэн. Тиймээс 29 насандаа дахин эрэгтэй гэдгээ илэрхийлж, эрэгтэй гэдгээрээ амьдарч эхэлсэн.”

1.5 ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрүүл мэндийн орчин

Эрүүлмэндээ хамгаалуулах, эрүүлмэндийн дээд зэргийн үйлчилгээ хүртэх эрх ЛГБТИК+ хүмүүсийн хувьд нэлээд хаалттай, ялангуяа лесбиян болон бисексуал эмэгтэйчүүд, трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн асуудал орхигдож байна. Ихэнх эмч нар ЛГБТИК+ хүмүүстэй яаж харилцахаа мэддэггүй. Тэд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа нь төрөлхийн мөн чанар буюу үргэлж ийм мэдрэмжтэй байсныг ойлгохгүй байх тохиолдол байдаг. Учир нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хувьд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй холбоотой нарийн мэдлэг маш дутмаг байна. Монголд одоогийн байдлаар ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдлыг бүрэн ойлгож, хэрэгцээнд нь нийцсэн тусламж үзүүлж чадах эмч төдийлөн байхгүйгээс ЛГБТИК+ хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн асуудал хязгаарлагдмал байна. Гей, бисексуал эсвэл ЭБЭ залуучуудын БЗДХ-ын тухай мэдээлэл болон үйлчилгээг дан бэлгийн эрүүл мэндийн чиглэлээр дагнан ажиллаж буй ТББ-ууд, Глобал сан, НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрөөс санхүүжсэн үйл ажиллагаагаар дамжуулан хүргэдэг боловч бусад ЛГБТИК+ олон нийтийн өмнө тулгарч буй архи, тамхины зохисгүй хэрэглээ, бэлгийн цөөнх эмэгтэйчүүд болон трансжендэр хүмүүсийн халдварт бус өвчин, эмгэг, эмзэг байдлын тухай, мөн хүйсийн шилжилттэй холбоотой салбарын мэдлэг, бодлого, зохицуулалт огт байхгүй байгаа нь эдгээр хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж чадахгүй, мөн эмнэлгийн буруу, зохисгүй үйлдлээс хамгаалагдах эрх нь хаагдмал байгааг харуулж байна (*ЛГБТ Төв, Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт, 2013*). Түүнчлэн сүүлийн үед нийгэм даяар хөндөгдөн яригдаж буй сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар бэлгийн болон хүйсийн цөөнх хүмүүст ээлтэй тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байсаар байна.

Боловсролын орчин

Бүх шатны боловсролын орчин бол хамгийн их ялгаварлан гадуурхалттай орчин гэдгийг өсвөр насныхны болон залуу ЛГБТИ хүмүүсийн дунд хийсэн судалгаанууд харуулдаг (*ЛГБТ Төв, ЛГБТ хүүхдүүдийн дунд оролцооны аргаар хийсэн судалгаа 2016*). Боловсролын орчинд ЛГБТ хүмүүс, тэр тусмаа трансжендэр өсвөр үеийнхэн хамгийн их ялгаварлан гадуурхалтад өртөж байна. Үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлт болон боловсролын салбар дахь сурган хүмүүжүүлэгчдийн ойлголт мэдлэггүй байдлаас ЛГБТ хүмүүсийн сурч боловсрох нөхцөлд хүндрэл бэрхшээл тулгарч байна. Ихэнх ЛГБТ хүүхэд, залуус, өсвөр насныхан үг хэлээр доромжлуулах, бие махбодын хүчирхийлэлд

өртөх, эрүүл аюулгүй сургалтын орчноор хангагдахгүй байх, улмаар сургууль завсардах, сэтгэл санааны гүн хямралд орох, өөртөө эрсдэл үүсгэх, амиа хорлох, амь насаа алдах зэрэг олон төрлийн эрсдэлд өртөж, улмаар тэдний сурч боловсрох, ирээдүйд нийгмийн бүтээлч идэвхтэй хэсэг болох эрх нь зөрчигдөж байна. Ангийн сурагчид, сургуулийн бусад сурагчид, гэр бүлийнхэн болон хөршүүд нь тэднийг шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгаа нь тэдний сурч боловсрох болон бусад эрхүүдийг нь хязгаарлаж байна (*“Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Бэлгийн цөөнхийн хүүхэд, залуусын сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга & дүн шинжилгээ 2011 он*). Боловсролын тогтолцоонд, ЕБС-ийн хөтөлбөрт агуулгыг суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэхийн тулд бага ангиас эхлүүлэн боломжтой хичээл бүрт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай мэдээллийг шууд болон шууд бус байдлаар суулгаж өгөх, багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар заах, ЕБС-ийн хөтөлбөрт БЧБХБИ (бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл)-ийн тухай мэдээлэл ямар түвшинд, хэрхэн заагдаж буйг хянах тогтолцоотой болох, боловсролын тогтолцоонд ЛГБТИК+ багш болон хүүхэд сурагчдыг ялгаварлахгүй байх салбарын бодлого, дүрэм журамтай болохоос нааш ЛГБТИК+ хүүхэд болон залуус таатай боловсролын орчинд сурах эрхээ бүрэн эдэлж чадахгүй гэсэн дүгнэлтийг хийх ёстой (*ЛГБТ Төв, Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт, 2013*).

Энэхүү эш татсан судалгаануудаас хойш 10 гаруй жил өнгөрчээ. Хэдийгээр энэ хугацаанд боловсролын орчинд бага багаар эерэг өөрчлөлтүүд бий болж байгаа боловч тийм ч хангалттай биш байгаа нь 2023 онд Бүх нийт боловсролын төлөө! иргэний нийгмийн үндэсний эвсэл болон ЛГБТ Төв НҮТББ-аас хийсэн “Монголын сургуульд транс* сурагч байх нь” кэйс цуглуулгын аргаар хийсэн чанарын судалгаанаас тод харагдаж байв. Ялангуяа ерөнхий боловсролын сургуульд ялгаварлан гадуурхалтад өртсөний улмаас өсвөр насандаа сэтгэл зүйн гэмтэл авах, цаашлаад энэ нь амьдралын чанар, сайн сайхан байдал, ертөнцийг үзэх үзэлд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна. Эсрэгээрээ, бэлгийн болон хүйсийн цөөнх байдлыг нь эерэгээр ойлгож, хүлээж авдаг орчинд сурах сэдэл өндөр, идэвх чармайлттай байна.

Гэр бүлийн орчин

ЛГБТИК+ хүмүүсийн өдөр тутмын ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэлд өртөх асуудал гэр бүлийн орчноос эхэлдэг. Гэр бүлийн хүчирхийлэлд бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэл аль аль нь хамаарна. Бэлгийн мөн чанарын тухай

болон хүйсийн хэм хэмжээний талаарх нийгмийн хэвшмэл, буруу ойлголтоос үүдэн эцэг эх асран хамгаалагчид нь өөрийн хүүхдийг ЛГБТИК+ гэдгийг мэдэхээсээ ч өмнө өөрсдөө ухамсарлалгүйгээр эдгээр ойлголтуудад нийцүүлэн амьдрахыг ЛГБТИК+ хүүхдүүдэд тулган шаардсанаар сэтгэл зүйн хувьд маш хүнд дарамтыг үүсгэдэг. Тэр тусмаа ЛГБ буюу бэлгийн цөөнх хүүхдүүдийн бэлгийн бойжилт явагдах, трансжендэр хүүхдүүдийн өөрийн хүйсээ илэрхийлж эхлэхээс эдгээр дарамт илүү хүчтэй болдог. ЛГБТИК+ хүүхдүүд ихэвчлэн нийгмийн дарамт, ялгаварлан гадуурхалтаас болж гэр бүлийнхэндээ өөрсдийгөө илэрхийлэхээс айдаг. Хэрэв гэр бүлийнхэн нь ЛГБТИК+ гэдгийг нь олж мэдсэн тохиолдолд бие махбод, сэтгэлзүйн хүчирхийлэл дарамт учруулах, гэрээсээ хөөх, хорьж цагдах, нийгмээс тусгаарлах гэх мэт гэмт хэргийн шинж чанартай үйлдлүүдийг хийж эхэлдэг. Мөн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийлэл нь өөрчлөгддөг зүйл гэсэн шинжлэх ухаанч бус үзлээс болж сэтгэцийн болон сэтгэл заслын олон төрлийн эмчилгээнд хамруулах гэж оролдох, шашны итгэл үнэмшлээр лам, бөө, сүмийн үйлчилгээ авах, ховс, тарнийн арга хэрэглэх гэх мэтээр хүний эрхэд нь ноцтой халддаг. Эдгээр үйлдэл нь ЛГБТИК+ хүмүүсийн дараах эрхүүдэд шууд болон шууд бус байдлаар халддаг: үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүртэх, эвлэлдэн нэгдэх гэх мэт (*ЛГБТ Төв, Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт, 2013*).

Ажлын орчин, нөхцөл

Хэдийгээр 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 6 дугаар зүйлд Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох дотроо бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл хэмээн тусган өгсөн байдаг ч хэрэгжилт муутай, хууль таниулах ажил дутмагийн улмаас ЛГБТИК+ хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх эрх нь хангагдахгүй байна.

ЛГБТИК+ гэдгээ мэдэгдвэл ажилд авдаггүй учир хүмүүс ЛГБТИК+ байдлаа нуух шаардлагатай тулгардаг. Нуугаад ажилд орлоо гэхэд дараа нь ЛГБТИК+ гэдгээ илэрхийлэх, эсвэл өөрөө хүсээгүй ч ЛГБТИК+ байдлаа мэдэгдэх үед ажлын байранд нь ялгаварлан гадуурхаж, чөлөөтэй ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болох, улмаар ажлаасаа гарах шаардлага тулгардаг. ЛГБТИК+ хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх эрх зөрчигдөөд зогсохгүй, энэ эрхтэй харилцан хамааралтай оршдог шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх, шаардлага хангахуйц орон байртай байх, нийгэм, соёлын амьдралд оролцох эрхүүд нь шууд зөрчигддөг байна. Түүнчлэн олон нийтийн, соёл, улс төрийн амьдралд оролцох эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн үг юм. (*ЛГБТ Төв, Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн*

хэрэгжилт, 2013)

2022 онд ЛГБТ Төв НҮТББ нь ReportOUT байгууллагатай хамтран Монгол дахь бэлгийн болон хүйсийн цөөнх олон нийтийн хүний эрхийн зөрчил, хөгжлийн хэрэгцээг судалсан судалгааны багт орж ажилласан бөгөөд энэхүү судалгаанд 18-45 насны, хөдөлмөр эрхэлж байсан 238 монгол ЛГБТИК+ хүн хамрагдсан. (ReportOUT. (2023) OUT in Mongolia: The Lived Experiences of LGBTQI Mongolians. Gateshead: ReportOUT)



Судалгааны үр дүн




8/10

өөрийгөө гэр бүл, ажил сургууль, эмнэлгийн үйлчилгээний үед ЛГБТИК+ гэдгээ нууж амьдардаг

Цалингийн доод хэмжээ 420k ₮-өөс доогуур орлоготой (шинэ хуулиас өмнө)




Ялгаварлан гадуурхалтыг салбараар



Монголд ЛГБТИК+ хүн амьдрах аюултай



ЛГБТИК+ хүмүүс тулгардаг бие махбодын хүчирхийлэл



70%

ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг хууль сахиулагчдын зүгээс үзүүлэх ялгаварлал түгээмэл байдаг гэж үзсэн



Шинэ хуулиуд & аюулгүй байдал



Монголд ЛГБТИК+ хүмүүст ээлтэй тусламж, үйлчилгээ хомс байна



ХОЁР. БЭЛГИЙН ЦӨӨНХ ХҮМҮҮСТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ПРАКТИК

АНУ-ын Үндэсний нийгмийн ажилтнуудын холбооны Ёс зүйн дүрэмд бэлгийн чиг баримжааг оруулдаг ч ЛГБТИК+ хүмүүстэй ажиллах заавар ба мэдээ, мэдээллийг оруулаагүй байдаг нь нийгмийн ажлын шинжлэх ухааны хүрээнд судлагддаг асуудлууд ЛГБТИК+ хүмүүсийн хувьд бусад хүн амынхаас онцлог хэдий ч мэргэжлийн ёс зүй, агуулгыг бүхэлд нь шинээр үүсгэх түвшний асуудал биш гэдгийг хүлээн зөвшөөрдөгтэй холбоотой.

Бэлгийн цөөнх хүмүүстэй ажиллах, тусламж үзүүлэх асуудлаар үүсдэг хэрэг- цээ нь нийгмийн ажилтнуудын хандлага, мэдлэг ба ур чадвараас ихээхэн хамаарна. Нэгэнтээ ЛГБТИК+ хүмүүсийн онцлог асуудал бусад хүн амынхаас үнэмлэхүй ялгаатай байдаггүй, анхаарах онцлогууд л байдаг тул нийгмийн ажилтнууд өдөр тутмынхаа үйл ажиллагаанд дагах, мөрдөх ёстой хэм хэмжээ ба загвар туршлагыг өөрсдийн ажлын хүрээнд үүсгэж байдаг. Одоогоор ялангуяа шинэ тутам мэргэжилтнүүдийн өмнө тулгамдаж буй асуудлууд нь: ЛГБТИК+ хүмүүст ямар хэм хэмжээ, загвараар тусламж үзүүлэх вэ? ЛГБТИК+ хүмүүстэй харилцахдаа ямар хандлага, мэдлэг ба ур чадвартай байх ёстой вэ?

ЛГБТИК+ хүмүүстэй ажиллах стандартыг “GAP” буюу ижил хүйсийн, эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааг нь хүлээн зөвшөөрч, дэмжин ажиллах практикийн (Appleby and Anastas, 1998) загвараас харж болох юм. ЛГБ хүмүүс бүрэн хангалттай, өөртөө хэрэгцээтэй мэдээллийг авч чаддаггүй ба гетеросексуал хүмүүстэй харьцуулахад гей, лесбиян хүмүүс сэтгэл зүйчдэд илүү ханддаг аж. Appleby, Anastas нар нь ЛГБ хүмүүст хамаарах 6 үндсэн сэдвийг гаргаж ирсэн байна. Энэ сэдвүүд нь нийгмийн ажилтны хандлага, мэдлэг ба ур чадвартай шууд холбоотой.

Хандлага

1. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа нь хэвийн бөгөөд хүний салшгүй мөн чанар.
2. ЛГБТИК+ хүмүүс өөрсдийгөө нээлттэй ба эерэгээр илэрхийлэх нь өөрийнхөө мөн чанарыг илэрхийлж байна гэсэн үг.

Мэдлэг

3. Тусламж үзүүлж буй ямар ч үйлчлүүлэгчээ шууд гетеросексуал хэмээн урьдчилан таамаглах ёсгүй.

4. Өөрийн бэлгийн чиг баримжаагаа нээлттэй илэрхийлэх эсэх нь хүн бүрээс шалтгаалан ялгаатай байдаг.

Ур чадвар

5. Тусламж үзүүлж байгаа ажилтнууд өөрсдийн гетеросексуал хэвшмэл ойлголт ба гомофоби байдлаа анхаарч ажиллах ёстой.
6. Туслалцаа авч буй үйлчлүүлэгчийн байгаа байдлыг үнэлэхдээ хэзээ ч гетеросексуал хэмээн урьдчилан таамаглах ёсгүй.

“GAP” буюу ижил хүйсийн, эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааг нь хүлээн зөвшөөрч, дэмжин ажиллах практикийн (Appleby & Anastas, 1998) зарчмууд нь зарим талаараа феминист онол, практиктай адилхан байдаг. Үүний гол зарчим нь туслалцаа авч буй үйлчлүүлэгчдийг хэн гэдгээс үл хамааран ямагт хүлээн зөвшөөрөх, хүн гэдгээр нь авч үзэх, эрхэм чанарыг нь хүндэтгэхэд оршдог. Энэхүү практик нь ямар ч бие ба сэтгэцийн эрүүл мэндийг ханган хамгаалах, нийгмийн ажилд ашиглах боломжтой ба хувь хүн, хос, гэр бүл, бүлэг хүмүүст ч хамааралтай юм (Van Den Bergh & Crisp, 2004, х.226).

2.1 БЭЛГИЙН ЦӨӨНХ ОЛОН НИЙТТЭЙ АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ХАНДЛАГА

Хандлага

Нийгмийн ажилтан бусдыг ялгаварлан гадуурхахгүйн тулд, тэр тусмаа бэлгийн цөөнх болон хүйсийн цөөнх хүмүүстэй ажиллахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Өөрийгөө ярилцаж буй хүнийхээ оронд тавьж үзэх буюу тэр хүний бэлгийн чиг баримжааны мэдлэг, нөлөө ба туршлагыг тунгааж үзэх.
2. Өмнө нь уулзаж байсан ЛГБТИК+ хувь хүмүүсийн оронд өөрийгөө тавьж үзэх (хувийн болон мэргэжлийн түвшинд).
3. ЛГБТИК+ хүмүүст нийгмээс ирдэг эерэг ба сөрөг хандлагыг дүгнэх.
4. Өөрийн үйлдэл, үг, биеийн өгүүлэмжийг ухамсрын, зан төлөвийн ба үйл хөдлөлийн түвшинд анхаарч, гомофоби эсвэл гетеросексизмыг хөхүүлж байгаа эсэхээ анхаарах.
5. Хувьдаа болон мэргэжлийн түвшинд ЛГБТИК+ соёл ба хувь хүмүүсийг илүү ойлгох тал дээр ажиллах.

Дээр дурдагдаж буй зүйлсийн үндсэн ойлголт нь нийгмийн ажилтнуудад байж болзошгүй өөрийн гомофоби ба гетеросексист

үзлийг анхаарах, ийм төрлийн алдаа гаргахгүйд оршино. Өмнө нь ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааг анагаахын үүднээс үндэслэлгүйгээр эмгэг хэмээн үзэх үеэс бүрэлдэн тогтсон ойлголт бол хүмүүс зөвхөн гетеросексуал байдаг ба энэ л ганц хэвийн бэлгийн чиг баримжаа хэмээн үздэг байсанд зарим нийгмийн ажлын болон сэтгэл зүйн мэргэжилтнүүд итгэсээр байдаг, ухамсаргүйгээр энэхүү итгэл үнэмшлээ өөрийн хандлагаар илэрхийлдэг. Тиймээс салбарын мэргэжилтэн аль болох шинжлэх ухааны мэдээлэл, судалгаанд үндэслэсэн мэргэжлийн ёс зүйгээсээ үл хазайн, бусад “-изм” шиг расизм (арьс өнгөөр ялгаварлан гадуурхах), сексизм (хүйсээр ялгаварлан гадуурхах), ангич үзэл (нийгмийн ангид харьяалагдах статусаар ялгаварлан гадуурхах), ageism (насаар ялгаварлан гадуурхах)-тай адил өөрийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд ялгаварлан гадуурхахгүй байх, гомофоби эсвэл гетеросексизмийг илэрхийлэхгүй байх нь тун чухал. Жишээ нь:

- Гей хүнийг бэлгийн чиг баримжаатайгаа холбоотой ямарваа зүйл хэлэхэд ямар нэгэн байдлаар шууд болон шууд бус байдлаар дургүйцэх;
- Хэн нэгэн ЛГБТИК+ асуудлыг ярихад сэдвийг идэвхтэй солих, үл ойшоох;
- Асуудлыг тайлбарлахдаа бэлгийн чиг баримжааг хэт чухал мэт, эсвэл ямар ч хамааралгүй мэт ярих;
- Туслалцаа авч буй хүн гей эсвэл лесбиян гэдгээ илэрхийлсэн ч “ийм үе байдаг”, “бэлгийн чиг баримжаа чинь өөрчлөгдөнө” гэж хэлэх, илэрхийлэхэд;
- Бэлгийн цөөнх хүмүүс хоёрдогч зэргийн, чухал бус хүмүүс мэт ярих;
- Ямарваа мэргэжлийн дүгнэлт хийхдээ тухайн хүний зөвхөн бэлгийн чиг баримжааг л үндэслэх;
- Хүний бэлгийн чиг баримжааг патологи буюу сэтгэцийн эмгэг гэж үзэх (Van Den Bergh & Crisp, 2004, х.227).

Мэдлэг

Нэр томьёо: нийгмийн ажилтнууд ЛГБТИК+ хүмүүс өөрсдийгөө хэрхэн тодорхойлдгийг мэдэх, өөрсдийгөө тодорхойлдог үг хэллэгийг нь хэрэглэх ёстой. Фелин (1998) “Зөв үг хэллэгийг ашиглах нь гетеронорматив (буюу зөвхөн эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаа нь цор байдаг, байх ёстой хэм хэмжээ гэж үзэх үзэл) хэвшмэл ойлголтыг даамжруулахгүй, мөн хэн нэгнийг доромжлохгүй байх зорилготой” гэж тодорхойлсон байдаг.

ЛГБТИК+ хүмүүсийн дунд маш олон үг хэллэг байдаг ч нийгмийн

ажилтан нь тухайн хүнийхээ хүслээр үг хэллэгийг ашиглах ёстой. Бэлгийн цөөнх хүмүүс өөрсдийгөө тодорхойлж байгаа байдал нь тэдний нас ба соёлын онцлогтой холбоотой байдаг. Жишээ нь: ахимаг насны эрэгтэй хүн өөрийгөө “гомосексуал” (энэ үгийг одоо үед огт хэрэглэгдэггүй болохыг анхаарна уу, ялангуяа монгол хэл дээр) гэж хэлдэг бол залуу хүн өөрийгөө “күйр” хэмээн хэлдэг байж болно. Зарим эмэгтэйчүүд өөрийгөө “гей” гэж хэлдэг бол зарим нь энэ үгийг доромж үг гэж үздэг учир “лесбиян” гэж дуудуулахыг хүсдэг. Гэвч нийгмийн ажилтнууд бэлгийн цөөнхийн тухай ярихдаа бэлгийн чиг баримжаа гэж хэлэх хэрэгтэй бөгөөд бэлгийн чиг хандлага гэж хэлдэггүй болохыг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн “гей”, “лесбиян” ба “бисексуал” гэх нэр томъёонуудыг ашигладаг ба “гомосексуал” гэдэг үгнээс бүрмөсөн татгалзах хэрэгтэй.

ЛГБТИК+хүмүүсийн бэлгийн чиг баримжаа гетеросексуал хүмүүстэй адил төрөлхийн учир бэлгийн чиг баримжаа гэдэг нэр томъёог ашиглах нь зөв. Ямар нэр томъёог ашиглахаа мэдэхгүй байгаа бол нийгмийн ажилтнууд тухайн үйлчлүүлэгчээсээ лавлах хэрэгтэй. Нийгмийн ажилтнууд ЛГБТИК+ хүмүүсийн дотнын хүний талаар ярихдаа нөхөр эсвэл эхнэр гэх үг ашигласнаас хамтрагч гэдэг үгийг оронд нь ашиглаж, ямар нэг хүйс заахгүйгээр ярьж занших нь зүйтэй. Ярихдаа хүйс заахгүйгээр ярих нь зөв бөгөөд энэхүү зарчмыг ямар нэгэн материал бөглүүлэх эсвэл ашиглахдаа багтаасан байх шаардлагатай.

Гомофоби, гетеросексизмын үг хэллэг ашиглахгүй байхын тулд бодож ба ярьж буй зүйлсээ анхаарах хэрэгтэй байдаг. Өмнөх хэсгүүд дээр дурдсанаар ЛГБТИК+ хүмүүс өөрсдөө гомофоби ба гетеросексизмын үг хэллэгийг хэлэх эсвэл дотроо өөрөө өөртэйгөө зөрчилдсөн шинж чанарыг илэрхийлэх магадлалтай байдаг. Эдгээр хүчин зүйлс нь ЛГБТИК+ хүн цаашдаа өөртөө итгэх итгэл буурах, сэтгэлээр гутрах, сандрах ба тогтворгүй байх сэтгэцийн өвчин болон архи, тамхины зохисгүй хэрэглээний шалтгаануудын хэсэг болдог (Van Den Bergh & Crisp, 2004, х. 228-229).

Дарамт, дээрэлхэлт ба хүчирхийлэл: ЛГБТИК+ хүмүүс нь өөрсдийг нь хүлээн зөвшөөрдөггүй болон дэмждэггүй нийгэмд амьдарсаар ирсэн. Ихэнхдээ хүмүүс ЛГБТИК+ хүмүүсийг салбар институцийн түвшинд ялгаварлан гадуурхагддаг гэж боддог. Жишээ нь: хууль тогтоомжийн хүрээнд эрх нь хамгаалагдаагүй, ажилд орох, байртай болох гэх мэт. Харин нийгмийн ажилтнууд ЛГБТИК+ хүмүүс өдөр тутмынхаа амьдралдаа ямар нэгэн байдлаар байнга ялгаварлан гадуурхагддаг ба үүнээс үүдэн олон асуудал үүсдэг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд: хамтрагчид олон нийтийн газар өөрсдийгөө нээлттэй илэрхийлэх, өөрийн бэлгийн чиг баримжааг гэр бүл болон найз нөхөд, ажлын хамт олондоо хэлэх, ЛГБ хувь хүн бэлгийн чиг баримжаанаасаа болоод өөрсдийнхөө туршлагаас ярих боломжгүй байх.

Үзэн ядалтын гэмт хэрэг нь хамгийн хүнд төрлийн гэмт хэргүүдийн нэг юм. Маш олон ЛГБТИК+ хүмүүс хүчирхийлэлд өртсөн тухайгаа цагдаагийн газарт мэдэгддэггүй нь өөрийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээсээ болоод давхар ялгаварлан гадуурхагдахаас айдагтай холбоотой юм. АНУ-ын 2001 онд гарсан судалгаанд нийт гэмт хэргүүдийн 14% нь бэлгийн чиг баримжаатай холбоотой гэмт хэргүүд байсан байна. Эдгээр гэмт хэргүүдийн онц ноцтой байдал нь харгис байдал юм. Terndrup (2002) “Ихэнх хүмүүс зодуулж эсвэл буудуулдаг бол ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй гэмт хэргүүдийг харахад ЛГБТИК+ хүмүүс нь нүүрний бүх ясаа хугалуулсан эсвэл 30 удаа хутгалуулсан байна” гэж дүгнэжээ.

Нийгмийн ухааны онол: нийгмийн ухааны онолууд нь бэлгийн цөөнхтэй хэрхэн ажиллах талаар мэдээлэл хүргэх зорилготой байх хэрэгтэй. Сэтгэцтэй холбоотой, шинжлэх ухаанч бус, хоцрогдсон нь батлагдсан уламжлалт онолууд ЛГБТИК+ хүмүүсийг патологийн үүднээс тайлбарладаг байсан. Дээрээс нь ЛГБТИК+ хүмүүсийн “coming out” буюу өөрсдийн бэлгийн болон хүйсийн мөн чанарыг илэрхийлэх процесс нь тухайн хүний амьдралын хүндрэл, асуудлыг задалж үзэхэд онолын үндэс болж байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй. ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдлыг ойлгоход тэднийг яагаад “coming out” хийхээсээ айдгийг, тэр айдсаасаа болж бэлгийн чиг баримжаагаа өөрчлөх зорилгоор сэтгэл зүйчид хандах тохиолдол байдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь сэтгэл зүйч ч бай, нийгмийн ажилтан ч бай, өөрийн гомофоби, гетеросексист үзлээ ойлгох, нийгэм, соёлын тогтолцооны хувьд ЛГБТИК+ хүмүүс хохирогч болох магадлалтай учир анхааралдаа авч ажиллах хэрэгтэйг хэлж байгаа билээ.

Олон нийтийн мэдээлэл: ЛГБТИК+ хүнийг өөр байгууллага руу шилжүүлэхдээ эсвэл тэдэнд өөр байгууллагын тухай мэдээлэл өгөхдөө тухайн байгууллагын дүрэм журмыг судалж, ЛГБТИК+ хүмүүст ээлтэй орчин бүрдсэн газар эсэхийг шалгах хэрэгтэй. Crisp, DiNitto нар нь дараах хүчин зүйлсийг харгалзан үзсэнээр ЛГБТИК+ хүмүүсийг өөр үйлчилгээ үзүүлэгч рүү шилжүүлэхийг шийднэ гэсэн байдаг. Үүнд:

1. Ажилтнууд ба үйлчлүүлэгч нарыг бэлгийн чиг баримжаагаар ялгавар-лан гадуурхахгүй гэсэн заалттай байх;
2. Тухайн байгууллагын ажилтнууд ЛГБТИК+ хүмүүстэй хэрхэн харилцах талаар сургалт авсан эсэх;

3. Тухайн байгууллагад нээлттэй ЛГБТИК+ хүмүүс ажилладаг эсэх;
4. ЛГБТИК+ хүмүүсийг засах эсвэл өөрчлөх гэсэн зүй бус явдлыг эсэргүүцдэг эсэх (Van Den Bergh & Crisp, 2004, х. 230-231);

Ур чадвар

ЛГБ хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэх: Энэ нь олон зүйлийн үр дүнд бүрдэх үйл явц юм. Нэгд, нийгмийн ажилтны ажлын газар ЛГБТИК+ хүмүүст зориулсан төрөл бүрийн гарын авлага, ном, сониныг нүдэнд ил газар тавих. Эдгээрийг ил тавьснаараа ЛГБТИК+ хүмүүст нээлттэй орчныг бүрдүүлж, тэдэнд бэлгийн чиг баримжааны тухай ярих боломжийг олгож байгаа гэсэн үг юм. Ном, товхимол, мэдээллийн хуудасны сэдвүүд нь гей эцэг эх байх нь, “coming out”, хамтрагчтайгаа амьдрах ба хууль ёсны эрх гэх мэт (зөвхөн эдгээр сэдвүүдээр хязгаарлагдахгүйг санах хэрэгтэй) байж болно. Дэлхийн хоёрдугаар дайны үед ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийг еврейчүүдийн нэгэн адил хоморголон устгасныг санах, дахин тийм зүйлийг давтуулахгүйн бэлэг тэмдэг болсон урвуугаа харсан ягаан гурвалжин дүрсийг өлгөх, эсвэл дэлхийн даяар ЛГБТИК+ хүмүүсийн бахархлын бэлэг тэмдэг болсон солонгын тугийг тавьж, ЛГБТИК+ хүний эрхийг дэмждэг гэдгээ үзүүлэх боломжтой.

Тусламж авч буй хүнд бэлгийн чиг баримжаанаас өөр асуудлаар бэрхшээл тулгарч буйд нь туслалцаа үзүүлэх: нийгмийн ажилтнууд аливаа хүний бэлгийн чиг баримжаа дээр суурилан дүгнэлт хийх бус, харин тэр хүнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд оршино.

ЛГБТИК+ хүний асуудлыг тэр хүний үүднээс харж үзэх: жишээ нь ЛГБ хүмүүс бэлгийн чиг баримжаанаасаа болон ямар нэгэн сөрөг нөхцөл байдалтай тулгарсан бол архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх эрсдэл ихэсдэг. Өөрөөсөө ичих ба өөртөө гутрах нь сэтгэл гутрал ба сандрах сэтгэцийн өвчинд хүргэх магадлалтай. Эдгээртэй тулгарсан хүмүүс нь мансууруулах бодис ба согтууруулах ундааг хэрэглэснээр зовлон шаналлаа мартаж гэж оролддог.

Бэлгийн чиг баримжаанаасаа болж шаналж буй хүмүүст туслалцаа үзүүлэх: ЛГБ хүмүүст зориулсан ээлтэй ба аюулгүй орчин бүрдүүлсний үндсэн дээр ЛГБ хүмүүс өөрийгөө бүрэн илэрхийлж чадах юм. Зөв ба эерэг мэдээллийг хүргэснээр тусламж авч байгаа хүн нь өөртөө итгэлтэйгээр зөв шийдвэр гаргах замаа тодорхойлох боломжтой болох юм.

Хувь хүнд илэрч болзошгүй гомофобийг олж харах: зарим ЛГБТИК+ хүмүүс ба бэлгийн чиг баримжаандаа эргэлздэг хүмүүс

өөрөө гомофоби үзэлтэй байж болзошгүй юм. Энэ нь нийгмийн ажилтнуудаас тусламж хүсэхэд өөрсдөд нь саад болдог. Хамгийн гол нь гомофоби үзлээ тухайн ЛГБТ хүн өөрөө анзаарахгүй эсвэл мэдэхгүй байх боломжтой. Энэ байдлыг олж харахын тулд тусламж авч буй хүнийхээ ярьсан зүйлийг анхааралтай сонсох хэрэгтэй.

Тусламж авч буй хүн нь өөрийгөө хэр нээлттэй илэрхийлдэг тухай олж мэдэх: ЛГБТИК+ хүмүүстэй ажилладаг нийгмийн ажилтанд тухайн хүн дургүйцэж байгаа эсэхийг харах. Хувь хүн нь магадгүй ЛГБТИК+ хүмүүст тусламж үзүүлдэг нийгмийн ажилтан дээр очих хүсэлгүй байх магадлалтай. Харин зарим хүмүүс нь дуртайгаар ЛГБТИК+ хүмүүст тусламж өгдөг нийгмийн ажилтантай уулзах бөгөөд бүхий л төрлийн мэдээллийг авахыг хүсэх болно.

Шаардлагатай тохиолдолд тусламж авч буй хүний ойр дотнын хүнийг үйл явцад хамруулах: ЛГБТИК+ хүмүүс маш олон төрлийн стресс ба дарамтад өртдөг ба үүнийг даван туулахад тухайн хүний гэр бүл, дотнын хамтрагч чухал үүрэгтэй. Хууль, эрх зүйн үүднээс гэр бүлийг нь хүлээн зөвшөөрөөгүй байдал ба гэр бүлээ хангах санхүүгийн бололцоогүй гэх мэт олон төрлийн хүчин зүйлс хувь хүмүүсийн харилцаанд болон нийгмийн харилцаанд нь нөлөөлж байдаг. Иймд нийгмийн ажилтнууд нь гей ба лесбиян харилцаанд байгаа хосуудын ялгаатай байдал, сул тал, давуу тал ба харилцан хамааралтай байдлыг ойлгох хэрэгтэй.

ЛГБТИК хүмүүсийн тухай ойлголт өгөх сургалт ба боловсролыг дээшлүүлэх шат шатны арга хэмжээнд байнга оролцох, мэдлэгээ дээшлүүлэх: ЛГБТИК+ хүмүүсийн талаарх мэдлэгээ сайжруулах чин хүсэлтэй байх ба цаг гаргах нь чухал. Илүү мэдээлэл олж авснаараа ЛГБТИК+ хүмүүст хүргэх үйлчилгээ нь илүү хүртээмжтэй, хэрэгцээнд нь нийцсэн болох юм (Van Den Bergh & Crisp, 2004, х. 232-234).

Боловсрол

Хичээлийн хүрээнд оюутнуудаар дүрийн тоглолт хийлгэх, ЛГБТИК+ хүмүүс шиг “coming out” хийх (гэр бүл, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүстээ хэлж байгаа мэт); боловсролын орчинд ялгаварлан гадуурхагдах, эмч ба эмнэлгийн ажилтнуудаас болоод эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжгүй байх, бэлгийн чиг баримжаанаасаа болж ямар нэгэн тусламж авч болох газраас хөөгдөх гэх мэт нөхцөлийг жишээгээр тоглуулж болно. Ийм төрлийн дасгалууд нь оюутнуудад бодит амьдрал дээр гардаг ялгаварлан гадуурхалт ба ЛГБТИК+ хүний асуудлыг ойлгоход дөхөм болно. Харин том хэмжээний семинар лекцийн үеэр ЛГБТИК+ хүмүүст ээлтэй байгууллагын арга барил, аюулгүй, бүгдийг тэгш хамруулсан, ээлтэй ажлын байрны нөхцөл байдлыг судлах боломжийг нь олгох хэрэгтэй.

Оюутнуудад ЛГБТИК+ хүмүүстэй харилцах, тусламж үзүүлэх арга зүйг боловсруулах даалгаврыг хичээлийн хөтөлбөрт багтааснаар бэлгийнцөөнх хүмүүстэй ажиллах арга барилд суралцах хөшүүрэг болно (Van Den Bergh & Crisp, 2004, ө. 235-236).

Эх сурвалж:

Appleby, G.A., & Anastas, J.W. (1998). Not just a passing phase: Social work with gay, lesbian and bisexual people. New York: Columbia University Press.

Crisp, C., & DiNitto, D.M. (in press). Substance abuse treatment with sexual minorities. In C.A McNeece & D. M. Nitto (Eds.), Chemical dependency; A systems Approach (3rd ed.). Boston: Allyn & Bacon.

Van Den Bergh N, & Crisp C. 2014. Defining Culturally Competent Practice with Sexual Minorities: Implications for Social Work Education and Practice. Journal of Social Work Education 40(2): 221-238

2.2 ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Нийгмийн ажлын ангийн оюутан багшаасаа “Та яагаад уламжлалт гэр бүлтэй ажилладаг жишээ хэлэхгүй байгаа юм бэ” гэж асууж магадгүй. Тэгвэл хариулт нь их тодорхой байх болно. “Биологийн аав ээж нь хоёр хүүхэдтэйгээ амьдардаг, аав ээж нь өмнө нь гэр бүл зохиож байгаагүй эсвэл салж байгаагүй ийм уламжлалт гэр бүлийг нийгмийн ажлын үйлчилгээ авч буй гэр бүл дотор олоход хэцүү болсон” гэж хариулах болно. Өнөөгийн уламжлалт гэр бүл магадгүй бидний өмнө үеийн орчин үеийн хэв маягийн гэр бүл байж болох юм. Гэр бүлийн уламжлалт бус, шинэ хэв маяг гэдэгт өрх толгойлсон ганц буй эцэг эхтэй эсвэл гей ба лесбиян эцэг эхтэй, эсвэл өвөө эмээтэйгээ, эсвэл хамаатантайгаа амьдардаг хүүхдүүд гээд олон янзын гэр бүлийн хэв маяг нэмэгдэж байна. Мөн өөр үндэстэн, ястан, эсвэл арьсны өнгөөр ялгаатай хүмүүс гэр бүл болох амьдрах тохиолдох их элбэг болсон. Тиймээс нийгмийн ажлын практикт яригдаж ирсэн уламжлалт гэр бүлийн бүтэц, бүрэлдэхүүн, нийгмийн бүлэг болон олон нийтийн бүтэц зохион байгуулалт, тэднээс хүлээх хүлээлтүүд мэдэгдэхүйц их өөрчлөгдөж байна. Хувь хүн ба гэр бүлийг сайн ойлгохын тулд хүн бүрийн, гэр бүлийн тогтолцооны өвөрмөц шинж, үнэт эрхэм чанарыг таньж ойлгох ёстой. Олон нийт, мэргэжлийн хүмүүс ялгаатай байдлыг шүүмжлэлтэй биш байдлаар эсвэл тэдний ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх байдлаар таньж ойлгох ёстой гэж нийгмийн ажилтнуудаас хүлээж байдаг. Нийгмийн ажилтнууд энэхүү нийгмийн болоод мэргэжлийн хүлээлтэд өөрийн мэдлэг, чадвар, туршлагаа нийцүүлэхийн тулд шүүмжлэлтэй биш байр сууринаас хэрхэн хандах, шүүмжлэлтэй хандахгүйн тулд ямар ёс зүйн хэм хэмжээг баримтлах ёстой, энэ зарчмыг нийгмийн ажлын практик үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэх талаар мэдэх хэрэгтэй болдог. Энэхүү хүний үнэт чанар, нэр хүндийг хүндэтгэн үзэх гэсэн хандлагыг нийгмийн ажилтан үйлчлүүлэгчдээ туслах бүхий л үйл ажиллагааныхаа тэргүүнд тавих ёстой. Нийгмийн ажилтнууд нь олон янзын үзэл бодолтой, итгэл үнэмшилтэй, янз бүрийн нийгмийн давхарга, хүйс, арьсны өнгө, яс үндэс, бэлгийн баримжаатай хүмүүстэй ажилладаг. Олон янзын хүмүүстэй харьцахын зэрэгцээ тэдний олон янзын асуудалтай тухайлбал эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүлийн, арьс өнгө, бэлгийн баримжаагаар ялгаварлах, хүчирхийлэл гэх мэт хувь хүний болон нийгмийн олон асуудалтай ажиллах хэрэгтэй болдог. Тиймээс, нийгмийн ажилтан олон төрлийн онол, практикийн аргуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, үйлчлүүлэгчийн нөхцөл байдалд тохирох практик загвар, ёс зүйн зарчим, эрх мэдлийн асуудлыг зөв сонгоход анхаарна. Үйлчилгээ үзүүлж буй нөхцөл нь үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, өдөр тутмын холбоо сүлжээ, нийгмийн

байгуулал, бүтэц зэргээс хамаарч өөр өөр байдаг. Нийгмийн ажилтнууд эдгээр өөрчлөлтийн талаар мэдэхийн зэрэгцээ энэ өөрчлөлтийн талаарх мэдлэгээ хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй ажиллах, тэдний хэвийн ажиллаж амьдрах боломжийг дахин бий болгох эсвэл нэмэгдүүлэхийн тулд хэрхэн ашиглах тухайгаа мэддэг байх шаардлагатай.

Ялгаатай байдал гэдэг үг нь тодорхой бүлэг эсвэл хүн амын тухай олон санаа бодлыг нэгтгэсэн өргөн хүрээтэй ойлголт. Жишээ нь Испани гаралтай бүлэг хүний тухай ярихад танд хамгийн түрүүнд юу бодогдох вэ? АНУ-ын хүн амын тооллогын мэдээнд испани гаралтай хүн амын бүлэгт латин америк эсвэл Мексик гаралтай бүх хүмүүсийг багтаасан байдаг. Өөрөөр хэлбэл, Куба, Мексик, Аргентин, Бразил, Испани зэрэг улсын бүх хүмүүс Испани гаралтай хүн амын бүлэгт орно. Хэдийгээр эдгээр улсаас гаралтай иргэд нэг испани гэсэн бүлэгт нэгдэж байгаа ч Куба хүн бол Аргентин, Мексик, Бразил, Испани хүмүүсээс их ялгаатай байх жишээтэй. Яс үндэс ялгаатай байхтай адил, тэдний өсөж төрсөн орчин, амьдралын хэв маяг, соёл мөн ялгаатай. Тухайлбал МкАдоогийн тодорхойлсон түүх ба соёлын онолын загварыг биологийн, сэтгэл зүйн, нийгмийн хүчин зүйлийг задлан шинжлэхэд ашиглаж тэдгээр ялгаатай байдлыг судалж болно.

Нийгмийн ажилтан нь хувь хүний ялгаатай байдлыг харгалзан үр дүнтэй ажиллахын тулд соёлын асуудалд мэдрэмжтэй хандахын зэрэгцээ өөрийн болон үйлчлүүлэгчийн үнэт зүйлсэд хэрхэн нийцэж байгаа, мөн тэдний үнэт зүйлс нь нийгмийн үнэт зүйлстэй хэрхэн холбогдож байгааг ойлгох хэрэгтэй. Ялгаатай байдалд анхаарах, соёлын ялгаанд мэдрэмжтэй хандах, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчлүүлэгчид нөлөөлөх орон нутгийн хийгээд бүс нутгийн ялгааг таних, ойлгох, үнэлж хүндэтгэх хэрэгтэй болдог.

Ялгаатай байдлын тухай сургалт ба нийгмийн ажил

Нийгмийн ажилд ялгаатай байдлын тухай сургалт яагаад чухал вэ?

Нийгмийн ажил нь мэргэжил болохынхоо хувьд хүмүүсийн хооронд болон хүн ба орчны хооронд олон талт, нарийн харилцааны хүрээнд нийгмийн асуудал, өөрчлөлтөд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг. Маш өргөн хүрээнд нийгмийн солилцоо, харилцаа холбоо, сайн сайхан байдлыг сайжруулахын төлөө нийгмийн ажлын практик чиглэгддэг. Бид өдөр тутам орон нутгийн асуудлаас эхлээд дэлхий нийтийг хамарсан өргөн асуудал, түүнчлэн нийгмийн гарал үүслийн хувьд ялгаатай олон хүнтэй харилцах хэрэг гардаг. Мөн нийгмийн ажлын чиглэлээр суралцаж

байгаа оюутнуудын дунд, улмаар ирээдүйд тэдний хийх нийгмийн ажлын практикт, мөн тэдний хувийн амьдралд ч ялгаатай байдалтай холбоотой асуудлыг шийдэх явдал тулгарна.

Хүмүүст тулгарч буй асуудлыг даван туулахад нь туслах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд туслах зорилготой практик үйл ажиллагаа нь нийгмийн ажлын аль нэг салбартай холбоотой гэж явцуу утгаар ойлгож болохгүй. Нийгмийн асуудлыг хувь хүнд тохиолдсон гэдэг өнцгөөр харахаас илүү тухайнаасуудлыг нийгмийн олон түвшинд тулгарч байгаа асуудал, бодлого чиглэлтэй холбон үзэх хэрэгтэй. Жишээ нь нийгмийн ажил нь мэргэжил болон хөгжиж эхлэхээс өнөөг хүртэл нийгмийн ажилтнууд ядуурлын асуудалтай өдөр бүр тулж ажиллаж байна. Өнөөдөр ч ядуурлын асуудлыг нийгмийн олон түвшинд үнэлж, түүнд чиглэсэн олон талт арга хэмжээ хэрэгтэй гэж үзэж байна. 2000 оны олон улсын нийгмийн ажлын тодорхойлолтод нийгмийн ажлын практикийн тодорхойлохдоо дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: “Нийгмийн ажлын мэргэжил нь нийгэмд давуу бус байр суурьтай хүмүүсийг нийгэмд татан оруулахын тулд ядуурлыг бууруулах, эмзэг байдал ба дарлал мөлжлөгийг багасгахыг чармайдаг. Нийгмийн ажлын интервенц нь хувь хүнд чиглэсэн нийгэм сэтгэл зүйн зөвлөн туслах үйлчилгээнээс эхлээд нийгмийн бодлого, төлөвлөлт, хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг нийтэд нь багтаасан” байдаг.

Нийгмийн ажлын үйлчилгээг янз бүрийн түвшинд үзүүлэх явцад нийгмийн ажилтнууд нийгэмд давуу байр суурь эзэлсэн эсвэл дарлагдаж, гадуурхагдсан хүмүүсийн зөрчил, тэдний хоорондын эрх мэдлийн тэнцвэргүй байдал, тэдний ялгаатай боломж, хүртээмжийн асуудалтай ажиллах шаардлагатай болдог. Нийгэмд байгаа тэнцвэргүй байр суурь, эрх мэдлийн асуудалтай нийгмийн ажилтан өдөр бүр тулж ажилладаг бөгөөд тэдэнд энэ чиглэлээр ажиллах мэдлэг, чадвар, дадал зайлшгүй хэрэгтэй.

Хүний эрхэм чанар, үнэ цэнэ, тэгш байдлыг хүндлэх нь нийгмийн ажлын үнэт зүйлс, ёс зүйн чухал суурь ойлголт. Олон улсын нийгмийн ажилтны холбоо (ОУНАХ), Нийгмийн ажлын сургуулиудын олон улсын холбоо (НАСОУН)-ээс 2004 онд баталсан нийгмийн ажлын ёс зүйн дүрэмд хүний эрх, хүний эрхэм чанарыг хүндэтгэх явдалд ач холбогдол өгч үүнийг нийгмийн шударга ёстой холбох ёстойг дараах байдлаар ёс зүйн дүрэмд тусгасан.

“Нийгмийн ажилтнууд нь хүний чадвар, нас, хүйс, жендэр, соёл, гэрлэлтийн байдал, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн үзэл, арьсны өнгө, биеийн шинж, бэлгийн баримжаа, итгэл үнэмшил дээр суурилсан аливаа ялгаварлан гадуурхлын эсрэг тэмцэх үүрэг хариуцлага хүлээнэ” (ОУНАХ/НАСОУН, 2004, 4.2).

“Нийгмийн ажилтнууд нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн ялгаатай байдлыг анхаарч өөрийн ажиллаж буй газар, нийгмийнхээ угсаатны болоод соёлын ялгааг таньж ойлгон, хүндэтгэх ёстой (ОУНАХ/НАСОУН, 2004, 4.3). Олон улсын түвшинд улс хоорондын болон соёлын ялгаатай байдлыг харгалзан ажиллах мэдлэг ур чадвартай байхаас гадна эрх мэдэл, давуу тал, дарлал мөлжлөг, ялгаварлан гадуурхлын улмаас нийгмээс тусгаарлагдсан байдлыг багасгах, тэгш эрх боломжийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллах ёс зүйн хариуцлага хүлээдэг. Эдгээр асуудалд дүн шинжилгээ хийх, ажиллах мэдлэг ур чадвартай болгох нь ялгаатай байдлын тухай сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь юм.

Ялгаатай байдлын тухай сургалт гэж юуг хэлэх вэ?

Ялгаатай байдал нь их өргөн хүрээтэй ойлголт учраас ялгаатай байдлын талаар судлахад хүндрэл тулгардаг. Ялгаатай байдалтай холбоотой асуудлыг тайлбарлах онолын үзэл баримтлалууд нь хоорондоо зөрчилдөөнтэй, эсвэл хоорондоо давхацсан, их олон янзын асуудал, түүнтэй холбоотой чиг хандлагыг агуулсан байдаг. Энэ олон янзын онол, үзэл хандлагыг хоёр үндсэн чиглэлд ангилахад магадгүй асуудлыг илүү ойлгомжтой болгож болох юм. Үүнд: соёл хоорондын хандлага ба арьс өнгөний эсрэг үзэл хандлага гэсэн хоёр ангилал болгож болно. Назарвиевич 2010 онд энэ хоёр ангиллыг тайлбарлан, бүтцийг нь дараах байдлаар танилцуулсан юм.

Ялгаатай байдлын тухай сургалтад заах төрөл бүрийн хандлага чиглэл: соёл хоорондын ялгааны сургалт ба арьс өнгөөр ялгаварлахын эсрэг боловсрол

2010 онд Назарвиевич соёлын тухай тодорхойлолт нь хоёр янз байна гэж үзээд нэг талаас соёлыг тогтвортой, уян хатан биш гэж үзэж байхад нөгөө талд нь соёл бол динамик, өөрчлөгдөх боломжтойг тодорхойлсныг онцолсон. Салбар дундын шинжлэх ухаанд хэрэглэгдэх нэр томъёог тодорхой, ойлгомжтой харуулсан мэдлэг дутмаг байна. Тиймээс, тэрээр тодорхой салбар шинжлэх ухааны нөхцөлд таарсан олон хандлагуудад дүн шинжилгээ хийхдээ тухайн салбар шинжлэн ухаан нь соёл ба олон соёлтой харилцах чадварыг хэрхэн тодорхойлж байна, үүнийгээ тодорхой нэг сургалтын заах арга зүйд хэрхэн тусгаж байгаа байдалд дүн шинжилгээ хийхийг оролдсон.

Назарвиевич нь соёл хоорондын ялгааны тухай сургалтын үндсэн агуулга нь дараах гурван чиглэлийг багтаах тухай заасан. Үүнд:

1. Соёлын чиглэл хандлагын тухай судалгаанд чиглэсэн соёлын антропологийн үүднээс ялгаатай байдалд хандах

2. Сургалт, тэр дундаа соёлд уусах эсвэл соёлыг тодорхойлсон арга зүйд чиглэсэн соёл хоорондын ялгаа
3. Бодит амьдралын тухай дүн шинжилгээнд тулгуурласан хэлэлцүүлэг ба хэлний ялгаа зэргийг сургалтын агуулгад багтана гэж үзсэн.

Харин арьс өнгөөр ялгаварлахын эсрэг боловсролын агуулгад

1. Интервенцийн тухай хэлэлцүүлэг, маргаан тухайлбал хэлэлцэх, үзэл бодлоо илэрхийлэх сургалт, Жанет Еллиотийн “Цэнхэр ба бор нүд” сургалтын загвар
2. Театрчилсан сургалтын арга, энэ аргыг Аугосто Боалийн гаргасан санаан дээр суурилсан
3. Ухамсарлахуйн сургалтууд тухайлбал Ван дэн Броекийн цагааныг шүүмжлэх нь гэсэн сургалт үүнд багтана.

Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг хандлага нь Адам, Бэлл, Гриффин нарын танилцуулсан нийгмийн шударга ёс гэсэн загвартай ойролцоо. Нийгмийн шударга ёс сургалтын гол агуулга нь өөрчлөлтийн үр нөлөөг үзэхийн тулд тасралтгүй хамтрах үйл явцын төлөө зүтгэх нийгмийг бий болгох явдал юм. Боловсролын зорилго ба сургалтууд энэ хамтын ажиллагааг бий болгоход чиглэгдэнэ. Энэ үйл явцыг дарангуйллын онолоор тайлбарладаг. Жишээ нь арьсны өнгөөр, бэлгийн баримжаагаар ялгаварлах үйл явцыг энэ онолоор тайлбарлана. Энэ дарангуйлах тогтолцооны гол онцлог нь дарангуйлж байгаа хүмүүсийн итгэл үнэмшил, хэвшмэл ойлголт, ерөнхийлөн дүгнэх, ад шоо үзэх, ялгаварлан гадуурхах хандлагыг бусад хүмүүс дэмжих, нийгмийн зүгээс энэ хандлагыг бэхжүүлсэн хандлага түгээмэл байдаг. Үүнийг hegemony буюу нийгмийн нэг бүлэг бусад бүлгээ улс төр, эдийн засаг, соёлын хувьд дарангуйлж нөлөөндөө байлгах гэж нэрлэдэг.

Адам, Бэлл, Гриффин нар нийгмийн шударга ёсны загварын зорилгыг “өөрсдийн тодорхойлсон хэрэгцээг хангахын тулд нийгмийн бүх бүлгүүд тэгш ба бүрэн оролцох”-д чиглэх ёстой гэж тодорхойлсон. Энэ нь шударга ёсыг эрхэмлэнэ гэсэн нийгмийн ажлын үнэт зүйлтэй нийцэж байгаа юм. Энэ зарчмыг нийгмийн ажлын сургалтын байгууллагын зорилготой холбон нийгмийн ажлын боловсрол ба сургалтад анхаарах нь чухал.

“Суралцагчид нийгэм болон тэдний амьдралд тохиолдох нийгмийн ялгаатай байдал ба дарангуйллын утга учрыг ойлгоход туслах интерактив болон туршилт дээр суурилсан сургалтын зарчмууд”-д анхаарах гэж Адам, Бэлл, Гриффин нар онцолсон.

Ялгаатай байдлын тухай сургалт ба нэгдсэн ойлголт

Назаркиевич ялгаатай байдлын тухай сургалтын загвартаа байгууллагад чиглэсэн ялгаатай байдлын удирдлагын асуудлыг улс төрийн боловсролтой нэгтгэхийг чухалчилсан. Учир нь АНУ-д энэ хоёр ойлголтыг соёлын ялгааны тухай сургалт, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг боловсрол гэсэн хоёр чиглэлээр тусад нь авч үздэг. Ялгаатай байдлыг тухай сургалт нь илүү өргөн хүрээтэй асуудлыг харах хэрэгтэй. Ялгаатай байдлын тухай сургалт нь нэг талаас хувь хүнийг тодорхойлох ойлголтууд, соёл, түүний гарал, намтар түүхийн асуудалд анхаарч, нөгөө талаас нийгмийн бүтэц, нийгмийн хандлагад нөлөөлөх замаар хүмүүсийн дунд тогтсон хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхах хандлагыг бууруулах шаардлагатай болдог. Түүнээс гадна нөөц боломжийг таних, давуу тал ба ялгаатай байдлыг үнэлэх зэрэгт анхаарал хандуулна. Соёлын хүчин зүйлс, соёлын ялгаатай байдалд ач холбогдол өгөхгүй байх эсвэл эрх мэдэл, давуу тал, дарангуйллыг үгүйсгэх гэж энэ хоёр ойлголтыг тусад нь авч үзвэл ялгаатай байдлын тухай сургалтын агуулгыг явцуу болгоно. Харин аль аль ойлголтыг хамтад нь авч үзэх нь ялгаатай байдлын тухай сургалтад чухал нөлөө үзүүлнэ.

Ялгаатай байдлын тухай сургалтын зорилго

Назаркиевич ялгаатай байдлын тухай сургалтын зорилтуудыг дараах байдлаар нэгтгэн дүгнэсэн. Үүнд:

1. Нийгэмших, ялгаварлан гадуурхлыг үр дагавар, хувийн үнэт зүйл ба хэвшмэл ойлголтуудыг таньж мэдэх, түүнд мэдрэмжтэй хандах, ба тэдгээр асуудлыг шүүмжлэлтэй эргэцүүлэн тунгаах
2. Байгууллага, нийгмийн институцийн ялгаварлан гадуурхал, түүний үр нөлөөг таньж ойлгох
3. Ялгаатай байдлыг нөөц баялаг гэж харах, ойлгохыг хичээх, хариуцлага хүлээх
4. Хувийн зан үйлийг өөрчлөх, хувийн болон байгууллагын түвшинд ялгаварлан гадуурхах явдлын эсрэг үйл ажиллагааг дэмжих зэрэг зорилгууд багтана.

Эдгээр зорилгыг өргөжүүлэх замаар нийгмийн ажлын чиглэлээр суралцаж буй оюутнуудын боловсролын хэрэгцээнд нийцүүлэн олон улсын түвшин, олон янзын соёлтой орчинд ил ба далд гарч буй ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх стратегийг баримтлахад нь туслах, тэднийг ирээдүй хийх мэргэжлийн практик үйл ажиллагаанд нь бэлтгэх явдал чухал. Ялгаатай байдлын тухай хичээлийн эхэнд оюутнууд өөрийн намтар түүх, үнэт зүйлс ба ёс суртахууны тухай бодох, тэднийг тодорхойлж буй нийгмийн үйл явцыг ойлгоход чиглүүлэх хэрэгтэй. Цаашдын хичээлүүдээр

ялгаатай байдлын талаарх ойлголт нь улам гүнзгийрч янз бүрийн ойлголт, хандлагуудыг үнэлж цэгнэх боломжтой болно. Эцэст нь тэд нэг л ижил түүх, хандлага нь нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтыг өөгшүүлж, энэ нь эрх мэдлийн хуваарилалт ба тэдний амьдралд шууд ба шууд бусаар нөлөөлж байгаа тухай мэдэх ба улмаар хүмүүсийн хоорондын харилцаа нь ялгаварлан гадуурхах байдлыг дэмждэг эсвэл юмыг харагдах байдлаар нь үнэлэхэд хүргэдэг гэдгийг ойлгох болно. Эхний зорилтын хүрээнд ойлголт нэмэгдүүлэх хичээлийн хүрээнд олж авсан мэдлэг нь хичээлийн хоёр дахь зорилго өөд чиглүүлнэ. Дараа нь бүтцийн түвшинд ялгаварлан гадуурхах, давуу биш байдал бий болгох нөхцөл бий болно гэдгийг ухаарна. Үүнийг институцийн түвшин дэх ялгаварлан гадуурхал гэж нэрлэх бөгөөд ийм төрлийн ялгаварлан гадуурхлыг бий болгоход эрх мэдлийг ашиглах оролцогч талуудын хувь нэмэр их үүрэгтэй. Сүүлийн хоёр зорилго бол суралцагчдын хандлага, ойлголттой холбоотой. Тэд ялгаатай байдлын тухай ойлгохоос гадна сэтгэл зүйн хувьд түүнийг мэдэрч, нийгэм, түүний доторх бүлгүүд, хүн бүрийн хувьд ялгаатай байдлыг нөөц гэж харан, ялгаварлан гадуурхлыг үүсгэж байгаа зан үйлийг өөрчлөх хэрэгтэйг ойлгоно. Энэхүү сургалтын үе шатууд нь өөрчлөлтөд нээлттэй байхын тулд эхлээд ойлголттой болох, дараа нь танин мэдэх, мөн төсөөлөх, ухамсарлах эцэст нь өөрчлөлт хийх сэдэл, чадвартай болох гэсэн сургалтын үйл явцыг ойлгож, түүнийг өөрийн биеэр мэдрэхэд нь тусална.

Онолыг практикт нэвтрүүлэх: “Ажиглах замаар суралцах”

Ялгаатай байдлыг заах уламжлалт олон арга, дасгалууд байдаг. Тэд бүгд өөрийн гэсэн зорилго, арга зүйтэй. Үүнтэй адил бид “Ажиглах замаар суралцах” гэсэн аргыг өөрсдийн дэвшүүлж буй ойлголт, загварыг хэрэглэх үндсэн арга гэж туршиж үзсэн. Бусад дасгалуудтай адил энэ туршилтын арга нь суралцагч өөрийнхөө орчин тойрон, нийгмийг ажиглаж, мөн түүний амьдралд ялгаатай байдал, эрх мэдлийн ил ба далд нөлөө хир их нөлөөлж байгааг таньж мэдэх, ойлгоход чиглэгдсэн. Гэхдээ энэ дасгалын онцлог нь тухайн сургалтын оролцогчийг бодуулах, түүний бодол, итгэл үнэмшлийг хөндөх нөхцөл орчныг бүрдүүлж түүнд идэвхтэй нөлөөлөх явдал юм. Энэ нөлөөлөл нь оролцогч өөрийн аюулгүй байдалд нөлөөлсөн аюултай, найдвартай биш байдлыг мэдэрч, аюул учирсан, эсвэл өөрт нь таатай бус орчинд юу хийх, эсвэл ийм байдал үүсэхэд юу хийх ёстой вэ гэдгийг төлөвлөх, өөрөө турших байдлаар олж мэдэх арга замд суралцана.

Ялгаатай байдлын тухай сургалтын үед оролцогч аюултай, найдваргүй байдалд орсон мэт мэдрэмжийг өөрийн биеэр яагаад мэдэрч турших нь чухал вэ? Вон Сиегалийн нийгмийн ажлын хөтөлбөрт багтсан төрөл бүрийн хичээлийн агуулгууд, ирээдүйд

практик дээр гараад үр дүнтэй ажиллах хоёрын хоорондын хамаарлыг судалсан судалгааны дүн нь энэ асуултад хариу өгсөн юм.

Хувь хүний намтар түүхтэй холбоотой аюултай, найдвартай биш байдлын тухай мэдрэмж нь тухайн хичээлийн хүрээнд ямар зорилготой, юуг сурах ёстойг ойлгож мэдэрсэн тэр ойлголт, мэдлэгээр тайлбарлагдаж, тайлагдаж байж сая тухайн хичээлийн агуулгын ойлгон ухамсарлах, улмаар хичээл үр дүнтэй амжилттай болно.

Ажиглах замаар суралцах гэсэн туршилтын дасгалын үед сургагч багшийн хяналт дор аюултай, найдваргүй гэсэн нөхцөл байдлыг үүсгэнэ. Энэ туршилт- дасгалын үед аюултай байдлыг даван туулах чадвартай хамт ялгаатай байдал- тай хэрхэн ажиллах чадвар хөгжих боломж бүрдэнэ.

“Ажиглах замаар суралцах” туршилт нь үндсэн дөрвөн шатаар явагдана. Үүнд -туршилтын талаар сургагч багш оролцогчдод заавар өгөх, оролцогч өөрөө дасгалыг тухай газар дээр гүйцэтгэх, оролцогч эргэцүүлэл бичиж багшид илгээх, эцэст нь том бүлгээр хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэх гэсэн дөрвөн шат багтана.

Туршилт хийх даалгаврыг оролцогчдод дараах байдлаар өгнө. Үүнд:

1. Чи бусдаас ялгаатай содон байх, эсвэл чамайг хүн танихгүй, эсвэл гадаадын хүн мэт чи бусдаас ялгаатай байж болох тийм газрыг бод. Яагаад энэ газрыг онцолсон гэдгээ эргэцүүлэн бод.
2. Тэр газар луугаа очиж, тэдэнд хэсэг хугацааг ганцаараа өнгөрүүл.
 - А. Өөрийн орчин тойрноо ажиглана (хүмүүс, бусад объект)
 - Б. Өөрийгөө ажиглана (биеийн хэлэмж, чи яаж хөдөлж байгаа зэрэг)
 - В. Гадаад орчинтойгоо харьцаж, тэнд байгаа хүмүүстэй харьцаа тогтоохыг оролд
3. Чи өөрийгөө аюулгүй газар байна гэж боддог, эсвэл өөрийн гэр, эсвэл чи тэнд харьяалагддаг газар, эсвэл чамд их тухтай хэвийн байдаг орчин гэх мэт газар. Чи яагаад тэр газрыг онцлон сонгосон гэдгээ эргэцүүлэн бод.
4. Тэр газраа очоод хэсэг хугацааг ганцаараа өнгөрүүл.
 - А. Өөрийн орчин тойрноо ажигла(хүмүүс, бусад объект)
 - Б. Өөрийгөө ажигла (биеийн хэлэмж, чи яаж хөдөлж байгаа зэрэг)

- В. Гадаад орчинтойгоо харьцаж, тэнд байгаа хүмүүстэй харьцаа тогтоохыг оролд
5. Өөрийнхөө энэ туршилтын үед төрсөн сэтгэгдэл, туршлагын талаар эргэцүүлэл бичиж, түүнийгээ сургагч багшдаа илгээх ба нэг хувийг нь дараагийн хичээл дээрээ ирэхдээ авчрах.
- А. Энэ хоёр туршлагаа аль алиныг дүрслэн тайлбарлах
- Б. Өөрийн ажиглалтыг эргэцүүлэн бодох

Оролцогчдын санал ба эргэцүүлэл

Оролцогчид даалгаврын дагуу танихгүй мэдэхгүй хүмүүстэй уулзах, өмнө нь очиж байгаагүй газраа очиход хүнд сорилттой тулгардаг. Тэд өөрсдийнхөө өдөр тутмын амьдралын хэмнэл, өдөр тутам очдог газраасаа өөр газар очиход шинэ хүмүүстэй уулзах, зарим нэг нь тэднийг үл тоох, хүлээж авахгүй байх явдалтай гарна. Сургагч багш тэдний ямар газар очихыг зааж өгөхгүй бөгөөд тэд өөрсдөө очих газраа сонгоно. Очих газраа өөрөө чөлөөтэй сонгох, гарч болох эрсдэлийг тооцох эсвэл эрсдэл бага газар очих нь тэдний сонголт. Бүлгээр хүн бүрийн очсон газрын тухай, хүмүүс шинэ газар очоод ямар зүйлийг сурч, ямар сонирхолтой туршлага болсныг ярихад зарим нэг нь “Би ийм туршилтыг хийж болох л байсан” эсвэл “Тэд яаж энэ бүхнийг хийж чадав” гэх мэт асуултуудыг өөртөө тавьдаг. Тэдгээр асуултын хариулт нь суралцагчдын ялгаатай байдлын тухай илүү их гүнзгий мэдлэгтэй болох, ялгаатай байдал ямар хүчирхэг ойлголт болохыг ойлгоход тусална. Зарим нэг оролцогчид өөрсдийн очих дургүй, өөрт нь хамааралгүй газарт очиж өөрийнхөө хаалт, дотоод зөрчлийг давахад хэрэгтэй зүйл болсон гэж тэмдэглэн хэлсэн байдаг.

Бүлгийн хэлэлцүүлгийн үед оролцогчдын хувьд хамааралгүй мэт үздэг олон газар байдгийг нээдэг. Жишээ нь зарим нь өөр үндэс угсаатай, эсвэл өөр шашинтай, эсвэл өөр арьс өнгөтэй хүмүүс амьдардаг газар, эсвэл сүм хийд, спортын дэлгүүр, секс тоглоомын дэлгүүр гэх мэт өмнө нь хэзээ ч очиж үзээгүй, очъё гэж боддоггүй байсан газрууд байдаг. Өөрийн хувьд миний очих ёстой газар биш гэж боддог газраа сонгож тухайн газартай танилцахад тэд өмнө нь бодоогүй, мэдээгүй зүйлтэй танилцах, бусад хүмүүсийн ялгаатай байдал, амьдралын өөр хэв маягийг ажиглах, ойлгох боломж гарна. Харин өөрийн хамаатай гэж боддог газрын сонголт бол хоорондоо их адилхан, оролцогчдын гэр нь байдаг. Нэгэн хэлэлцүүлгийн үед миний хамаатай гэж бодсон газар нь хүн бүрийн хувьд гэр нь байхад, хамааралгүй мэт санагддаг газар нь олон нийтийн газар байна, энэ нь нийгмийн гадуурхал эсвэл нийгмийн татан оролцуулах хандлагатай холбоотой байж болно, мөн хэн гаднын хүн, хэн өөрийн хүн гэдгийг шийдэх вэ гэдэг бол

бас нэг чухал асуудал гэсэн асуудлыг хөндөж ярилцаж байсан юм.

Оролцогчдын хувьд яг тулаад ирэхэд тэд очиж үзээгүй, тэд тэнд хамааралгүй гэж бодож байсан газрыг сонгох явдал элбэг. Очиж үзээгүй газраа очиход тэдний өмнө сонсож байсан түүх, эсвэл тэдний хандлага тухайн газартай танилцахад ямар их нөлөөлдөг болохыг, түүнчлэн нийгмийн зүгээс хүмүүсийн дунд тогтсон хэвшмэл ойлголт, хандлага тэдэнд хэрхэн нөлөөлж байсныг ойлгоно. Зарим нэг оролцогчид ялгаатай байдлын талаар хэрхэн мэдсэн тухай эерэг сэтгэгдэлтэй, сэтгэл өндөр ярьж байхад зарим нь үнэхээр миний очих газар биш байсныг ойлгосон гэж ярих тохиолдлууд байдаг. Очсон газраа аюулгүй гэж мэдрэх тохиолдолд оролцогч тэнд илүү тайван, гаднын хүн биш гэж бодон чөлөөтэй байдаг бол очсон газраа гаднынх, хүний газар гэж бодох тохиолдолд тэр газар аюултай, эсвэл тайван биш гэсэн мэдрэмж төрүүлдэг. Гаднын, гадаадынх юм шиг байдалтайгаа нүүр тулж, түүнийг даван туулах нь хувь хүний хувьд том өсөлт хөгжил гэж оролцогчид тайлбарлаж байсан нь гэж Ашенбреннэр-Веллманний аюулгүй байдлын мэдрэмжийн талаарх тайлбарыг санагдуулж байв.

Ялгаатай байдлын тухай энэ хичээл нь бүхэлдээ оролцогчид өөрсдийн амьдралд болон тэдэнтэй холбоотой байдаг хүмүүст нөлөөлж буй хүчин зүйлсийг тасралтгүй ажиглан, түүнийгээ эргэцүүлэн бодож, ойлгоход тусална.

Эх сурвалж: Boehler, D. & Randall, M. (2012). Diversity training and social work: An insight into theory, methodology and practice. ERES web journal, 1/2012.

2.3 ЛГБТИК+ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллах нь соёлын бүлгийн хувьд ялгаатай үйлчлүүлэгчидтэй ажиллахтай төстэй байдаг. Ялгаатай байдлаасаа болж сэтгэцийн эрүүл мэндэд нөлөө үзүүлэхүйц өдөр тутмын ялгаварлан гадуурхалт, стресс дарамттай байнга нүүр тулж байдаг. ЛГБТИК+ үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхийн тулд тэдний нийгэм сэтгэлзүйн байдал, холбогдох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь зөв юм.

ЛГБТИК+ олон нийт хамгийн түрүүнд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд өөрийн гэр бүл, найз нөхдийн хүрээнд сэтгэлзүйн асуудлуудтай тулгарсаар ирсэн байдаг.

ЛГБТИК+ үйлчлүүлэгчийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийл-лийн хувьд ялгаатай байдлыг үл харгалзан, тэднийг өөрийн гэсэн амьдралын түүх, онцлог шинж, хэрэгцээ шаардлага бүхий хувь хүн гэж үзнэ.

ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллахдаа анхаарах зүйлс:

- Тэдэнд зөвхөн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэлд тулгуурласан асуудлууд байна гэсэн үг биш юм. Бусад хүмүүст тулгарч байдаг гэр бүл, нийгэм, сэтгэлзүй, эдийн засгийн асуудал бэрхшээлүүд ч бас тулгардаг. Тиймээс үйлчлүүлэгчийн асуудал, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр үйлчилгээг төлөвлөх хэрэгтэй.
- Хувь хүн бүр нас, бие, сэтгэлзүйн онцлог шинжийн хувьд ялгаатай, өөрийн гэсэн өвөрмөц онцлог шинж бүхий байдгийг санах хэрэгтэй. ЛГБТИК+ үйлчлүүлэгч бүрд яг тохирсон үйлчилгээний арга зам гэж байхгүй бөгөөд өөрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага бүхий хувь хүн гэдгийг харгалзан үзэх шаардлагатай.
- Таны ямар ч үйлчлүүлэгч бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн хувьд ЛГБТИК+ олон нийтэд харьяалагддаг байж болох учраас аливаа үйлчлүүлэгчидтэй харилцахдаа хувь хүний ялгаатай байдалд халдсан, ёс зүйгүй үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.
- Өөрийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэлд хандаж буй хандлагаа ажиглаад үзээрэй. Хэрэв хувь хүний хувьд та шүүмжлэлтэй талаас ханддаг бол үйлчилгээний үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Хэрэв үйлчилгээний үйл явцад сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзвэл өөр мэргэжилтнээр солих хүсэлт

гаргаж, шийдвэрлүүлэх хэрэгтэй.

- ЛГБТИК+ олон нийтийн талаар урьдчилан судалгаа хийх хэрэгтэй. Өмнө ойлголт мэдлэгтэй байх нь үйлчилгээний явцад ямар нэгэн харилцааны алдаа гаргахаас сэргийлэх болно.
- **Өөрийгөө танин мэдэх нь:** ЛГБТИК+ олон нийтийн талаарх өөрийн ойлголт мэдлэгийг эргэцүүлж, мэдрэмжээ танин мэдэх хэрэгтэй. Миний хувийн үнэт зүйлс, соёл, шашны итгэл үнэмшил, зан үйл үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх үү? Хэрэв хувийн болон мэргэжлийн үнэт зүйлс хоорондоо зөрчилдөж байгаа бол ёс зүйн хувьд хоёрдмол байдал гаргахгүйн тулд мэргэжлийн үнэт зүйлсэд тулгуурлан шийдвэр гаргах хэрэгтэй. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хувьд ялгаатай байхаас үл хамааран хувь хүн гэж үзэж хүндэтгэлтэй хандах ёстой.
- Нийгмийн ажлын практикийн үйл явц үйлчлүүлэгчтэй ажиллах нийгмийн ажилтны үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлдог. Нийгмийн ажлын практикийн үйл явц нь дараах үе шатуудаар явагдана.

ХАРИЛЦАА ХОЛБОО ТОГТООХ

Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоохдоо аль болох тэдэнд нээлттэй, чөлөөтэй харилцах боломж бүхий тухтай орчныг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Уулзалтын эхэн үед харилцаа холбоо тогтоох болсон зорилго, чиглэлийг тодорхойлохын тулд аль болох нээлттэй асуултыг асууж, тэдэнд чөлөөтэй харилцах боломжийг олгох хэрэгтэй. Мөн өөрийн байгууллагын зорилго чиглэл, та түүнд хэрхэн тусалж чадах талаар тайлбарлаж, нууцлалын зарчим болон кейс файл хөтлөлтийн талаар тайлбарлах хэрэгтэй.

Харилцаа холбоог бэхжүүлэхийн тулд аль болох нээлттэй, чөлөөтэй харилцах орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Анхны уулзалт эхлэхийн өмнө тухгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, таагүй байдлыг удирдах хэрэгтэй.

Уулзалтын өмнө ЛГБТИК+ олон нийт, тэдний онцлог шинж, ялгаатай байдлуудын талаар судлах, ойлгож мэдсэн байх шаардлагатай. Энэ нь ЛГБТИК+ олон нийтийн талаарх хэвшиж тогтсон буруу ойлголтоос салахад туслах болно.

Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох болсон зорилго, үйлчилгээний зорилгын талаар тайлбарлана. Хэрэв үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлага болон тулгарсан асуудал таны үзүүлж буй үйлчилгээ болон байгууллагын зорилго чиглэлд

нийцэж буй бол үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцож үйлчилгээг хүргэх буюу хэрэв өөр байгаа бол үйлчлүүлэгчийн саналыг харгалзан холбогдох байгууллагад холбон зуучилж болно. Хэрэв үйлчилгээ цааш үргэлжлэх шийдвэр гарсан бол үйлчлүүлэгчтэй үйлчилгээний гэрээ байгуулна. Үүнд үйлчилгээ хэдий хугацаанд үргэлжлэх, хэн хэн оролцох, уулзалтын хуваарь гаргах болон оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага зэргийг харилцан тохирно.

Харилцан итгэлцэл бүхий харилцаа холбоог бий болгож хөгжүүлэх хэрэгтэй. ЛГБТИК+ үйлчлүүлэгч ялгаварлан гадуурхал, үгүйсгэл, үйлчилгээний нууцлалын талаар итгэлгүй байгаа байдлаас шалтгаалан мэдээлэл өгөхөөс зайлсхийх магадлалтай байдаг. Үйлчлүүлэгч тантай чөлөөтэй ярьдаг болох хүртэл тодорхой цаг хугацаа зарцуулж болно. Үйлчлүүлэгчийг яаруулах, ярилцахыг тулгаж болохгүй ба хүлээцтэй хандах хэрэгтэй.

Нууцлал: Анхны уулзалтын үеэр үйлчилгээний нууцлалын талаарх холбогдох журмыг танилцуулна. Ямар ч тохиолдолд үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалахыг эрмэлзэх бөгөөд түүний нууцлалыг задруулах дараах тохиолдлууд байж болдог бөгөөд энэ тохиолдолд түүний нууцлалыг задруулах талаар түүнд урьдчилан сануулах хэрэгтэй. Үүнд:

- Үйлчлүүлэгч өөрийгөө гэмтээх буюу амиа егүүтгэх магадлалтай бол
- Үйлчлүүлэгч бусдыг гэмтээх буюу бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахыг завдаж буй бол
- Үйлчлүүлэгч хэн нэгэн хүчирхийлэл дарамтад өртөж буй талаар мэдээлэл өгсөн бол тухайн хүнийг хамгаалах зорилгоор нууцлалыг задруулж болдог.

Дээрх тохиолдолд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын дүрэм журамд үндэслэн холбогдох арга хэмжээг авдаг.

Үйлчлүүлэгчийг тайвшруулах нээлттэй харилцаа үүсгэх туслах асуултууд:

- Аль нутгийнх вэ? Нутгийн онцлог шинж юу вэ? Тухайн орон нутагт ЛГБТИК+ олон нийт байдаг уу? Иргэд нь ЛГБТИК+ олон нийтийн талаар соёлын ямар хандлагатай байна вэ?
- Ажил хийдэг үү? Эсвэл сурдаг уу? Зуны амралтыг хэрхэн өнгөрөөдөг вэ? Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олонтойгоо чөлөөт цагийг хэрхэн өнгөрүүлдэг вэ?
- Таны сайн найзууд хэн бэ? Тэдгээр найзуудтайгаа хэрхэн танилцсан бэ? Та бүхэн цагийг хэрхэн өнгөрүүлдэг вэ?
- Таны сонирхол, хобби юу вэ? Та юу хийх дуртай вэ? Цаашдын

зорилго, төлөвлөгөөнийхөө талаар хуваалцаж болох уу?

- Хөгжим сонсох дуртай юу? Ямар төрлийн хөгжим сонсдог вэ? Ямар хамтлаг, дуучинд дуртай вэ? Яагаад дуртай вэ?
- Та үйлчилгээний үр дүнг хэрхэн харж байна вэ?

Ярилцлага хийхийн өмнө:

- Та хэн бэ? Байгууллагын зорилго, зорилт юу вэ? Үйлчлүүлэгч хэн бэ? Би хэрхэн тусламж дэмжлэг үзүүлэх вэ? гэдэгт анхаарлаа хандуулаарай.
- Үйлчлүүлэгчид хүндэтгэлтэй хандахаа хэзээ ч битгий мартаарай.

Харилцааны ур чадвар

Нийгмийн ажилтан ЛГБТИК+ үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлтэй ажиллахдаа харилцааны ур чадвартаа анхаарал хандуулах хэрэгтэй. Үйлчлүүлэгч өөрийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийлэлд хэрхэн хандаж буйд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй.

Үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хамгийн чухал ур чадваруудын нэг нь харилцааны ур чадвар юм.

Идэвхтэй сонсох чадвар: ABC зарчимд тулгуурлан хэрэгждэг.

Affirming буюу баталгаажуулах: Үйлчлүүлэгч ихэвчлэн өөрийн бусадтай хуваалцах дургүй мэдээллээ танд ярьж байдаг. Тэдний ярьж буй зүйлсийг хүлээн зөвшөөрөх, хариу өгөх замаар харилцаанд дэмжиж буйгаа илэрхийлэх хэрэгтэй. Үйлчлүүлэгч таны ярианд оролцож, хариу үзүүлж буй байдлаар дамжуулан анхаарал хандуулж буй эсэхийг мэддэг. Тухайлбал, “Ярих хэцүү байсан байх аа. Өөрийн талаар ярилцсанд баярлалаа” зэргээр ярилцах үед дэмжиж болно. Мөн ярилцагчийн өөдөөс харах, толгой дохих зэргээр биеийн хэлэмж ашиглаж болно.

Being sensitive буюу мэдрэмжтэй байх: Харилцааны үед үйлчлүүлэгчийн цаашид нээлттэй ярилцах үйл явцад дэмжлэг үзүүлэхийн тулд нээлттэй харилцааг дэмжих хэрэгтэй. Тухайлбал, “Танд ямар хэцүү байсныг ойлгож байна, дахиж ийм зүйл болохгүй гэдэгт итгэлтэй байж болно” зэргээр ярилцах хэрэгтэй.

Clarifying буюу тодруулж асуух: Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн ярьж буй зүйлсийг дэлгэрүүлэн асууж болно. “Үүнийг дэлгэрүүлэн ярьж өгнө үү. Хэзээ энэ зүйл тохиолдсон бэ?” гэх мэт.

Суралцах хөгжих: Үйлчилгээ үзүүлж буй олон нийтийн талаар

ойлголт мэдлэгтэй байх нь үр дүнтэй харилцаа холбоо тогтооход маш чухал. Үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлыг тэднээс илүү сайн мэднэ гэж байхгүй учир үйлчилгээ үзүүлж байх явцдаа бид үйлчлүүлэгчдээс маш ихийг сурч мэдэж авдаг.

Хувийн үнэт зүйлстэйгээ тэмцэх: Хэрэв үйлчилгээ авч буй олон нийтийн талаарх таны үнэт зүйлс, итгэл үнэмшил мэргэжлийн үнэт зүйлстэй зөрчил- дөж байгаа бол та нэн тэргүүнд мэргэжлийн үнэт зүйлс, итгэл үнэмшлийг баримтлах хэрэгтэйг санаарай.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Нөхцөл байдлын үнэлгээ гэдэг нь үйлчлүүлэгчид тулгарч буй асуудал, бэрхшээлүүдийн талаар үнэлгээ хийж, тодорхойлно. Юуны түрүүнд та үйлчлүүлэгчид түүнд аюулгүй, итгэлтэй, тухтай орчин гэсэн мэдрэмжийг төрүүлэхийн тулд анхаарал хандуулах хэрэгтэй. Энэ нь үйлчлүүлэгчид айдас болон биеэ барих мэдрэмжгүй өөрийн санаа зовж буй зүйлс, тулгарч буй асуудал бэрхшээл болон түүнийг хэрхэн шийдвэрлэх боломжтой талаар чөлөөтэй ярилцах боломж олгох болно. Нийгмийн ажлын үйлчилгээ тухайн үйлчлүүлэгчийн давуу талд тулгуурлан хүрдэг учир үйлчлүүлэгчийн хүсэл сонирхол, тэдний авьяас чадвар, давуу тал, түүнд юу чухал болох, цаашдын зорилго чиглэлийн талаар тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн хувь хүний ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, үйлчлүүлэгч өөрт тулгарсан асуудлаа хэрхэн тодорхойлж байна, түүнийг шийдвэрлэхийн тулд юу хийж болох талаарх зорилгоо хамтран тодорхойлох хэрэгтэй. Дэвшүүлсэн зорилгоо биелүүлэхийн тулд юу хийх боломжит нөхцөл байдлуудыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний биелэлтийг хэрхэн үнэлэх талаар хамтын оролцоотой шийдвэр гаргах хэрэгтэй. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ гэдэг нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, үйлчилгээний талаарх түүний хүлээлт, үйлчилгээний зорилго зэрэгт үйлчлүүлэгчийн оролцоог хангаж ажиллахыг хэлдэг.

Асуудлыг тодорхойлох: Нэн тэргүүнд үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход анхаарал хандуулах хэрэгтэй.

Хүчтэй мэдрэмж илэрхийлж буй үед түүнийг тайвшруулах буюу асуулт асуух үйл явцыг түр хойшлуулж болно. Байгууллага болон мэргэжилтний хувьд тухайн үйлчлүүлэгчид хэрхэн тусалж болох талаар тайлбарлаж, үйлчлүүлэгчтэй хамтран үйлчилгээний зорилгоо тодорхойлох хэрэгтэй.

ТУЛГАРЧ БОЛОХ АСУУДЛУУД	ИЛЭРХИЙЛЭХ ХЭЛБЭР
<i>Айдас түгшүүр</i>	• Үл хүлээн зөвшөөрүүлэх • Хүчирхийлэл ба дарамт • Ялгаварлан гадуурхал, алагчлал • Гэр бүлээс тусгаарлагдах • Сэтгэцийн эмчилгээнд албадан хамрагдах
<i>Өөрийгөө илэрхийлэх</i>	• Бусдаас нуугдахын оронд өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх Гэр бүл, найз нөхдийн дунд өөрийнхөөрөө, чөлөөтэй байх Бусад хүмүүсийн хажууд өөрийгөө бүрэн дүүрэн мэдрэх Нуугдмал байх хугацаанд алдагдсан цаг хугацаа, боломжийг олж авах • Бусдын адил хүн гэдгээ мэдрэх • Өөрийнхөөрөө байх нь асуудал биш гэдгийг мэдрэх
<i>Өөрийгөө илэрхийлэхэд тулгарч болох мэдрэмжүүд</i>	• Айдас түгшүүр, эмзэг байдал • Тайвшрал • Хэн гэдгээрээ бахархах • Тодорхой бус байдал • Мэдрэмтгий байх
<i>Бусад хүмүүсийн сэтгэгдэл</i>	• Айх, эвгүйцэх, тухгүй байх • Юу хэлэх, юу хийхээ мэдэхгүй байх • Уурлах, бухимдах, зэвүүцэх • Дэмжих • Хүндэтгэх

Бусдаас хүсэж буй нөхцөл байдал	• Байгаагаар нь хүлээн авах • Дэмжих • Ойлгох, мэдрэмжийг нь дэмжих • Тайтгаруулах, тайвшруулах • Илүү ойр дотно харилцах • Сөрөг хандлага гаргахгүй байх
---	--

Улаан дохио: Асуудал бэрхшээл хүнд байгаа шинж тэмдэг буюу яаралтай анхаарал хандуулах шаардлага байгааг илэрхийлэх шинж тэмдгүүд. Үүнд:

- Амиа егүүтгэх оролдлого
- Өөрийгөө болон бусдыг гэмтээх оролдлого
- Архи тамхи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх
- Сэтгэл гутралд орох
- Айдас түгшүүрийн хэмжээ их байх

Ямар ч үйлчлүүлэгчтэй харилцах байсан нээлттэй, ил тод харилцаа холбоог бий болгож, хэвшүүлэх нь чухал. Эхний үед үйлчлүүлэгч байгууллагын талаар сайн мэдээлэлгүй байх, ялгаварлан гадуурхагдах, шүүмжлүүлэхээс зайлсхийх, үйлчилгээний нууцлалын талаарх ойлголт мэдлэг муу байх зэргээс шалтгаалан нээлттэй харилцахад хэцүү байж болно. Ялангуяа богино хугацаанд үйлчилгээ хүргэх үед үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо бэхжүүлэхэд хүндрэлтэй байдаг.

Байгууллагын дүрэм журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хэцүү байвал үйлчилгээний талаар танилцуулсан хэвлэмэл хуудас, танилцуулга зэргийг ашиглаж болно. Биеийн хэлэмж таны бодож байгаагаас илүү ихийг илэрхийлдэг учир биеэ авч яваа байдал, дуу хоолойн өнгө зэрэг биеийн хэлэмжээр үйлчлүүлэгчид хүндэтгэлтэй хандаж буйг илэрхийлэх хэрэгтэй.

Үйлчлүүлэгчийг удирдан чиглүүлэх хэрэггүй. Ямар ч тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хүн үйлчлүүлэгч өөрөө гэдгийг санах хэрэгтэй. Үйлчлүүлэгчийг өөрөө бие даасан шийдвэр гаргахад туслах, дэмжих хэрэгтэй.

ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭХ

ЛГБТИК+ олон нийтэд дараах асуудлууд тулгарсан байж болох юм. Үүнд:

- Мэдэхгүй асуудлууд, эрэл хайгуул хийх

- Гэр бүл, найз нөхөд, шашин шүтлэг, ажил, сургуулийн орчноос тусгаарлагдахаас айх
- ЛГБТИК+ олон нийтийн талаарх нийгмийн хандлага, хэвшиж тогтсон буруу ойлголтууд
- Ялгаварлал, алагчлал, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргүүд
- Гэр бүлийн болон бусад орчинд дарамт шахалт, хүчирхийлэлд өртөх
- Сэтгэцийн хямрал, амиа хорлох талаарх бодлууд
- Хорт зуршил хэрэглэх
- Өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах

Хямрал гэдэг нь гэнэтийн нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас зан байдлаа хянах чадвараа түр алдах буюу өөрийгөө хянах, өөртөө дэмжлэг үзүүлэх эх үүсвэрүүд нь сул болох юм уу байхгүй болох нөхцөл байдлыг хэлдэг. Гэнэтийн хямрал нь хүний өдөр тутмын амьдралын хэвшлээс гадуур хэн бүхнийг цочирдуулам үйл явдал тохиолдож, маш хүчтэй дарамт үзүүлдэг.


Архаг хямрал нь хүний хувийн амьдралд байнга байдаг, хэдийгээр тухайн хүн эхэн үедээ хямралаа тайлж чаддаг боловч яваандаа энэхүү хямрал нь сөрөг нөлөө үзүүлж, байнгын хямралт байдалд байлгадаг болсныг хэлнэ (ХТҮГ, НҮБХС, 2004). Хүчирхийлэл, дарамтад өртсөн үйлчлүүлэгч ихэвчлэн гэнэтийн хямралд орж, улмаар хямралд чиглэсэн үйлчилгээ авч чадаагүйгээс архаг хямралд автсан шинж тэмдэг илэрдэг байна (ХЭҮТ, 2006). Жишээлбэл, хямралд орсон хүн санаа зовомтгой болж нойр хоолонд дургүй болох, арьс нь өвчлөх, ходоодны шархтай болох гэх мэт.

Сэтгэлзүйн хувьд илрэх шинж тэмдэг:

- Цурхиран уйлах
- Богино хугацаанд жин нэмэх юм уу турах
- Нойргүйдэх, сурах, ажиллах идэвхгүй байх
- Хоолны дуршил буурах буюу эсвэл хэт их идэх
- Ганцаараа байхыг хүсэх
- Нийгмийн ур чадвар дутагдах, зохисгүй зан үйл гаргах
- Архи, тамхи хэтрүүлэн хэрэглэх
- Түрэмгий зан үйл гаргах: Гэнэт зан байдал өөрчлөгдөх, бусдын өөдөөс дайрч давшлах
- Бие махбод сул дорой болох, байнга өвдөх гэх мэт

Хямралын үеийн үйлчилгээний зорилго нь үйлчлүүлэгчид хүрээлэн буй орчноос үүдсэн хямралын асуудлыг шийдэж, даван туулах чадварыг сэргээхэд чиглэгддэг.

Зураг 1. Хямралын үйл явдлын дүр зураг



Аюултай нөхцөл байдалд орж, сэтгэл санаагаар унах гэдэг нь ихэвчлэн хямралын өмнөх байдалд орох бөгөөд ихэвчлэн өөрийн туслах систем даван туулах чадварын тусламжтайгаар хийгддэг. Эдгээр байдал шийдэгдэхгүй тохиолдолд тухайн хохирогч хямралт байдалд орох бөгөөд энэ тохиолдолд зайлшгүй хямралд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.

Туслах харилцаа холбоог хөгжүүлэх нь харилцаа холбоогоо бий болгохын тулд үйлчлүүлэгчийн санаа зовж байгаа болон хэрэгцээтэй зүйлд нь идэвхтэй анхаарна. Хамтарч бодит нөхцөл байдлыг гаргаж тавих, асуудлыг үйлчлүүлэгч хүлээн авч буй байдлыг тодорхойлно. Гол нь үйлчлүүлэгчтэй хямралыг давж гарах бодитой итгэл найдварыг төрүүлэхүйцээр харилцах хэрэгтэй.

Үйлчлүүлэгчийн айдас, түгшүүр, сэтгэл санааны уналтад мэдрэг хандаж, хэрэв хэт их айдас түгшүүртэй байгаа бол түүнд тусалж чадах сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнээс үйлчилгээ авахад нь тусална. Хямралд орсон үйлчлүүлэгчид зохих тусламж дэмжлэг аваагүйгээс болж амьдралаа идэвхтэй авч явах чадвар буурч болно. Үйлчлүүлэгчид ирээдүйд тулгарч болох хямралаас урьдчилан сэргийлж, асуудлыг шийдвэрлэх арга зүйд суралцуулах, чадварыг нэмэгдүүлэхэд анхаарна.

Дэмжих үйл ажиллагаа нь хүнд нөхцөл байдлыг даван туулахад нь үйлчлүүлэгчийг хөгжүүлэх замаар туслах явдал юм. Жудиф Нелсон туслах журмыг тодорхойлохдоо үйлчлүүлэгчид илүү аятайхан, таатай, зоригтой, итгэлтэй байхад нь туслах арга хэмжээ юм гэж тодорхойлсон (Louis C. Johnson, 325х). Тэрээр мөн 4 төрлийн дэмжих хэлбэр байдгийг тодорхойлсон. Үүнд:

1. **Хамгаалах:** Зөвлөгөө өгөх, хязгаар тогтоох, төвөгтэй, хүнд үед хэрхэх тухай заавар зөвлөгөө өгөх;
2. **Хүлээн зөвшөөрөх:** Үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг нийгмийн ажилтан сайн ойлгож байгаа болон нөхцөл байдал, мэдрэмжийг ойлгож байгаагаа илэрхийлэх;
3. **Найдвар төрүүлэх:** Үйлчлүүлэгч ярилцлагад саналаа хэлэх, ярьж буй зүйлд өөрийн бодол саналаа хэлж, итгэл найдвар, урам өгөх, батлах, даван туулах, гүйцэтгэлийг бататгах;
4. **Сургах:** Үйлчлүүлэгчээ хэрхэн үрдүнтэй ажиллах, бэрхшээлийг даван туулах тухай заах, шаардлагатай мэдээллээр хангах, нийгэмд шинэ үүрэг гүйцэтгэхэд нь туслах, өөрийнхөө тухай мэдлэгийг нэмэгдүүлэхэд туслах.

Харилцаа холбоог бэхжүүлэхийн тулд ойрхон холбоо барих, хямралын нөхцөл байдлыг тодорхойлох, үүссэн шалтгааныг тодорхойлох, үйлчилгээний хувилбаруудыг тодорхойлох, бусад байгууллага болон мэргэжилтнүүдээс тусламж хүсэх зэрэг болно.

Үйлчилгээний явцад гарсан ахиц дэвшлийг хамтран хэлэлцэж, хэрэв үйлчилгээний зорилго өөрчлөх талаар ярилцах бол хамтран шийдэлд хүрэх буюу зөвшилцөх хэрэгтэй.

Зөвлөгөө өгөх техникүүд:

- Биеийн хэлэмж: Таны хэлж буй үгнээс илүү ихийг ярьдаг.
- Харцаар холбоо тогтоох (үйлчлүүлэгч рүү харах)
- Гарын хөдөлгөөн (гар барих, шүргэлцэх, тэврэх, ярихдаа гараа хөдөлгөх гэх мэт)
- Дуу хоолойн өнгө
- Биеийн хөдөлгөөн

- Нүүрний хөдөлгөөн
- Ерөнхий төрх байдал

Анхаарах зүйлс:

- Идэвхтэй сонсох, анхаарал хандуулах, тодруулах асуух зэргээр санаа тавьж буйгаа ойлгуулах;
- Асуулт ба хариулт: Нээлттэй болон хаалттай асуултуудыг тохируулан ашиглах, тодруулах асуулт асуух хэрэгтэй;
- Бага ярьж илүү их сонсох, ярьж буй ярианд дэмжлэг үзүүлэх, үйлчлүүлэгчийн яриаг таслахгүй байх.

Үйлчлүүлэгчийн давуу талд тулгуурлан үйлчилгээ хүргэх:

Энэ нь үйлчлүүлэгчийг чадваржуулах замаар түүний оролцоог дэмжиж асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг хандлага юм. Үйлчлүүлэгчид ямар ч хүндрэл бэрхшээл тулгарсан бай тэрээр өөрийн өвөрмөц онцлог шинж, давуу тал бүхий хувь хүн гэдгийг ойлгож мэдэх хэрэгтэй. Үйлчлүүлэгчийн давуу болон сул талуудыг тодорхойлж, давуу талд тулгуурлан шийдвэрлэдэг. Үйлчлүүлэгчийн давуу тал дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:

Хувь хүний зан төлөв, шинж чанар:

- Үйлчлүүлэгч асуудлаа шийдвэрлэх хүсэл эрмэлзэлтэй байна уу?
- Үйлчлүүлэгч мэдээлэл авахад нээлттэй хандаж байна уу?
- Үйлчлүүлэгч өөдрөг үзэлтэй байна уу?
- Үйлчлүүлэгч тавьсан зорилгоо биелүүлэхээр тууштай хичээж, зүтгэж байна уу?
- Үйлчлүүлэгч гол асуудалд анхаарлаа хандуулж байна уу?
- Үйлчлүүлэгч өөр орчин нөхцөлд дасан хурдан зохицох чадвартай байна уу?

Та дээрх асуултуудад “Тийм” гэж хариулт өгсөн бол таны үйлчлүүлэгч “Зан төлөв, шинж чанар”-ын хувьд давуу талуудтай юм байна.

Ур чадвар:

- Үйлчлүүлэгч гадаад хэлний мэдлэгтэй байна уу?
- Үйлчлүүлэгч ямар сургууль төгсөж, ямар мэргэжил эзэмшсэн байна вэ?
- Үйлчлүүлэгчид маш сайн хийж чаддаг ямар зүйлс байна вэ?
- Үйлчлүүлэгч олон хүнтэй газар чөлөөтэй ярилцах чадвартай байна уу?

Та дээрх асуултуудад “Тийм” гэж хариулт өгсөн бол таны үйлчлүүлэгч “Ур чадвар”-ын хувьд давуу талуудтай юм байна.

Хүмүүс болон дэмжлэгийн систем:

- Үйлчлүүлэгчийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг гэр бүлийн гишүүд болон найз нөхөд ойлгож, дэмжиж байна уу?
- Үйлчлүүлэгчид ЛГБТИК+ олон нийтэд харьяалагддаг өөр найзууд байна уу?
- Үйлчлүүлэгч ЛГБТ олоннийтийн эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагын талаар мэддэг, үйлчилгээ авч байсан, үйл ажиллагаанд оролцож байсан туршлага байна уу?

Та дээрх асуултуудад “Тийм” гэж хариулт өгсөн бол таны үйлчлүүлэгч “Хүмүүс болон дэмжлэгийн систем”-ын хувьд давуу талуудтай юм байна.

Нөөц боломж:

- Үйлчлүүлэгчид эдийн засгийн нөөц боломж байна уу?
- Үйлчлүүлэгч өөрт буй боломжийг олж харж, ашиглаж чадаж байна уу?
- Үйлчлүүлэгч нийгмийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авч байсан уу?

Та дээрх асуултуудад “Тийм” гэж хариулт өгсөн бол таны үйлчлүүлэгч “Нөөц боломж”-ийн хувьд давуу талуудтай юм байна.

Үйлчлүүлэгчтэй хамтран давуу болон сул талуудаа тодорхойлсны дараа үйлчлүүлэгчид тулгарсан асуудлуудыг тэд хянаж чадахгүй боловч түүнд хариу өгөх, даван туулах хүч тэдэнд бий гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Тэдэнд тулгарч буй асуудлууд бусад хүмүүст ч мөн тулгардаг бөгөөд туслах байгууллага, мэргэжилтнүүд түүнээс ч илүү олон байгаа гэдгийг сануулах хэрэгтэй.

Одоо байгаа нөхцөл байдал цаашид хэрхэн өөрчлөгдөх боломжтой байгааг тайлбарлах хэрэгтэй.

Хэрэв байршуулан үйлчилгээ хүргэх бол:

- Байршуулах асуудал: Ямар байранд, хэнтэй хамт байх талаарх бодлого чухал.
- Эрүүл мэндийн асуудал:
- Хууль эрхзүйн тусламж, зөвлөгөө:
- Сэтгэлзүйн зөвлөгөө, тусламж: ЛГБТ үйлчлүүлэгч өөрийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн

хувьд өөрийгөө танин мэдэх, хүлээн зөвшөөрөхөд нь дэмжлэг үзүүлэх, туслах хэрэгтэй.

ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ, ТӨГСГӨХ

Нийгмийн ажилтны үзүүлсэн үйлчилгээ чанартай байх гэсэн хариуцлагыг хүлээх ёс зүйг нийгмийн ажилтнууд хүлээх ёстой. 1996 онд батлагдсан “Нийгмийн ажлын Олон улсын ёс зүйн кодоод” “Нийгмийн ажилтан . . . үйлчилгээнд явцын болон эцсийн үнэлгээг хийх хэрэгтэй.” гэж заасан байдаг. Үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлтийг хэмжихэд хэрэглэгдэх ямар шат дамжлагыг авч хэрэгжүүлснээ шийдвэрлэн үнэлэхэд нийгмийн ажилтан дараах асуултуудыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- ***Баталгаажсан байдал***

Хэмжих үйл явцыг хэрхэн таамаглаж, авч үзэж байгаа болох

- ***Найдвартай байдал***

Ижил нөхцөлд хэмжилтийг дахин давтан хийсэн тохиолдолд үр дүн ижил байх

- ***Энгийн хэрэглээтэй байх***

Мэргэжлийн бус хүмүүст ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, тодорхой үр өгөөжтэй байх

- ***Мэдрэмжтэй байх***

Өчүүхэн төдий өөрчлөлт, ялгаатай байдлыг хэмжилтэд авч үзэх

- ***Өөрчлөлтөд идэвхгүй хэсгийг харгалзан үзэх***

Ямар нэгэн өөрчлөлт харагдахгүй байгаа болон бусад талуудыг ялгааг олж харах.

Нийгмийн ажлын практикийн үйл явцын бүх үр дүнг үнэлж болох бөгөөд практикийн бүх үе шатанд тасралтгүй үнэлгээ, хяналт хийж байх үүргийг нийгмийн ажилтнууд хүлээдэг.

Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх үйл явц нь эцсийн үнэлгээ хийх, үйлчилгээг дуусгавар болгосноор төгсдөг.

Үйлчилгээг төгсгөх нь нийгмийн ажилтан харилцаа холбоог дуусгах асуудалд мэдрэмжтэй байж үйл ажиллагааг дүгнэхэд чиглэсэн хамгийн чухал үе шат юм. Заримдаа үйлчилгээ нь нийгмийн ажилтан болон үйлчлүүлэгчийн бодож төлөвлөж байснаас өөр тохиолдолд дуусаж болно.

Үйлчлүүлэгчийн өөртөө тавих анхаарал халамжийг үнэлэх хуудсыг ашиглаарай. Тус үнэлгээний хуудас нь өөртөө анхаарал халамж

тавих чадварт дэмжлэг үзүүлэхийн тулд үр дүнтэй стратегийг тодорхойлоход ашигладаг. Үнэлгээний хуудсыг бүрэн бөглөж дууссаны дараа сайжруулах үйл ажиллагааны хүрээ тус бүрээс 1-ийг сонгоно уу. Давтамжийг дараах хэлбэрээр үнэлнэ үү.

5	4	3	2	1
Дандаа, тогтмол	Заримдаа	Ховор	Үгүй	Хэзээ ч тохиолдор байгаагүй

Бие махбодод тавих анхаарал халамж

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Тогтмол хооллодог (өглөө, өдөр, орой).	
Эрүүл хооллодог.	
Дасгал хөдөлгөөн хийдэг.	
Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхийн тулд шинжилгээ болон эмчилгээ хийлгэдэг.	
Шаардлагатай үед эрүүл мэндийн тусламж авдаг.	
Шаардлагатай үед амралт, завсарлага авдаг.	
Массаж хийлгэдэг.	
Бүжиглэх, усанд сэлэх, алхах, гүйх, спортоор хичээллэх зэргээр хөгжилдөх дуртай.	
Бэлгийн харилцаанд ордог.	
Хангалттай унтаж амардаг.	
Өөрт таалагдсан хувцсаа өмсдөг.	
Амралт авдаг.	
Аялал, зугаалгаар явдаг.	
Түр ч болов утаснаас хол байж чаддаг.	
Хэвлэл мэдээллийн хэрэгслээс түр холддог (Facebook, Twitter гэх мэт.)	

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Өөрийн талаар бодож эргэцүүлэхэд цаг гаргадаг.	
Өөрийн сэтгэлзүйд тохирсон эмчилгээний арга ашигладаг.	
Ажил, сургуультай холбоогүй сэдвээр ном зохиол уншдаг.	
Өөрийн мэргэшсэн, ажилладаг, сурдаг сэдвээс өөр үйл ажиллагаа хийдэг.	
Стрессээ тайлж чаддаг.	
Бусдад өөрийн ялгаатай, давтагдашгүй талыг илэрхийлдэг.	
Өөрийн дотоод шийдвэр, өөрийн итгэл үнэмшил, хандлага, мэдрэмжээ сонсдог.	
Галерейд очих, үзвэр үзэх, спортын арга хэмжээнд оролцох гэх мэт шинэ зүйлс туршдаг.	
Бусдаас туршлага судалдаг.	
Сониуч	
Шаардлагатай бол “Үгүй” гэж хэлж чаддаг.	

Сэтгэлийн хөдөлгөөнд тавих анхаарал халамж

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Өөрт таалагддаг хүмүүстэй цагийг өнгөрөөдөг.	
Амьдралд тань чухал хүмүүстэй холбоо харилцаатай байдаг.	
Өөрийн давуу талаа мэдэж, түүгээрээ бахархдаг.	
Өөртөө хайртай.	
Дуртай номоо дахин уншдаг, дуртай киногоо дахин үздэг.	
Өөрт тухтай хүмүүс, эд зүйлс, байр, харилцаа холбоог олж мэдэж, эрэлхийлдэг.	
Өөртөө уйлах боломж олгодог.	

Өөрийгөө инээлгэх зүйлсийг эрэлхийлдэг.	
Нийгмийн асуудал, жагсаал цуглаан зэрэгт уурлаж, бухимдал төрдөг.	
Хүүхэдтэй тоглох дуртай.	

Оюун санаанд тавих анхаарал халамж

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Дүгнэлт хийхэд цаг гаргадаг.	
Байгальд гарах, аялахад цаг гаргадаг.	
Оюун санаатай холбоотой үйл ажиллагаанд оролцдог.	
Урам зориг авах зүйлстэй.	
Итгэл найдвар, өөдрөг үзэлтэй.	
Амьдралд материаллаг бус зүйлс чухал гэдгийг мэддэг.	
Бусдын дарамт шахалтгүйгээр цагт нь амжуулахыг эрмэлздэг.	
Мэдэхгүй байгаагаа бусдад илэрхийлдэг.	
Таны амьдралд юу утга учиртай, таны амьдрал хаашаа чиглэж буй талаар эргэцүүлдэг.	
Бясалгал хийдэг.	
Залбирдаг.	
Дуулдаг.	
Хүүхэдтэй цагийг өнгөрөөдөг.	
Сүсэг бишрэлтэй.	
Итгэж үнэмшиж байгаа зүйлдээ хувь нэмрээ оруулдаг.	
Танд урам зориг өгдөг зүйлсэд (ном зохиол, түүх, яриа, хөгжим гэх мэт) дуртай.	

Ажлын байр болон мэргэжилдээ тавих анхаарал халамж

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Ажлаасаа хөндийрч завсарлага авдаг. (өдрийн цай уух гэх мэт)	
Хамтран ажиллагсадтайгаа ярилцахад цаг гаргадаг.	
Тодорхой зорилгыг биелүүлэхийн тулд чимээгүй, төвлөрдөг.	
Таны сэтгэл хөдөлж, урам зориг авдаг ажлууд тодорхой байдаг.	
Үйлчлүүлэгч болон хамтран ажиллагсадтайгаа тодорхой хил хязгаар тогтоож харилцдаг.	
Ажлын ачааллаа тэнцвэржүүлж чаддаг.	
Ажиллах орчноо өөрт тухтай байдлаар тохижуулсан.	
Удирдах ажилтнаас заавар, зөвлөмж авдаг.	
Өөрийн хэрэгцээ шаардлагад тохируулан хэлэлцээр хийдэг. (үр ашиг, цалин хөлс гэх мэт)	
Үе тэнгийн дэмжих бүлэгтэй.	
Мэргэжлийн ашиг сонирхлын хувьд гэмтэлгүй бүсийг бий болгодог.	

Тэнцвэрт байдал

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Ажил болон амьдралынхаа тэнцвэрт байдлыг бий болгохыг хичээдэг.	
Ажил, гэр бүл, харилцаа холбоо, тоглох болон амрах тэнцвэрт байдлыг бий болгохыг хичээдэг.	

Би дараах төрөл тус бүрээс үүнийг сайжруулахын тулд идэвхтэй ажиллах болно. Үүнд:

Бие махбод	
------------	--

Сэтгэлзүй	
Сэтгэлийн хөдөлгөөн	
Оюун санаа	
Ажлын байр болон мэргэжил	
Тэнцвэрт байдал	

Үйлчилгээний үе шатуудыг шалгах хуудас

АГУУЛГА	ХАРГАЛЗАХ ОНОО
Үйлчилгээний хугацаа, оролцогч талууд, тэдний эрх, үүрэг, хариуцлага тодорхой байх	
Үйлчлүүлэгчийн үйлчилгээний талаарх хүлээлт тодорхой болсон байна.	
Зорилго, зорилтууд тодорхой бөгөөд хамтран дэвшүүлсэн байна.	
Зорилго, зорилтын биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг харилцан тохирсон байна.	
Уулзалтын хугацаа, давтамж зэргийг тодорхойлсон байна.	
Хэрэгжүүлэх үйлчилгээг харилцан тохирсон байна.	
Нууцлалын талаарх асуудлын талаар хэлэлцэж, зөвшилц-сөн байна.	
Үйлчилгээ хэрхэн төгсөх, кейс хэрхэн хаагдах талаар харилцан зөвшилцсөн байна.	
Харилцаа холбооны хэм хэмжээ, хил заагийг тодорхой ойлголцсон байна.	

Нөлөөллийн ажил

ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллахад бэлгийн чиг баримжааны талаарх ойлголт, бусад хүмүүсээс ирэх сөрөг үзэл хандлагуудын нөлөөлөл, ЛБГТИК+ олон нийт дэх дэд соёл болоод тусгай хэм хэмжээ, нормын талаарх мэдлэг, эрүүл мэндийн хувьд тулгарах асуудлууд, ЛБГТИК+ олон нийтэд тохирох нийгэм соёлын хэллэг зэрэг олон талын үндсэн ойлголт мэдлэгтэй байхыг шаарддаг.

ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллах хамгийн сайн практик нь ЛГБТИК+ олон нийтийн талаарх хэвшмэл буруу ойлголтоос ангид аюулгүй, оролцоог хангасан, үйлчилгээний орчин бүрдүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах, тулгарч болох эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлох, тэдний өдөр тутмын амьдралд тохиолдож болох стрессийн нийгэм соёлын хүчин зүйлүүдийг тодорхойлоход үйлчлүүлэгчид туслах, түүнчлэн гэр бүлдээ ЛГБТИК+ талаар нээлттэй болоход нь туслах боломж зэрэг ордог.

Нийгмийн ажилтнууд нь олон нийтийн нөөц бололцоог мэддэг байх шаардлагатайг сайн туршлагууд онцолж байгаа бөгөөд нэмэлт дэмжлэг тусалцаа нь үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхэд тусалдаг байна.(Хэбуорт нар 2013)

Үүний нэг жишээ бол ЛБГТИК+ дэмжих бүлгүүд бөгөөд сэтгэцийн эрүүл мэнд болоод эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн дэмжлэг тусалцаа, ЛГБТИК+ хүмүүсийн онцлогтой холбоотой үнэн зөв мэдээллийг олж авах сүлжээ зэрэг багтдаг байна.

ЛБГТИК+ үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ хүргэхийн тулд тэдний талаар тусгайлсан сургалтыг нийгмийн ажилтнуудад зохион байгуулах нь маш чухал болохыг мэргэжлийн ном, сурах бичгүүдэд онцолсон байдаг (Юбанкс-Картер нар 2005, Грийн нар, 2009).

Жишээлбэл: Аливаа сургалтын хөтөлбөрүүд нь ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажиллахад хувийн болон мэргэжлийн үнэт зүйлсээ баримтлан ажиллаж буй мэргэжилтнүүдэд туслахуйц байх хэрэгтэй. Мөн ЛГБТИК+ тусгай сургалтад хамрагдахаас гадна ЛГБТИК+ үйлчлүүлэгчтэй ажилласан клиник туршлагатай хүмүүс нь сайн зааварчлагч, чиглүүлэгч байдаг гэж үздэг.

Нийгмийн ажилтнууд нь доорх ойлголт, мэдлэг, ур чадварыг эзэмших ёстой байдаг.

Ойлголтын хувьд:

- Өөрийн болон бусдын бэлгийн чиг баримжаатай холбоотой мэдрэмж, үнэт зүйл, итгэл үнэмшлээ таньж мэдэх, ойлгох;
- Мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэх явцдаа нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг, ялангуяа бэлгийн чиг баримжаатай холбоотой дүрмүүдийг баримтлан ажиллах;
- ЛГБТИК+ хүмүүсийг дарамтлах аливаа үйлдлийн эх сурвалж, зорилго, баталгаа, нотолгоог олж мэдэх.

Мэдлэгийн хувьд:

- Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн илэрхийлэлтэй холбоотой онолын ойлголтуудыг ойлгож мэдэх;

- ЛГБТИК+ иргэний хөдөлгөөнүүдийн түүхийг мэдэх;
- Хүүхэд нас, өсвөр нас, үерхэл нөхөрлөл, гэр бүл, идэр, ахмад нас зэрэг хүний хөгжлийн үе шатуудын бодит байдлыг авч үзэх;
- Бэлгийн чиг баримжаа ба шашин, арьс өнгө, үндэс угсаа, нас, хүйс зэргийн харилцан хамаарлыг ойлгох;
- ЛГБТИК+ олон нийттэй холбоотой өнөөгийн судалгаануудад шүүмжлэлтэй хандах, дүн шинжилгээ хийх;
- ЛГБТИК+ олон нийтийн нийгмийн, эрх зүйн, эдийн засгийн орчин дахь өнөөгийн асуудлуудыг ойлгож мэдэх.

Ур чадварын хувьд:

- ЛГБТИК+ хүмүүст тохиромжтой биологи, сэтгэлзүй, нийгмийн үнэлгээнүүдийг ашиглах, нийгмийн ажлын практикт хэрэгжүүлэх;
- ЛГБТИК+ олон нийтэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай (нээлттэй болох, хорт зуршлын хэрэглээ, амиа хорлолт, ХДХВ/ДОХ, гэр бүлийн хүчирхийлэл гэх мэт) орчнуудыг тодорхойлох;
- ЛГБТИК+ хүмүүсийн талаар микро, мезо, макро түвшинд нөлөөлөх Олон улсын нийгмийн ажилтны холбооны ёс зүйн дүрмийн удирдамжаар дамжуулан АНУ-ын Охайо мужаас нийгмийн ажилтнуудад микро, макро түвшинд аль алинд нь ЛГБТИК+ үйлчлүүлэгчдэд нөлөөлөх арга замуудын жагсаалтыг гаргасан байна. Үүнд:

Микро түвшин дэх нөлөөллийн ажил

- Үйлчлүүлэгчээс өөрийг нь хэн гэж танилцуулахаа асуух;
- Бусад өдрүүдэд үйлчлүүлэгч тань өөр төлөөний үг хэрэглэдэг эсэхийг асуух;
- Тэднийг нэрээр нь дуудахаас нь илүүтэйгээр үйлчлүүлэгчийн хэлж буй хүйсийн төлөөний үгийг хэрэглэж байх;
- Нэр томъёонуудыг мэдэж байх;
- Үйлчлүүлэгчийн тодорхойлж буй нэр томъёог ашиглах;
- Ариун цэврийн өрөөний бодлогоо өөрчлөх, тэдний хүйсийн илэрхийлэлд тохирсон ариун цэврийн өрөө ашиглах боломжийг олгох;
- Сургалт, семинар, хэлэлцүүлгээс ЛГБТИК+ соёлын талаар мэдлэгтэй болох, өөрийгөө хөгжүүлэх;
- Хүйсийн буруу төлөөний үг хэлэх зэрэг жижиг алдаа гаргасан тохиолдолд энгийнээр уучлалт гуйх;

- Тэднийг дэмжиж буйгаа илэрхийлэн бахархлын солонгон тугийг харуулах;
- Үйлчлүүлэгчийг хүйсээ өөрөө бичих боломж олгох;
- ЛГБТИК+ үйлчлүүлэгчдэд тохирч болох сүүлийн үеийн арга хэмжээнүүдийн талаар мэддэг байх.

Макро түвшин дэх нөлөөллийн ажил

- Цэргийн хorigийг зогсоохыг уриалах;
- Ажлын байран дахь ялгаварлан гадуурхахын эсрэг бодлогыг ухуулан таниулах буюу нийтийн эрх ашгийг хамгаалсан бодлогыг дэмжих;
- Боловсролын тогтолцоонд жендэрийн талаарх тодорхойлолт буюу үзэл;
- санааг тусгах;
- Ажлын байрны бодлогыг ЛГБТИК+ хүмүүст ээлтэй, хүртээмжтэй болгох;
- Даатгалын компаниудад тусгайлан анхаарал тавихын тулд өмгөөллийн туслалцаа үзүүлэх;
- ЛГБТИК+ хүмүүсийн аюулгүй, таатай орчныг бий болгохын тулд орон нутгийн нөөц бололцоог ашиглах;
- ЛГБТИК+ хүмүүсийг аливаа ялгаварлалгүй тэгш эрхтэйгээр дэмжих, жагсаал цуглаан хийх, дуу хоолойгоо илэрхийлэх боломжийг олгох.

Ажлын байранд ЛГБТИК+ хүнийг хэрхэн дэмжих вэ?

- **Үгний сонголт ба хэрэглээ:** Үгний сонголт болон хэрэглээгээр дамжуулан бид бусдыг дэмжих, үгүйсгэх, ялгаварлах боломжтой байдаг. Тиймээс зүгээр л юу хэлэх, юу хийхээ мэдэхгүй бол бусдын хүйс, бэлгийн чиг баримжааны талаар ярихаас зайлсхийх хэрэгтэй.
- **Байгууллагын харилцаа, соёл:** Байгууллагын харилцаанд хувь хүн бүр нас, бие, сэтгэлзүйн онцлог шинж байдлын хувьд ялгаатай болохыг ойлгож, дэмжсэн харилцаа холбоо, соёлыг төлөвшүүлэх хэрэгтэй.
- **Байгууллагын орчинд:** Хувцас солих болон бие засах өрөөний хувьд трансжендэр хүнд ашиглахад тохиромжтой байх хэрэгтэй. Мөн та ЛГБТИК+ олон нийтийг ойлгодог гэсэн ойлголт болон 6 өнгийн далбааны зургийг байрлуулах боломжтой.
- **Бодлого, төлөвлөлт:** Байгууллагын бодлого, төлөвлөлтийн хувьд үл ялгаварлах бодлого байх шаардлагатай. Ажлын байранд хувь хүнийг ялгаатай байдлаар нь онцлон авч үзэх, дарамт шахалт учруулах, үл хайхрах ёсгүй.

ЛГБТИК+ хүмүүс ба тэдний гэр бүл

Гэр бүлийн зүгээс үл зөвшөөрөх, зөрчилдөөн үүсэх цаашлаад ЛГБТИК+ найзууд, арга хэмжээнүүдэд оролцуулахаас татгалзах, гэр бүлийн хүчирхийлэл үүсэх нь ЛГБТИК+ хүүхдүүдийн эрүүл мэнд болоод сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд орох өндөр эрсдэлийг авчирдаг байна.

Гэр бүлийн зарим зан үйл нь ЛГБТИК+ хүүхдийг эрүүл мэндийн болоод сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай болох үйл явцыг нэмэгдүүлж байдаг.

Зайлсхийх, зугтах зан үйл

- ЛБГТИК+ үзэл баримтлалаас нь болж хүүхдээ цохих, алгадах, бие махбодыг нь гэмтээх;
- Хэл амаар доромжлох, нэр хоч өгөх;
- Гэр бүлийнхэнтэйгээ оролцдог үйл явдлууд, үйл ажиллагаануудаас хасах;
- ЛБГТИК+ найзууд болон холбоотой бусад үйл ажиллагаануудад оролцохыг хориглох;
- ЛГБТИК+ байдлаасаа болж ялгаварлан гадуурхагдах тохиолдолд хүүхдээ буруушаах
- Хүүхдээ илүү эрэгтэйлэг эсвэл эмэгтэйлэг байхыг шаардах
- Хүүхдээсээ болж тэд ичиж байгаагаа эсвэл бусад хүмүүс тэднийг яаж харж байгаа талаар хэлэх;
- Хүүхдийн ЛБГТИК+ байдлын талаарх хэнд ч хэлэлгүй гэр бүлийнхээ хүрээнд нууцлах.

Хүүхдийнхээ бие махбодын болоод сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг нь бууруулах, тэдний сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэдэг гэр бүлийн зан үйл гэж байдаг.

Туслах, дэмжих зан үйл

- ЛГБТИК+ байдлын талаар хүүхэдтэйгээ ярилцах;
- Хүүхэд нь ЛГБТИК+ гэдгээ хэлэх үед эсвэл хүүхдийнхээ талаар мэдсэн тохиолдолд түүнд хайртайгаа илэрхийлэх;
- Өөрт нь таагүй санагдаж байсан ч хүүхдийнхээ ЛГБТИК+ байдлыг нь дэмжих;
- ЛГБТИК+ байдлаасаа болоод хүүхэд нь ад үзэгдэх тохиолдолд хүүхдэдээ нөлөөлөх;

- Гэр бүлийнхээ бусад гишүүдэд ЛГБТИК+ хүүхдээ хүндэлж байхыг шаардах;
- Хүүхдээ ЛГБТИК+ байгууллага болон бусад үйл ажиллагаануудад оролцуулах, хүргэж өгөх;
- Ирээдүйд ЛГБТИК+ насанд хүрэгчийн үүднээс хийх сонголтуудын талаар ярилцах;
- ЛГБТИК+ хүмүүсийг дэмжлэг цугларалтыг дэмжиж ажиллах
- Хүүхдийнхээ ЛГБТИК+ найзуудыг урих, гэр бүлийнхээ арга хэмжээнүүдэд оролцуулах;
- Хүүхдийнхээ хүйсийн илэрхийллийг нь дэмжих;
- Хүүхэд чинь насанд хүрсэн ч аз жаргалтай ирээдүй байгаа гэдэгт итгэх.

ЛГБТИК+ залуучууд, гэр бүлтэй ажилладаг мэргэжилтнүүд нь дараах зүйлд анхаарах ёстой.

- ЛГБТИК+ залуучуудад болон гэр бүлийнхэнд зориулж ЛГБТИК+ хүүхдийн- хээ эцэг эх, асран хамгаалагчдад хэрхэн туслахыг зааж өгөхийн тулд олон нийтийн болон онлайн нөөц, боломжийг тодорхойлох.
- Эцэг эхчүүд, асран хамгаалагчид нь ЛГБТИК+ хүүхдүүдээ дэмжих, анхаарал халамж тавих шинэ арга замуудад суралцахад туслахын тулд үлгэр жишээ гэр бүлийн орчныг бүрдүүлэх хэрэгтэй.
- Өсвөр насны хүүхдүүдээс бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийллийнхээ талаар гэр бүлийнхэндээ хэлэхэд ямар хариу үйлдэл үзүүлж байсан талаар асууж зөвлөх.
- Дэмжлэг болохуйц зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, ЛГБТИК+ олон нийтийн байгууллага, нөөц боломж, хөтөлбөрүүдэд зуучлах.
- Эцэг эхчүүдэд өсвөр насныхны ЛГБТИК+ илэрхийллийн талаар сөрөг хариу үйлдлүүд нь хүүхдүүдийн эрүүл мэнд болоод сэтгэцийн эрүүл мэндэд маш ноцтой нөлөөлдөг гэдгийг хэлж тайлбарлах, хүүхдүүдийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд өртөх эрсдэлийг нь нэмэгдүүлж буй зан үйлээ бууруулахад тэднийг дэмжиж ажиллах.
- ЛГБТИК+ хүүхдүүдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, аливаа эрсдэлд өртөхөөс хамгаалахад нь туслахуйц гэр бүлийн дэмжлэгийн аливаа үйл ажиллагаа, зан төлөвийг дэмжих болно.

2.4 ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГУУД

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Чех
Хураангуй:	2009 онд Бэлгийн цөөнхийн хороотой. Тус хороо нь Хүний эрхийн төрийн зөвлөлийн нэг хэсэг бөгөөд ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг хэлэлцдэг. Европын тэгш эрхийн жилийг тохиолдуулан хүний эрх, цөөнхийн сайдын байгуулсан Бэлгийн цөөнхийн асуудлаарх ажлын хэсгийн үйл ажиллагааг явуулдаг. Энэхүү ажлын хэсэг нь ЛГБТИК+ цөөнхийн байдлыг судалж үзсэн байдаг.

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Франц
Хураангуй:	2008 онд Ялгаварлан гадуурхалтын эсрэг тэгш боломжийн хорооноос залуучуудад чиглэсэн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх аян өрнүүлсэн. Өсвөр насныхан, залуучууд, насанд хүрэгчид гэх мэт 4,1 сая хэрэглэгчтэй вебсайт нээсэн. Ялгаварлан гадуурхалтын эсрэг тэгш боломжийн хорооны стратегийн дагуу боловсролын яаманд сургуулийн хичээлийн хөтөлбөр болон ном сурах бичгүүдэд ЛБГТИ олон нийтийн талаарх сөрөг тогтсон ойлголтуудыг өөрчлөх, урьдчилан сэргийлэх үүднээс хүсэлт илгээсэн байна.

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Герман
Хураангуй:	Ялгаварлангадуурхалтын эсрэг албанаас зохион байгуулсан судалгааныхаа үр дүнг 2009 оны 4 сард хэвлүүлсэн бөгөөд тус судалгаа нь хүн амын дунд шашин шүтлэг, арьс өнгө, үндэс угсаа, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, хүйсийн баримжаа илэрхийлэл зэргээр ялгаварлан гадуурхах үзэл нь Герман улсад тулгамдсан асуудал болж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой байсан юм. Хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхах үзэл нь нийгэмд маш бат бэх тогтсон байгаа нь тус судалгаагаар тогтоогдсон байна.

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	Трансжендер
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Их Британы нэгдсэн вант улс
Хураангуй:	Худалдаа аж үйлдвэрийн танхимын санхүүжилтээр ажлын байрны сайн туршлагын талаар ажил олгогч нарт зориулсан гарын авлагыг боловсруулсан бөгөөд тус гарын авлага нь Хүйсийн шилжилт: Ажил олгогч нарт зориулсан гарын авлага нэртэйгээр хэвлэгдсэн байна.

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Мальта

Хураангуй:	Мальта улсын томоохон үйлдвэрчний эвлэлүүдийн нэг болох Хөдөлмөр эрхлэгчдийн ерөнхий хорооноос Твэмин нэртэй бодлогын баримт бичгийг гаргасан бөгөөд энэхүү баримт бичиг нь ЛГБТИК+ хүмүүсийг ажлын байрандаа тэгш эрх эдлэх, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зорилготой юм. Тус бодлогын баримт бичигт тусгагдсан зарим стратегийн талаар дурдвал: • ЛБГТИК+ ажилтнуудын эрхийг хамгаалах • Ажлын байран дээрх ЛГБТИК+ хүмүүст тулгарч буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцэх үндэсний хэмжээний хурал, уулзалт зохион байгуулах олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх үүднээс сайн туршлагуудын талаарх шинэ мэдлэг, мэдээллүүдийг өгөх • Гишүүд, ажилтнууддаа ЛГБТИК+ асуудлаар сургалт зохион байгуулах • Ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэхийн тулд Хөдөлмөр эрхлэгчдийн ерөнхий хорооноос эерэг үлгэр дуурайл, арга хэмжээ авч байгааг олон нийтэд зарлах, бодлогын баримт бичгийг хэвлүүлэх • ЛГБТИК+ олон нийтийн зүгээс зохион байгуулж буй бусад үйл ажиллагаануудад оролцох • ЛГБТИК+ ажилтны эрх ашгийг хамгаалах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий зохицуулагчийг томилох зэрэг стратегүүдийг баталсан байна.
-------------------	---

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Нидерланд
Хураангуй:	20 гаруй жил Голландын засгийн газар ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүлээн зөвшөөрөх талаар бодлого боловсруулсан байдаг. 2007 оны 11-р сард тус засгийн газар энэ сэдвээр 2008-2011 оны бодлогын баримт бичигтээ тусгасан байна. Энэхүү бодлогын баримт бичгийн гол зорилго нь Нидерландад ЛГБТИК+ хүмүүсийг нийгмээрээ хүлээн зөвшөөрөх явдлыг нэмэгдүүлэх явдал юм. Тус бодлогын баримт бичгийн дурдсан хугацаанд үндсэн 5 зорилгыг багтаасан байна. Үүнд: • Хүн амын бүлгүүд дэх хэлэлцүүлгүүдийн сэдвийг ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаар болгож, түүнийг баталгаажуулах; • ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг арилгах; • Иргэний нийгмийн байгууллагууд болоод орон нутаг, үндэсний хэмжээний байгууллагуудыг дэмжих; • ЛГБТИК+ хүмүүст ээлтэй сургууль, ажлын байрны орчин бий болгоход дэмжлэг үзүүлэх; • Олонулсын болоод Европын салбарт үүргээ идэвхтэйгээр биелүүлэх гэх мэт. Бэлгийн чиг баримжаатай холбоотой ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх нь тус улсын Гадаад хэргийн яамны хүний эрхийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм. Энэхүү баримт бичиг нь НҮБ болоод Европын холбоотой хамтарсан хэд хэдэн хэлэлцээр хийхэд гол үүрэг гүйцэтгэсэн байна.

Сайн туршлага:	Ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Төрийн байгууллага
Улс:	Польш
Хураангуй:	2007 оны Европын Холбооны “Бүх нийтийн тэгш боломжийг хангах жил”-ийн хүрээнд Польшийн Хөдөлмөр, нийгмийн бодлогын яамнаас ойлголт мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр кампанит ажил явагдсан. Кампанит ажлын хэрэгжилт, зохион байгуулалтад Польшийн Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам болон Гэр бүл, эмэгтэйчүүдийн хэлтэс хамтран ажилласан байна. Кампанит ажлын үеэр бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах асуудлаар шинжээчдийн бүлгийг оруулсан хэлтсийн зөвлөх байгууллага болон Зөвлөх хороо байгуулагдсан байна. Европын Холбооны «Бүх нийтийн тэгш боломжийг хангах жил»-ийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны хамгийн гол үр дүн нь “Польш дахь бэлгийн цөөнхийн нөхцөл байдлын судалгаа” байсан юм.

Сайн туршлага:	Хамтын ажиллагаа
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+ олон нийт
Оролцогч:	Бодлого
Улс:	Румин улс
Хураангуй:	2005-2009 онд зохион байгуулагдсан гей жагсаалын үеэр орон нутгийн цагдаа нар болон цагдаагийн албаны ажилтнууд тус жагсаалд оролцож байсан нь магадгүй сайн туршлагуудын нэг болж болох юм. Тэдгээр хүмүүс нь зохион байгуулагч байгууллагуудтай маш сайн хамтарч ажиллаж байсан бөгөөд нацист залуучууд, хөл бөмбөгийн клубууд, шашны хэт даврагсдаас жагсаалд оролцогчдыг хамгаалсан байсан байна.

Сайн туршлага:	Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн тайлан мэдээ/Ойлголт ; мэдлэгийг дээшлүүлэх
Зорилтот бүлэг:	ЛГБТИК+
Оролцогч:	Цагдаагийн байгууллага
Улс:	Герман улс
Хураангуй:	ЛГБТИК+ олон нийттэй харилцах цагдаагийн тусгай тасаг байгуулсан. Холбооны улсууд, хэд хэдэн хот болон цагдаагийн зарим агентлагуудад гей, лесбиянчуудын эсрэг хүчирхийлэл, ЛГБТИК+ олон нийттэй холбоотой бусад асуудлаар тусгайлан ажилладаг цагдаагийн тусгай төлөөлөгч ажиллуулж эхэлсэн байдаг. Энэхүү төлөөлөгч нар нь гей, лесбиян хүмүүсийн холбоод, байгууллагуудтай холбоо тогтоох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх түүнчлэн ЛГБТИК+ асуудлаар олон нийтэд үйлчилдэг байна.

ГУРАВ. БЭЛГИЙН ЦӨӨНХ ХҮМҮҮСТЭЙ АЖИЛЛАХ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДТЭЙ АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Олоннийтэд тусламж үзүүлдэг бүхийлсалбарын мэргэжилтнүүдэд эдгээр асуулт нь хамааралтай. Тэр ч утгаараа Америкийн Сэтгэл судлалын холбоо 1990 оноос хойш ЛГБТИК+ хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой судалгаануудыг хийсээр, агуулга болон ёс зүйн хэм хэмжээг багтаасан мэргэжлийн удирдамжуудыг боловсруулсаар ирсэн. 2000 онд АССХ-оос бэлгийн чиг баримжааны цөөнх хүмүүстэй ажиллахад зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн 16 зүйлтэй зааварчилгаа боловсруулсан нь ЛГБ хүмүүстэй ажиллах бүрэн хангалттай үндэс биш ч, хандлага, мэдлэг, ур чадвар гэсэн үндсэн мэргэжлийн ёс зүй болон агуулгын асуудлыг хамардаг.

1. Хандлага:

Удирдамж 1-6: сэтгэл зүйчид ЛГБ хүмүүсийн талаарх өөрсдийн хувь хүмүүсийн хандлагаа ойлгож, үйлчлүүлж буй ЛГБ хүмүүсийн хэрэгцээг бүрэн ойлгох, тэдэнд хэрэгцээтэй тусламжийг тодорхойлон өгөх.

2. Найз нөхөрлөл ба гэр бүл

Удирдамж 7-10: сэтгэл зүйчид ЛГБ хүмүүсийн гэр бүлүүдийн тухай ойлголт- той байх, ЛГБ хүмүүсийн харилцаа чухлыг хүндэтгэх, ЛГБ эцэг эхчүүдийн нөхцөл байдлыг хүндэтгэх.

3. Ялгаатай байдал

Удирдамж 11-16: сэтгэл зүйчид ЛГБ залуучуудын онцлог асуудал ба эрсдэл, шашин, соёл, арьсны өнгө болон үндэс угсааны нөлөө ЛГБ хүмүүст хэрхэн нөлөөлдгийг мэдэх.

4. Нийгэм, эдийн засгийн асуудал болон ажил хөдөлмөр

Удирдамж 17-18: ЛГБ хүмүүсийн нийгэм, эдийн асуудал ба хөдөлмөрийн орчин нь ЛГБ хүмүүсийн сэтгэл зүйд гүн нөлөөлдөг болохыг ойлгох.

5. Боловсрол

Удирдамж 19-20: сэтгэл зүйчид ЛГБ хүмүүст зориулсан сэтгэл зүйн боловсрол олж авах, ЛГБ асуудлаар судалгаа хийх, түгээх хэрэгтэй.

“Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж” нь нэгд, лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чиглүүлэг мөн ба хоёрт, үнэлгээ, интервенц, харилцаа, ялгаатай байдлууд, боловсрол, сургалт, судалгаанд шаардагдах үндсэн мэдээлэл ба цааш дэлгэрүүлж ашиглах эх сурвалжуудын цогц юм. Энэхүү удирдамж нь “Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх удирдамж” (Division 44/Committee on Lesbian, Gay, and Bisexual Concerns Joint Task Force on Guidelines for Psychotherapy with Lesbian, Gay, and Bisexual Clients, 2000)-д суурилсан ба “Америкийн сэтгэл судлалын холбооны үйлчилгээний удирдамж боловсруулах, үнэлэх шалгуур” (APA, 2002a)-ыг хангасан болно. Энэ удирдамжаар сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүст ээлтэй үйлчилгээ үзүүлэх, эдгээр хүмүүсийн тухай бодит боловсрол мэдлэгийг бусдад олгох, судалгаа хийхэд дөхөм болох юм.

Удирдамж хэмээх нэр томъёо нь сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаандаа сэтгэл зүйчдийн мөрдөх дүрэм, зарчим, тодорхойлолт юм. Удирдамж гэдэг нь жишгээс өөр. Жишиг нь заавал мөрдөх мөн чанартай ба мөрдүүлэх механизмыг агуулсан байдаг. Тиймээс энэ удирдамж нь биелүүлэхийг хичээвэл зохилтой зорилгыг агуулсан. Мөн энэ удирдамж нь сэтгэл зүйн мэргэжлийг системчилсэн байдлаар цааш хөгжүүлэх, сэтгэл зүйчдийн практикийг мэргэжлийн өндөр түвшинд явуулахыг хангахад чиглэсэн юм. Энэ удирдамжийг заавал даган мөрдөх ёстой, эсвэл энэ удирдамжид бүх нөхцөл байдал бүрэн гүйцэд багтсан гэсэн үг биш ба энэ удирдамж бүх клиникийн нөхцөлд тохирно гэсэн үг биш юм. Удирдамжийг сэтгэл зүйчдийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээнээс дээгүүр, тодорхойлогч хэмжүүр хэмээн үзэх ёсгүй. Практикийн удирдамж нь мэргэжилтнүүд хэрхэн үйл ажиллагаагаа явуулах ёстой, сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээний үед ялангуяа анхаарвал зохих асуудлуудыг түлхүү багтаасан. Эдгээр удирдамж нь одоогоор мөрдөж буй АССХ-ны бодлогод нийцсэн. Холбооны болон мужийн хууль, тогтоомж практикийн удирдамжаас чухал ба АССХ-ны сэтгэл зүйчдийн ёс зүйн зарчим ба үйл ажиллагааны дүрэм (APA, 2002b) -тэй нийцсэн.

Үндэслэл

1975 онд АССХ “ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай байх нь тунгаан бодох чадвар, сэтгэл зүйн тогтвортой байдал, итгэл хүлээх чадвар болон тухайн хүний бусад нийгэм, мэргэшлийн чадвар, чадавхжуулах доголдсон гэсэн үг биш” хэмээх шийдвэрийг гаргасан ба “ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчин хэмээн буруугаар ойлгож ирсэн стигмаг арилгахын төлөө сэтгэцийн эрүүл мэндийн бүх мэргэжилтнүүд манлайлах үүрэг гүйцэтгэх ёстой” хэмээн уриалжээ (Conger, 1975, х. 633). Энэ чухал

бодлогын бичиг баримтыг баталснаас хойш АССХ нь лесбиян, гей, бисексуал хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө үйл ажиллагааг манлайлсаар, эдгээр хүмүүстэй ажиллах, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн асуудлыг судлах, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн тухай нийгэмд боловсрол олгоход туслах мэдлэг, арга зүйн хэрэгслээр хангасаар ирсэн билээ. 2009 онд АССХ дахин “^бэлгийн чиг баримжаагаа тодорхойлохуйгаас үл хамааран ижил хүйсийн бэлгийн болон хайр дурлалын сэдэл, мэдрэмж, зан үйл нь хүний бэлгийн мөн чанарын энгийн ба эерэг вариаци мөн билээ” (APA, 2009a, x. 121) хэмээн баталгаажуулжээ.

1975 оны шийдвэр гарснаас хойш хорин таван жилийн дараа АССХ-ны бодлого ба сэтгэл зүйчдийн лесбиян, гей, бисексуал хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх практик ихээхэн зөрүүтэй байгааг (Garnets, Hancock, Cochran, Goodchilds, Peplau, 1991) баримтжуулан судалжээ. Эдгээр болон бусад (Fox, 1996; Greene, 1994b; Nystrom, 1997; Pilkington & Cantor, 1996) судлаачдын үзсэнээр сэтгэл зүйчдэд лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахад илүү мэдлэг, сургалт хэрэгцээтэй байгааг хэлжээ. Энэ шалтгаанаар энэхүү “Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх удирдамж” (Division 44/Committee on Lesbian, Gay, and Bisexual Concerns, Joint Task Force on Guidelines for Psychotherapy with Lesbian, Gay, and Bisexual Clients, 2000, англиас монгол руу орчуулсан Н.Анараа, ЛГБТ Төв, 2011)-ийг боловсруулсан билээ.

Хэрэгцээ

Удирдамжийг шинэчлэх нь цагаа олсон зүйл. Учир нь лесбиян, гей, бисексуал сэтгэл зүйн талбарт ихээхэн өөрчлөлтүүд гарсан. Өмнө нь байсан сэдвүүд илүү хөгжингүй болсон ба лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллаж буй хүмүүсийн мэргэшлийн сонирхол гүнзгийрснээр шинэ сэдвүүд бий болж, ном зүй нь ч өргөссөн. Түүнчлэн хүн амд суурилсан судалгаа хөгжихийн хэрээр судалгааны чанар ч үнэмлэхүй сайжирсан.

Өнгөрсөн арван жилд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг эргээд эмгэг хэмээн тодорхойлохыг эрмэлзсэн байгууллага, нөлөөллийн бүлгүүдийн үйл ажиллагаа эрчимжсэн (Haldeman, 2002, 2004). Арга зүйн хувьд эрүүл, АССХ-ны ёс зүйн дүрэмд үндэслэсэн ба одоогоор мөрдөж буй АССХ-ны бодлогод нийцсэн удирдамж гаргах нь лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд нэн чухал билээ. Эдгээр удирдамж нь үндэсний ба олон улсын хэмжээнд практикт хэрэглэгдсээр ирсэн ба төрийн бодлогын нэг хэсэг болсоор ирсэн. АССХ-оос батлагдсан өдрөөс хойш арван жилийн дараа хүчин төгөлдөр байхаа болих буюу шинээр батлагдана.

Нийцэхүй

Эдгээр удирдамж нь АССХ-ны ёс зүйн дүрэм (АРА, 2002b)-д үндэслэсэн ба лесбиян, гей, бисексуал асуудалд хамааралтай АССХ-ны баримталсаар ирсэн бодлоготой нийцнэ. Эдгээр бодлогод Ижил хүйстэн хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт (Conger, 1975); Бэлгийн чиг баримжаа, эцэг эх ба хүүхдүүд (Paige, 2005); Бэлгийн чиг баримжаа ба гэрлэлт (Paige, 2005); үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргүүд (Paige, 2005); Лесбиян, гей, бисексуал хүмүүсийг ялгаварласан хууль, тогтоомж, санаачилгыг эсэргүүцэх нь (Paige, 2007); Бэлгийн чиг баримжаатай холбоотой сэтгэл санааны хүндрэл ба бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагааны тухай хариу үйлдэлд баримтлах зохистой хандлагын талаарх шийдвэр (АРА, 2009a) зэрэг багтана. Энэхүү удирдамж нь ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжаа нь эмгэг биш гэдгийг баталгаажуулсан байр суурьтай байдаг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн бусад томоохон нийгэмлэгүүд (Америкийн сэтгэц, эмгэг судлалын холбоо, 1974; Америкийн гэр бүл, гэр бүлийн эмчилгээний нийгэмлэг, 1991; Америкийн сэтгэл зүйн зөвлөгөөний нийгэмлэг, 1996; Канадын сэтгэл зүйн холбоо, 1995; Нийгмийн ажилтны үндэсний нийгэмлэг, 1996)-ээс баримталдаг бодлоготой нийцсэн.

Боловсруулсан үйл явц

Эдгээр удирдамжийг 44-р салаа/Лесбиян, гей, бисексуал, трансжендэр асуудлын хорооноос хамтран боловсруулсан юм. Удирдамжийг шинэчлэн найруулах үйл явцыг 44-р салаа, АССХ-ны удирдах зөвлөлөөс санхүүжүүлсэн. Удирдамжийг дагалдах ном зүй нь АССХ-ны ёс зүйн дүрэм (АРА, 2002b) болон АССХ-ны бусад бодлоготой нийцсэн. Түүнчлэн текстийн хэрэглээ хэсгийг сэтгэл зүйчдэд илүү мэдээлэл, туслалцаа өгөх үүднээс дэлгэрүүлсэн болно.

Нэр томьёоны тодорхойлолт

Хүйс гэдэг нь хүний биологийн статусыг хэлэх ба ерөнхийдөө эр, эм, эсвэл интерсекс (эр, эмийг ялгах шинж төрхийг хослуулсан) хэмээн хуваадаг. Биологийн хүйсийг тодорхойлогч зүйлд бэлгийн хромосом, гонад, нөхөн үржихүйн дотоод эрхтэн ба бэлэг эрхтэн багтана.

Жендэр гэдэг нь хүний биологийн хүйстэй холбоотойгоор тухайн нийгмээс тухайн хүйсийн хүмүүсийн илэрхийлэх ёстой хэмээн үздэг хандлага, мэдрэмж, зан үйлийг хэлнэ. Нийгмийн хүлээлтэд нийцсэн зан үйлийг жендэр-норматив, харин эдгээрт нийцээгүй зан үйлийг жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйл хэмээн үздэг.

Хүйсийн баримжаа гэдэг нь “өөрийгөө эр, эм, эсвэл трансжендэр хэмээн мэдрэх мэдрэмж” (Америкийн сэтгэл судлалын холбооны асуулт хариулт, 2006) юм. Өөрийгөө мэдрэх мэдрэмж нь биологийн хүйсээс ялгаатай байх тохиолдолд тухайн хүн өөрийгөө транссексуал эсвэл бусад трансжендэр ангиллаар тодорхойлж болдог (Gainor, 2000).

Хүйсийн илэрхийлэл гэдэг нь өөрийн жендэрээ тухайн нийгэмд ямар байдлаар илэрхийлж буй байдал ба үүнд жишээлбэл хувцаслалт, ярих байдал, сонирхол гэх мэт зүйл багтдаг. Хүний хүйсийн илэрхийлэл нь нийгмээс тогтоосон хүйсийн хэм хэмжээ, үүрэг рольтой нийцсэн, эсвэл нийцээгүй байж болдог ба тухайн хүний хүйсийн баримжааг илэрхийлсэн, эсвэл илэрхийлээгүй байж болдог (.Америкийн сэтгэл судлалын холбоо, 2008, х. 28).

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь бэлгийн болон хайр дурлалын хувьд ямар хүйсийн хүнд татагдаж буйг хэлнэ. Бэлгийн чиг баримжааны ангилалд ижил хүйсийнхээ хүмүүст татагдах баримжаа (гей эсвэл лесбиян хүмүүс), эсрэг хүйсийн хүмүүст татагдах баримжаа (гетеросексуал), аль аль хүйсийн хүмүүст татагдах баримжаа (бисексуал) багтдаг. Эдгээр ангиллыг өргөнөөр хэрэглэсээр байгаа хэдий ч судалгаа шинжилгээний бүтээлд бэлгийн чиг баримжаа нь ийн тод ангилагдахуйцаар илэрдэггүй, харин үргэлжлэх мөн чанартайгаар илэрдэг нь харагдсан (жишээ нь Kinsey, Pomeroy, Martin, & Gebhard, 1953; Klein, 1993; Klein, Sepekoff, & Wolff, 1985; Shiveley & DeCocco, 1977). Түүнчлэн зарим судалгаагаар зарим хүний бэлгийн чиг баримжаа нь хувирамтгай байх боломжтой, ялангуяа эмэгтэйчүүдийн бэлгийн чиг баримжаа холбиромтгой байх магадлалтайг харуулсан (Diamond, 2007; Golden, 1987; Peplau & Garnets, 2000).

Өөрийгөө нээхүй (камин аут) гэдэг нь хүн өөрийнхөө бэлгийн чиг баримжааг ойлгож, түүнийгээ хүлээн зөвшөөрөх үйл явцыг хэлдэг. Энэхүү үйл явцад хүн бэлгийн чиг баримжаагаа бусдад хэлэх үйл явц ч мөн багтдаг. “Нуугдмал” гэдэг нь хүн өөрийнхөө бэлгийн чиг баримжааг нууцлах, эсвэл бэлгийн чиг баримжааныхаа тухай асуудал дээр хувийн орон зайгаа эрхэмлэх байдлыг хэлдэг.

Нэгдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид ялгаварлан гадуурхалтын үр дүн, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралд нөлөөлөх янз бүрийн нөлөөллийг ойлгохыг эрмэлзэнэ.

Хоёрдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал чиг баримжаа нь сэтгэцийн өвчин биш гэдгийг ойлгоно.

Гуравдугаар удирдамж. Сэтгэл зүйчид ижил хүйстэндээ татагдах, хайрлах, түүнтэй холбоотой илрэх зан үйл нь хүний бэлгийн

амьдралын хэвийн нэг хэлбэр бөгөөд бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүчин чармайлт нь үр дүнтэй эсвэл аюулгүйг баталсан нотолгоо байхгүйг ойлгоно.

Дөрөвдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал асуудлын талаарх өөрсдийн хандлага, мэдлэг нь үнэлгээ, сэтгэл засалд нь нөлөөлж буй анзаарч, шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтнээс зөвлөгөө авч, өөр сэтгэл зүйчдэд шилжүүлбэл зохино.

Тавдугаар удирдамж. Сэтгэл зүйчид бисексуал хүмүүсийн онцлогийг ойлгохыг хичээнэ.

Зургадугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа бэлгийн чиг баримжааны асуудлуудыг хүйсийн баримжаа, илэрхийллийн асуудлуудаас ялгаж ойлгох ёстой.

Долдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал дотнын харилцааны тухай мэдлэгтэй байж, эдгээр харилцаа чухал болохыг хүндэтгэнэ.

Наймдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал эцэг эхийн туршлага, асуудлыг ойлгохыг хичээнэ.

Есдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүсийн гэр бүлд эрх зүйн эсвэл цусан төрлөөр холбогдоогүй хүмүүс багтаж болохыг ойлгоно.

Аравдугаар удирдамж. Сэтгэл зүйчид тухайн хүний лесбиян, гей, бисексуал бэлгийн чиг баримжаа нь тухайн хүний төрсөн гэр орныхонд хэрхэн нөлөөлөх, төрсөн гэр орныхонтойгоо харилцах харилцаанд нь хэрхэн нөлөөлөхийг ойлгохыг хичээнэ.

Арван нэгдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид арьсны өнгө, яс үндсийн хувьд цөөнх болсон лесбиян, гей, бисексуал хүмүүст өөрийнх нь цөөнхийн соёл, хэм хэмжээ, итгэл үнэмшил тодорхой хэмжээгээр өөрийгөө хүлээн зөвшөөрөхөд тогтор болж, сөргөөр нөлөөлдгийг ойлгохыг хичээнэ.

Арван хоёрдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралд шашин шүтлэг нь хэрхэн нөлөөлдгийг ойлгохыг хичээнэ.

Арван гуравдугаар удирдамж. Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн үе, насны ялгаатай байдлыг ойлгохыг хичээнэ.

Арван дөрөвдүгээр удирдамж. Лесбиян, гей, бисексуал залуучууд онцгой асуудал, эрсдэлтэй байдгийг сэтгэл зүйчид ойлгохыг хичээнэ.

Арван тавдугаар удирдамж. Сэтгэл зүйчид биеийн, мэдрэхүйн, танин мэдэхүй-сэтгэлийн хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс онцгой асуудалтай тулгардгийг ойлгоно.

Арван зургадугаар удирдамж. Лесбиян, гей, бисексуал хүмүүс болон олон нийтийн амьдралд ХДХВ/ДОХ-ын нөлөөг сэтгэл зүйчид ойлгохыг хичээнэ.

Арван долдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн сайн сайханд нийгэм, эдийн засгийн асуудал нөлөөлдгийг харгалзаж үзнэ.

Арван наймдугаар удирдамж. Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд ажлын байрны онцгой асуудлууд байдаг гэдгийг ойлгохыг хичээнэ.

Арван есдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтад багтаана.

Хорьдугаар удирдамж. Сэтгэл зүйчид ижил болон бисексуал бэлгийн чиг баримжааны талаар өөрсдийнхөө мэдлэг, ойлголтыг мэргэжлийн сургалт, супервижн, зөвлөгөөнөөр сайжруулахыг хичээнэ.

Хорин нэгдүгээр удирдамж. Бэлгийн чиг баримжаа болон түүнтэй холбоотой асуудлаарх судалгааныхаа үр дүнг сэтгэл зүйчид бүрэн дүүрнээр нь нийтэд тарааж, эдгээр судалгааг буруугаар ашиглах, буруугаар тайлбарлах магадлалтайг ойлговол зохино.

3.2 ТРАНСЖЕНДЭР БОЛОН ХҮЙСИЙН ХУВЬД ЯЛГААТАЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДТЭЙ АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүс нь биологийн хүйсээсээ өөрөөр өөрсдийгөө мэдэрдэг ба тодорхойлдог хүмүүс юм. Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийн тухай олон баримт түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн байдаг (Coleman, Colgan, & Gooren 1992; Feinberg, 1996; Miller and Nichols, 2013; Schmidt, 2003). Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүс нь 100,000 хүн тутам 0.17- 1,333 нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай байдаг (Meier & Labuski, 2013). 2009-2011 оны байдлаар 18-64 насны хүмүүсийн 0.5 хувь нь өөрсдийгөө трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай гэж тодорхойлсон байна (Conron, Scott, Stowell, & Landers, 2012). Гэвч хүн амын тооллого хийхэд энэ тоо нь хангалттай бус байх магадлалтай, учир ЛГБТИК+ хүмүүсээс тоо баримт авах хэцүү байдаг (Meier & Labuski, 2013). Сүүлийн 20 жилийн турш трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийн талаарх судалгаа ихэссэн. Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсээс ирсэн мэдээлэл ба судалгаа

ихэссэн байдал нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст ээлтэй олон талт эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох ба сайжруулах үндсийг тавьж өгсөн юм (Bockting, Knudson, & Goldberg, 2006; Coleman et al., 2012). Судалгаа нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст тулгарсан төрөл бүрийн ялгаварлан гадуурхалт ба стигмаг баримтжуулсан (Grant et al., 2011) бөгөөд үүнээс үүдэлтэй сэтгэл зүйн дарамт (Bockting, Miner, Swinburne, Romine, Hamilton, & Coleman, 2013), сэтгэл гутралд өртөмтгий (Fredriksen-Goldsen et al., 2014) болох ба амиа егүүтгэх (Clements- Nolle, Marx & Katz, 2006) зэргийг багтаасан байна. Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст ээлтэй ба хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ байдаггүй нь одоог хүртэл маш том асуудал болсоор байгаа (Fredriksen-Goldsen et al., 2014; Garofalo, Deleon, Osmer, Doll, & Harper, 2006, Grossman & D'Augelli, 2006) бөгөөд хүйсийн баримжаа, илэрхийллээсээ болоод эрүүл мэндийн үйлчилгээг хүртэж чаддаггүй байх нь элбэг (Xavier, et al., 2012).

Зорилго

Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж нь сэтгэл зүйч нарт трансжендэр хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэх, арга барилаа сайжруулах ба хөгжүүлэхэд чиглэсэн удирдамж болно. Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүстэй ажиллах практик нь эдгээр хүмүүсийн хүйсийн баримжаа, илэрхийллийг мэддэг, хүндэтгэсэн ба дэмжсэн байх хэрэгтэй юм. Удирдамжууд нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүстэй ирээдүйд ажиллах сэтгэл зүйч нарт зориулсан ба одоо эдгээр хүмүүстэй ажилладаг сэтгэл зүйч нарт туслалцаа болох юм. Энэ удирдамжаар сэтгэл зүйчид трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст ээлтэй үйлчилгээ үзүүлэх, эдгээр хүмүүсийн тухай бодит боловсрол мэдлэгийг бусдад олгох, судалгаа хийхэд дөхөм болох юм.

Нэгдүгээр удирдамж. Сэтгэл зүйч нар нь жендэрийг зөвхөн эрэгтэй, эмэгтэй биш харин олон төрөл байдаг ба хүний жендэр нь биологийн хүйстэй нь нийцэх албагүй гэдгийг ойлгоно.

Хоёрдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар нь бэлгийн чиг баримжаа болон хүйсийн, баримжаа, илэрхийлэл хоёрыг өөр ойлголтууд болохыг мэдэх ч харилцан хамааралтай гэдгийг ойлгоно.

Гуравдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийг соёл ба нийгмийн талаас нь ойлгохыг бас хичээнэ.

Дөрөвдүгээр удирдамж. Сэтгэл зүйч нарын хүйсийн баримжаа ба илэрхийллийн тухай мэдлэг нь трансжендэр болон хүйсийн хувьд

ялгаатай хүмүүст ба тэдний гэр бүлд хэрхэн нөлөөлдөг гэдгийн ойлгоно.

Тавдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст сөрөг хандлага, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалт ба хүчирхийлэл хэрхэн нөлөөлдгийг ойлгоно.

Зургадугаар удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийг институцийн хүрээнд саад бэрхшээлтэй байдгийг олж мэдэхийг хичээх ба трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэхийг хичээнэ.

Долдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар нийгэмд өөрчлөлт авчирч бас трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст хүндээр нөлөөлдөг сөрөг ойлголтыг багасгахын төлөө ажиллана.

Наймдугаар удирдамж. Хүйсийн баримжаа, илэрхийлэлдээ эргэлзэж байгаа эсвэл өөрийгөө тодорхойлсон хүүхэд, залуучууд бүгд өөр тул насанд хүрснийхээ дараа хүүхэд өөрийгөө тодорхойлж байсан шигээ үлдэх ёстой биш гэдгийг сэтгэл зүйч нар ойлгоно.

Есдүгээр удирдамж. Сэтгэл зүйч нар ахимаг насны трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийг олон бэрхшээлтэй тулгардгийг ба асуудлаа хурдан шийддэг гэдгийг ойлгоно.

Аравдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэнд нь бэлгийн цөөнхийн стресс, хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй нь холбоотой эсвэл холбоогүй байж болохыг ойлгоно.

Арван нэгдүгээр удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийг нийгэм дэмжих ба трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэхэд амьдрал нь эерэг болохыг ойлгоно.

Арван хоёрдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийн хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хайр дурлалын амьдралд нь нөлөөлөхийг ойлгоно.

Арван гуравдугаар удирдамж. Трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүсийн гэр бүлийн байдал нь өөр өөрийн гэсэн онцлогтойг сэтгэл зүйч нар мэднэ.

Арван дөрөвдүгээр удирдамж. Сэтгэл зүйч нар нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүстэй ажиллах салбар хоорондын практикийг судалж, бусадтай хамтран ажиллах хэрэгтэй гэдгийг ойлгоно.

Арван тавдугаар удирдамж. Сэтгэл зүйч нар трансжендэр болон хүйсийг тэднийг судалгаанд хамруулахдаа хүний эрх ба таатай байдлыг нь бодолцон, буруу мэдээлэл түгээхгүй, судалгааг буруугаар ашиглахгүйг анхаарна.

Арван зургадугаар удирдамж. Сэтгэл зүйч нар нь трансжендэр болон хүйсийн хувьд ялгаатай хүмүүст таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд бусдыгаа бэлтгэнэ.

ДӨРӨВ. МОНГОЛ ДАХЬ ЛГБТ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

4.1 ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ, ИНСТИТУЦУУД

Олон улсын хүний эрхийн эрх зүй нь хүн төрөлхтний түүхэнд анх удаа 20-р зууны дундуур үүссэн нийтийн эрх зүйн ойлголт юм. Дэлхийн хоёрдугаар дайны сая сая хүний амь нас, амьдралыг сүйрүүлсэн зургаан жилийн дараа хүн төрөлхтөн дахин тийм аймшгийг хүлээн зөвшөөрөхгүй ба давтуулахгүйн үүднээс улс орнууд хоорондоо болон дотооддоо хүний мөн чанарыг хэрхэн ойлгох, хүндэтгэх ёстой үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагыг засгийн газар хоорондын байгууллага статустайгаар үүсгэн, олон салбар байгууллага, агентлаг, хууль тогтоогч байгууллагуудаас бүрдсэн энэхүү институцээр дамжуулан хүний амьдралын хэрэгцээний бүхий л тал буюу хүний эрхүүдийг баталгаажуулах, хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүргийн тогтолцоог үүсгэсэн байдаг. Энэхүү хүний эрхийн эрин үе нь тухайн үед эрчимтэй явагдаж эхэлсэн хөгжиж буй орнууд дах колоничлолыг дуусгавар болгох хөдөлгөөн, хөгжингүй орнуудад бүх иргэдэд иргэний болон улс төрийн эрхийг нь эдлүүлэх эмэгтэйчүүдийн эрх, уугуул иргэдийн эрх, ЛГБТИК+ хүний эрхийн хөдөлгөөнүүдтэй давхацсан байдаг.

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь олон улсын гэрээнүүд, гэрээний дагуу тодорхой улсуудад өгсөн зөвлөмж, гэрээний хороодын ерөнхий зөвлөмж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тогтоолууд, НҮБ-ын Ерөнхий чуулганы тогтоол ба Ерөнхий чуулганаас баталсан бусад баримт бичиг, НҮБ-ын мэргэшсэн хараат бус шинжээч, тусгай илтгэгчдийн дүгнэлт, зөвлөмж зэргээс бүрддэг. Хэчнээн олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь тэдгээрийг багтаасан гэрээнд нэгдэн орсон улсад үүрэг хүлээлгэдэг ч, ямарваа асуудлаар тусгай илтгэгч эсвэл хараат бус шинжээч байгаа болон олон улсын гэрээ байгаа тохиолдолд тухайн гэрээнд нэгдэн ороогүй улсын хувьд ч заавал даган мөрдөх олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээ үүссэн хэмээн тооцогддоогоороо онцлог эрх зүйн зохицуулалт болдог.

Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийн хүний эрхийн асуудлыг НҮБ-ын 1948 оны геноцидын эсрэг буюу Төрлөөр хомрогдон устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай олон улсын гэрээг хэлэлцэх үеэс нарийн авч үзсэнийг түүхэнд тэмдэглэн үлдээсэн нь фашист Германы үед гей эрчүүдийг болон лесбиян эмэгтэйчүүдийг төрлөөр хоморголон устгасантай

холбоотой. Фашист Германы үед лесбиян эмэгтэйчүүдийг хоморголон устгасан талаар статистик төдийлөн байдаггүй нь лесбиян эмэгтэйчүүдийг гетеронорматив үзлээр ёс суртахууны хувьд байж боломгүй хэмээн үзээд, биеэ үнэлэгч эмэгтэйчүүдтэй хамт ижил ангилалд багтаадаг байсантай холбоотой. Харин гей эрчүүдийн талаар мэдээлэл бүрэн биш байдаг.

1933 оноос 1945 он хүртэл 100,000 гей эрчүүдийг зөвхөн гей л учир баривчилж, үүнээс 50,000 хүнд ял оноож, үй олноор устгах лагериудад еврейчүүд, рома буюу цыган, сэтгэцийн өвчтэй хүмүүсийн нэгэн адил хорьж, амь насыг нь зэрлэгээр бүрэлгэхээс эхлэн бэлгийн чиг баримжааг нь өөрчлөхийн тулд уураг тархи болон бие эрхтэнд нь олон төрлийн аймшигт туршилтуудыг хийсэн. Төрөлхийн болоод өөрчлөгдөшгүй мөн чанар, илрэл болох арьсны өнгө, яс үндэс, үндэс язгуур болон бэлгийн чиг баримжаа гэх мэт зүйлд үндэслэн сая сая хүнийг ийн хоморголон устгасан нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт зүй ёсоор тооцогдож, геноцидын эсрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээ үүсэхэд нөлөөлсөн. Харамсалтай нь тухайн үед дэлхий дахинаа зонхилж байсан гетеронорматив үзэл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаар шинжлэх ухаанч мэдээлэл байгаагүй байдал, мөн геноцидын бай болсон нь тодорхойлогдвол нөхөн төлбөрийн асуудал үүсэхээс эмээсэндээ энэхүү гэрээг боловсруулсан эрх зүйчид ЛГБТИК+ хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээрээ геноцидын бай болсныг гэрээнд багтаагаагүйг түүхчид харамсан тэмдэглэдэг.

1948 оноос эхэлсэн ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийг ханган хамгаалах энэхүү олон улсын үйл явц 1994 оноос эрчимжиж, олон улсын эх зүйн хэм хэмжээд тусгалаа олж эхэлсэн нь НҮБ-ын Иргэний болон улс төрийн олон улсын пактын хэрэгжилтийг хянах Хүний эрхийн хорооноос гаргасан зөвлөмжтэй холбоотой. 1992 онд Австрали Улсын иргэн Николас Түүнэн НҮБ-ын Хүний эрхийн хороонд насанд хүрсэн ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүс хувийн орон зайдаа бэлгийн хавьталд орохыг “ёс бус бэлгийн хавьтал” хэмээн холбооны тогтолцоотой Австрали Улсын Тасмани мужийн Эрүүгийн хуулиар шийтгэдэг байсныг лесбиян, гей хүмүүсийг бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан шийтгэх нь ялгаварлан гадуурхалт мөн, бэлгийн чиг баримжаа нь хүйс хэмээх зүйлтэй салшгүй холбоотой тул ийм төрлийн ялгаварлан гадуурхалт нь Австрали Улсын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын дагуу хүлээсэн үүрэгт үл нийцсэн эрүүгийн зохицуулалт тул хүчингүй болгох асуудлыг дэвшүүлсэн. Хүний эрхийн хороо нь 1994 оны 3-р сарын 31-нд хуралдан, энэхүү гомдлыг авч хэлэлцэн, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах, шийтгэх нь хүйст үндэслэсэн ялгаварлан гадуурхалт

мөн тул Тасмани мужийнхаа Эрүүгийн хуулийн зохих заалтыг хүчингүй болгох, Австрали Улс даяар бэлгийн чиг баримжаанд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг дуусгавар болох ёстой шийдвэрийг Австрали Улсад зөвлөсөн.

1994 оноос хойш НҮБ-ын бусад гэрээдийн хороо болон мэргэшсэн тусгай илтгэгч, хараат бус шинжээчид барууны ч, хөгжиж буй орнуудын ч ЛГБТИК+ хүмүүсийн эрхийн нөхцөл байдлалд дүн шинжилгээ хийн, мэдлэг мэдээлэлгүй байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт дэлхий даяар байгаа ба үүнийг дуусгавар болгох ёстойг зөвлөсөн байдаг. Харин 2011 онд НҮБ-ын хүний эрхийн хэм хэмжээг тогтоогч үндсэн механизм болох Хүний эрхийн зөвлөл нь ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг хаана ч гарсаар байгаа үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг зогсоох зорилгоор Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа ба хүний эрх, 2014 онд мөн зөвлөлөөс Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа ба хүний эрх, 2016 онд мөн зөвлөлөөс Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанд үндэслэсэн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах нь гэсэн тогтоолуудыг гаргасан ба 2016 оны 6-р сард батлагдсан тогтоол гаргах үйл явцад ЛГБТ Төвөөс идэвхтэй оролцож, дэлхийн өцөг булан бүрийн 680 гаруй төрийн бус байгууллагаас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд зориулан гаргасан уриалгыг ЛГБТ Төвийн Эрүүл мэндийн хөтөлбөрийн менежер Г. Доржжанцан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд танилцуулсан билээ. Энэхүү тогтоолын дагуу НҮБ анх удаа Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр хүчирхийллийн эсрэг асуудлаа Хараат бус шинжээчийн институцыг байгуулж, 2016 оны 9-р сараас өмнө нь НҮБ-ын олон мэргэшсэн асуудлаар Тусгай илтгэгчээр ажиллаж байсан Тайландын эрдэмтэн, профессор доктор Витит Мунтарбхорныг анхны Хараат бус шинжээчээр томилсон түүхэн үйл явц өрнөсөн.

НҮБ-аас гадна олон улсын эрх зүйн хэм хэмжээг тогтоогч өөр нэгэн төрлийн институц нь бүсийн засгийн газар хоорондын байгууллагууд байдаг. Хэчнээн Ази Номхон далайн орнуудын хувьд Европын хүний эрхийн тогтолцоо шиг Европын шударга ёсны шүүх, Европын хүний эрхийн шүүх байдаггүй ч Монгол Улс нь 2012 оны 11-р сард засгийн газар хоорондын Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-д жинхэнэ гишүүнээр элссэнээр Европын хүний эрхийн хэм хэмжээ Монгол Улсад мөн хамааралтай болсон юм. ЕАБХАБ нь одоогоор дэлхий дахинаа хамгийн хөгжингүй үзэн ядалтын эсрэг эрх зүйн хэм хэмжээг тодорхойлж чадсанаараа алдартай ба үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэгт ялангуяа ЛГБТИК+ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээрээ өртдөгийг цохон, ЛГБТИК+ хүмүүс болон бусад цөөнхийг тэгш хамгаалах бүх арга

хэмжээг авахыг гишүүн орнууддаа үүрэг болгодог.

Монгол Улсын нэгдэн орсон бүх гэрээ конвенцид ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхэд хамааралтай заалтууд байдаг нь бүх гэрээ конвенцид хүн бүр эрх тэгш ба ямар нэг байдлаар, тэр дундаа хүйсээр ялгаварлахгүй хэмээх зарчим багтсантай уялдаатай. Нэн ялангуяа 1966 оны Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пакт, 1966 оны Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн олон улсын пакт, 1979 оны Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах олон улсын гэрээ, 1989 оны Хүүхдийн эрхийн олон улсын гэрээ, 1958 оны Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтээр үл ялгаварлах олон улсын 111-р гэрээ гэх мэт үндсэн олон улсын гэрээнүүд ЛГБТИК+ хүмүүсийн эрхэд шууд хамааралтай.

4.2 ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ХҮНИЙ ЭРХЭД ХАМААРАХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хоёр төрлийн хууль шууд үйлчилдгийн нэг нь үндэсний хууль тогтоомж, нөгөө нь олон улсын хууль билээ. Монгол Улс олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан цагаасаа тухайн олон улсын гэрээг шууд хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуулийн 10-р зүйл, Дээд шүүхийн 2008 оны тайлбараараа хангасан байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 11 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн доор байгуулагдсан шинэ хүний эрхийн механизм болох Тогтмол түгээмэл хэлэлцүүлгээр орохдоо анх удаа Монгол Улсын эрх зүй болон нийгмийн нөхцөл байдал дахь хүний эрхийн өргөн хүрээний асуудалд ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийн асуудал багтаж, бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээс үл хамааран ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг ханган хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг аван ажиллаж байгаа билээ. ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийг ханган хамгаалах асуудлыг 2011 оны 5-р сарын 18-нд батлагдсан Засгийн газрын 159-р тогтоол, 2013 оны 7-р сарын 3-нд батлагдсан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 13-р тогтоол, 2015 оны 12-р сарын 3-нд батлагдсан шинэчилсэн Эрүүгийн хууль, 2013, 2014, 2017 онуудад батлагдсан эрүүл мэндийн салбарын мэргэжилтний ёс зүй, салбарын хөгжил болон эрүүл мэндээр баримтлах засгийн газрын бодлогод “бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар үл ялгаварлах” гэсэн заалтууд орж ирсэн.

Гэр бүл үүсгэх эрхийг хангах асуудлаарх зохицуулалт:

Гэр бүлийн тухай хууль, 3.1.1. “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу

төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

Гэр бүлийн тухай хууль 16.1.11-р зүйл: Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.

1999 онд шинээр батлагдсан Гэр бүлийн тухай хуулийг УИХ-р хэлэлцүүлэх явцад өмнө хүчин төгөлдөр байсан Гэр бүлийн хуульд заасан байсан “гэрлэлт нь хоёр хүний тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ” гэсэн заалтыг хүйс зааж өгөхгүй бол ижил хүйстнүүдэд гэрлэх боломж бүрдэх талаар тухайн үеийн УИХ-ын гишүүд нэлээд маргалдаж, заавал хүйс заан оруулсан хэмээн албан бус сурвалжууд мэдээлдэг ба УИХ-ын архиваас үүнийг судлах боломжтой.

Тухайн үеийн улстөрчдийн хувь хүмүүсийн үзэл бодол, ойлголт мэдлэггүй байдлаасаа үүдэн ЛГБТИК+ хүмүүсийн гэрлэлтээ бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх эрхийг хязгаарлах нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй шууд зөрчилдөж байсан. Гэрлэлт, гэр бүлийн тухай олон улсын хэм хэмжээг багтаасан зохицуулалт бүхий Монгол Улсын нэгдэн орсон 1964 оны Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай олон улсын гэрээний албан ёсны англи хэл дээрх текстэд:

(2) Marriage shall be entered into only with the free and full consent of the intending spouses гэдгийг

(2) эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй бүрэн харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрлэж болно

хэмээн албан ёсны, анхдагч текстэд байхгүй үг нэмж орчуулснаас үүдэн Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль ийм үг үсэгтэй болсон нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхгүй байгаа хэмээн үзэх үндэслэл болж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр албан ёсоор амьдарч буй хүмүүс бэлгийн чиг баримжаагаараа ангилагдан, ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүс болон тэдний де факто гэр бүл, тэдний үр хүүхдүүд төрийн зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөж байна хэмээн үзэх үндэслэлийг бүрдүүлжээ.

Гэрлэлт болон гэр бүлээ хүлээн зөвшөөрүүлэх нь ЛГБТИК+ хүмүүсийн хувьд хайрын харилцаагаа баталгаажуулах сэтгэл зүйн хэрэгцээнээс гадна нийгэм, эдийн засгийн олон хэрэгцээтэй шууд хамааралтай байдаг. Ямарваа нийгмийн халамж, үйлчилгээ, санхүүгийн зээл гэх мэтэд хамрагдах нь гэрлэсэн хосуудад илүү боломжтой байдаг нь ЛГБТИК+ хүмүүсийн гэрлэлтээ батлуулж

чадахгүй байдал нь хүүхдээ асран хамгаалах, төрүүлсний дараа хүүхдээ асран хамгаалахдаа боломжтой эх эсвэл эцэг нь хүүхэд асрах чөлөө авах гэх мэт эрхээ эдлэхэд шууд шударга бус хязгаарлалтыг үүсгэж байдаг.

ЛГБТИК+ хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зохицуулалтууд:

ЛГБТ Төвөөс 2010 оноос хойш үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг Эрүүгийн хуульд багтаах ёстой талаар олон улсын болон үндэсний хэмжээнд нөлөөллийн ажлууд хийсний үндсэн дээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад анх удаа үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг болох ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан ба энэ нь 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Тус хуульд:

14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл тодорхой үйлдэл, эс үйлдэхүй шаардсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн зүйлчилжээ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1 бүлэглэж;

2.2 хүч хэрэглэж;

2.3 албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Хүндрүүлэх нөхцөл байдал

Үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж үйлдсэн нь зарим гэмт хэргийн хувьд хүндрүүлэх нөхцөл болон орсон.

10.1 дүгээр зүйл. Хүнийг алах

2.14. үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

Трансжендэр хүмүүсийн эрхийг хангах зохицуулалт:

2009 оны 6-р сарын 25-нд Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орсноор трансжендэр хүмүүсийн өөрийгөө тодорхойлж, амьдардаг хүйсэд нь нийцсэн байдлаар шинэчилсэн бичиг баримт олгох талаар заалт орж, трансжендэр хүмүүсийн бичиг баримтын асуудлыг шийдэж өгсөн нь нэн дэвшилттэй. Бичиг баримт нь трансжендэр хүмүүсийн амьдардаг хүйсийн дагуу олгогдох нь трансжендэр хүмүүсийн аюулгүй амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх гэх мэт асуудалд нэн нээлтэй учир Монгол Улс энэхүү хуулийн заалтаараа бусад олон оронд үлгэр жишээ үзүүлэхүйц хэмжээнд байна хэмээн дүгнэж болно.

20 дугаар зүйл. Хүйс өөрчлөгдсөнийг бүртгэх

Монгол Улсын иргэн эмнэлгийн журмаар хүйсээ солиулсан, эсхүл байгалийн жамаар нэг хүйс нь давамгайлсан бол энэ тухай эмнэлгийн магадалгааг үндэслэн сум, дүүргийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтан бүртгэж, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхийг шинэчлэн олгож болно.

ЛГБТИК+ хүмүүсийг хөдөлмөрийн орчин дахь ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зохицуулалт:

2021 оноос Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх болсон. Энэхүү шинэчлэн найруулсан хувилбарт бэлгийн болон хүйсийн чиг баримжаа гэх үгс нэмэгдэж орж ирсэн юм. Тус хуульд:

6 дугаар зүйл. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох

6.1. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.

ЛГБТИК+ хүмүүсийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой нууцлалыг хамгаалах зохицуулалтууд:

2022 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд уг хуульд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийг “хүний эмзэг мэдээлэл”-д оруулсан юм. Тус хуульд:

4.1.12. “хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг.

Мөн түүнчлэн дараах албан хаагчдын ёс зүйн дүрэмд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахгүй байх талаар зааж, мөрдөгдөж байна. Эдгээрт:

- Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа шударга ёс, хууль дээдлэх, тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хариуцлага хүлээх, үйлчлэх зарчмыг баримтална (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11-р сарын 25- ны 446-р тушаалын 1-р хавсралт) Үл ялгаварлан гадуурхах гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харъяалагдах байдлаар алагчлахгүй байхыг (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ)
- Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран тэгш, хүртээмжтэй хүргэх (Тулгуур зарчим, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлого батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2014 оны 2-р сарын 24-ний өдрийн 55-р тушаалын хавсралт)
- Эрүүл мэндийн яам: 2013, 2014 онд салбарын хөгжлийн бодлого болон салбарын мэргэжилтний ёс зүйд ялгаварлан гадуурхалтын эсрэг зарчим багтсан
- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм (Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралт, 5 дугаар зүйлийн 5.2.3-т зааснаар)
- Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм (Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 598 дугаар тушаалын

хавсралт, 4 дүгээр зүйлийн 4.1.2-т зааснаар)

- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим (Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм (Ерөнхий байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх гэж заасан)

4.3 БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА, ХҮЙСИЙН БАРИМЖАА, ИЛЭРХИЙЛЛИЙН АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

ЛГБТ Төв ТББ 2008 оноос хойш Монгол дахь ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдлын талаарх дараах илтгэлүүдийг бэлтгэн явуулсан. Үүнд:

- НҮБ-ын Хүний эрхийн хорооны Хүний эрхийн тогтмол түгээмэл хэлэлцүүлэгт (2010, 2015 онд)
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай гэрээний хороонд (2008, 2016 онд)
- Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд (2011, 2016 онд)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд (2015 онд)
- Иргэний болон улс төрийн эрхийн хороонд (2011, 2016 онд)
- Хүүхдийн эрхийн хороо (2017 онд)

Эдгээр илтгэлүүдийн дагуу Монгол Улсын Засгийн газар дараах үндсэн зөвлөмжүүдийг авсан. Эдгээрт:

- 2009 онд НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагсдын статусын талаарх тусгай илтгэгчийн илтгэлд БЧБХБИ-тэй холбоотой Монгол улсын төрийн агентын ялгаварлан гадуурхалт
- 2010 оны UPR-ын 7 зөвлөмж нь 3 төрөл:
 1. Ялгаварлан гадуурхалтын эсрэг бие даасан хууль тогтоомж
 2. Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг томьёолох, эрүүгийн зохицуулалттай болох
 3. Нийгэмд БЧБХБИ болон хүний эрхийн талаар бодит, зөв мэдээллээр хангах
- 2010 оны ЭШЭОУГХХХ БЧБХБИ-д хамааралтай дээрхтэй адил 2 зөвлөмж
- 2011 оны ИБУТЭОУПХХХ-д хамааралтай 2 зөвлөмж
- 2012 оны Ядуурлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч МУ

дахь ЛГБТ хүмүүсийн ядууралд өртөмхий байдлын талаар багтаасан

- 2015 онд Монгол Улс Хүний эрийн зөвлөл доорх Тогтмол түгээмэл хэлэлцүүлгээс ЛГБТИК+ хүмүүс болон ялгаварлан гадуурхалтыг дуусгавар болгох талаар 17 зөвлөмж
- 2015 оны 6-р сард Монгол Улс Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактын хэрэгжилтээ дүгнүүлсэн ба ЛГБТИК+ хүмүүс болон ижил хүйсийн хосуудын эсрэг ялгаварлан гадуурхалтыг дуусгах арга хэмжээ авах зөвлөмж
- 2016 оны 2-р сард Монгол Улс Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах олон улсын гэрээний хэрэгжилтийг дүгнүүлсэн ба ЛБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг дуусгах арга хэмжээ авах зөвлөмж
- 2016 оны 8-р сард Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын хорооноос ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг эрүүдэн шүүх болон түүнтэй дүйцэх үйлдлийг зогсоох зөвлөмж
- 2017 онд Хүүхдийн эрхийн хорооноос ялгаварлан гадуурхалтыг хориглосон хуулиа бэхжүүлж, ялгаварлан гадуурхалтад хүргэж буй хэвшмэл ойлголт, хандлагыг устгахын тулд тодорхой арга хэмжээг батлан хэрэгжүүлэх, гэр бүлийн, олон нийтийн, сургуулийн орчинд бүх хүүхдүүдэд бүрэн болон эрх мэдэлжсэн оролцоог хөхиүлэн дэмжих болон мэдээлэлжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ялангуяа охид болон ЛГБТИК+ хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд анхаарах зөвлөмж

Өмнө тайлбарласанчлан олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь зөвхөн олон улсын гэрээний текстээр хязгаалагддаггүй, гэрээдийн хорооноос гаргасан ерөнхий болон улс оронд зориулсан зөвлөмжүүдээс бүрддэг. Эдгээрийг бүрэн эхээр нь оруулахад:

Хүний эрхийн тогтмол түгээмэл хэлэлцүүлэг (2010)

- Бэлгийн чиг баримжаа, жендерийн байдлаар алагчлахыг илэрхий хориглосон, алагчлах явдлын эсрэг өргөн хүрээтэй хууль тогтоомж батлах (Канад Улс)
- Бэлгийн чиг баримжаагаар алагчлах, хүчирхийллийн бүх хэлбэрийг нээлттэй буруушааж, бэлгийн чиг баримжаанд суурилсан халдлага, заналхийллийн хэргийг мөрдөн шалгаж, яллах (Нидерланд Улс)
- ЛГБТ хүмүүсийн эрхийг үрдүнтэй хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсруулж, тус улсад ЛГБТ хүмүүсийг алагчлах үзлийг бий болгохыг хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар зогсоох (Швейцари Улс)

- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанаас нь хамаарч хувь хүмүүст халдсан, заналхийлсэн хэргийг нарийвчлан, хараат бусаар мөрдөн шалгах явдлыг хангах, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх (Канад Улс)
- Бэлгийн чиг баримжаанаас нь хамааран, тухайлбал ЛГБТ хүмүүсийг заналхийлсэн, халдсан бүх хэргийг нягт бөгөөд хараат бусаар мөрдөн шалгаж, шударга шүүхийн олон улсын жишгийн дагуу буруутай этгээдийг шийтгэх (Швед Улс)
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг ЛГБТ хүмүүсийг алагчлахгүйгээр хангах (Швед Улс)

Хүний эрхийн тогтмол түгээмэл хэлэлцүүлэг (2015)

- Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх (Ирланд, Чили, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Уругвай, Бүгд Найрамдах Чех Улс, Франц, Словени, Зүүн Тимор)
- ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн үр нөлөө бүхий хамгаалалт тогтоосон хууль тогтоомжийг боловсруулж батлахаас гадна Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн гэх халдлагуудыг хараат бус байдлаар мөрдөн шалгах арга хэмжээ авах (Гондурас)
- Өөрийн үндэсний хууль тогтоомждоо эрхийг нь баталгаажуулах замаар ЛГБТ хүмүүс эрхээ эдлэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих (Уругвай)
- Үзэн ядах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах зорилгоор тухайн хууль тогтоомжийг өөрчлөх (Испани)
- ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ийм явдлыг үл тэвчих хандлагыг дэмжих зорилгоор олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах (Бразил)
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулж, энэ чиглэлээрх датаг цуглуулах, мэдээлэл, статистикийг гаргах ажлыг зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэх (Нидерланд)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо (2015)

- ЛГБТИК+ хүмүүсийн эсрэг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг зогсоохыг хангахад шаардагдах бүх арга хэмжээг авах, ялангуяа мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх
- Ижил хүйсийн хосууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх тэгш эрхтэйг хүлээн зөвшөөрөх

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо (2010)

Оролцогч улс алагчлахтай тэмцэх, ялангуяа үзэн ядалтаас үүссэн гэмт хэрэг, үг хэлээр дайрах үйлдлийг зохицуулсан эрх зүйн тогтолцоог бий болгох хэрэгтэй. Ийм төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийг шударгаар шүүхэд Оролцогч улс тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Бэлгийн цөөнх, ХДХВ/ДОХ-той хүмүүс болон зарим гадаадынхан (эмзэг бүлгийнхэн)-ыг хамгаалах нь зүйтэй. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанаас болж халдлагад өртөгсдийн гомдол, мэдээллийг “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой асуудалд олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх Жогжакартын зарчимд нийцүүлэн түргэн шуурхай, бүрэн гүйцэт, хараат бусаар мөрдөн шалгах бодлого, бодлогын хэрэгжилт, гомдол хянан шийдвэрлэх механизмуудыг байгуулах хэрэгтэй байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Бэлгийн чиг баримжаа төрөлхийн үү, олдмол уу? Хэзээ илрэх вэ?

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь төрөлхийн, хүн хүндээ татагдах, дурлах мөн чанарыг хэлдэг ойлголт юм. Бэлгийн чиг баримжаа бэлгийн зан үйлээр илэрхийлэгдэж ч болно, үгүй ч байж болно. Бэлгийн чиг баримжаа ихэнхдээ бэлгийн бойжилтын насанд илэрдэг. Гаднын нөлөөнөөс, жишээ нь: хүнд уруу татагдаж, эсвэл шохоорхож, сонирхсоноос болж бэлгийн чиг баримжаа өөрчлөгддөггүй. 1963 онд Америкийн сэтгэл судлаачдын холбооноос ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг бишийг тогтоосон ба Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1990 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг олон улсын өвчний жагсаалтаас хассан байдаг.

Хүйсийн баримжаа төрөлхийн үү, олдмол уу? Хэзээ илрэх вэ?

Хүйсийн баримжаа нь хүн бүрийн өөрийн хүйс, биеэ мэдрэх гүн гүнзгий, төрөлхийн мэдрэмж учир хүүхэд маш бага наснаасаа үүнийгээ мэдэрч, илэрхийлж байдаг.

Хүйсийн баримжаа ихэнхдээ хүүхдийн бага насанд илрэх ч транс байдал илрэх тодорхой насыг заах боломжгүй. Хүйсээ төрсөн хүйстэйгээ ижил хэмээн мэдэрдэг, түүгээрээ нийгэмшдэг хүнийг сизжендэр гэдэг бол хүйсээ төрсөн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрдэг, түүгээрээ нийгэмшдэг хүнийг трансжендэр гэдэг.

Бэлгийн чиг баримжаа ба бэлгийн зан үйлийн хооронд ялгаа бий юу?

Бэлгийн чиг баримжаа нь хүнд татагдах, дурлах сэтгэл, оюун, бэлгийн салшгүй мөн чанар. Бэлгийн зан үйл нь бэлгийн үйлдэл л төдий. Бэлгийн зан үйл буюу үйлдэл нь бэлгийн чиг баримжаанд суурилсан ч байж болдог, үгүй ч байж болдог. Жишээ нь, хүйсээр тусгаарлах дээр үеийн сүм хийд, одоогийн цэргийн хуаран, хорих газрууд гэх мэт газруудад ижил хүйсийн бэлгийн зан үйл их байдаг ч энэ бол нөхцөл байдлаас үүдсэн бэлгийн зан үйл гэж тооцогддог ба энэхүү ижил хүйсийн бэлгийн хавьталд орж буй хүмүүс өөрсдийгөө ЛГБ буюу бэлгийн цөөнх гэж тодорхойлох нь цөөн байдаг.

ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийн байдал Монголд ямар байна? Хүмүүсийн эрх яг яаж зөрчигдөж байна? Нийгмийн хандлага ямар байна?

Нийгмийн сөрөг хандлагаас үүдсэн төрөл бүрийн ялгаварлан гадуурхалт нийгмийн бүх салбарт байсаар байна.

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай олон нийтийн болон хүний эрхийн мэдлэг нимгэн байгаагаас сөрөг хандлагууд илэрсээр байдаг.

ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг ханган хамгаалахын тулд юу шаардлагатай байгаа вэ?

Хүний эрх гэдэг нь хоорондоо харилцан хамааралтай, түгээмэл, хуваагдашгүй гэсэн гурван цогц зарчимд суурилдаг. Нэг бүлэг хүмүүсийн хүний эрхийг нөгөө бүлэг хүмүүсийн эрхээс дээгүүр эсвэл доогуур авч үзэх ёсгүй. Тиймээс бэлгийн цөөнх хүмүүс хүний хувьд, иргэний хувьд яг ижил эрхийг эдлэх ёстой ч одоогийн байдлаар энэ боломжгүй байна. Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжтой болох, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл үл хамааран хүн бүрт иргэнийхээ бүх эрх, үүргээ эдлэх боломжийг хангаснаар нийгэм маань хүн бүрээ тэгш эрхтэйг нь дээдэлдэг болно.

Монгол Улсын Засгийн газраас ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг ханган хамгаалахын тулд юу хийж байна вэ?

ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийг ханган хамгаалах ёстой талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс авсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийн тулд баталсан 2011 оны 5-р сарын 18-ны өдрийн Засгийн газрын 159-р тогтоол, Хүний эрхийн зөвлөл болон Хүний эрхийн болон Эрүү шүүлтийн эсрэг хороодоос 2010 болон 2011 онуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар баталсан 2013 оны 7-р сарын 3-ны өдрийн УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 13-р тогтоол гэх мэт арга хэмжээ авсан байгаа хэдий ч салбарын яамд, газрууд эдгээр тогтоолыг амьдралд хэрэгжүүлэх санаачилга, алхмаар дутагдалтай ажиллаж байна. Салбар яамдаас ялгаварлан гадуурхалтыг бүхэлд нь хориглосон тушаалыг Соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын яам 2013 онд, Эрүүл мэнд, спортын яам 2014 онд гаргасан. Шинээр боловсруулагдаж 2015 оны 12-р сарын 3-нд батлагдсан Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг зүйлчилсэн ба шинэ Зөрчлийн тухай хууль болон Хөдөлмөрийн хуульд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлахгүй гэсэн заалтуудыг мөн оруулж өгсөн.

Монголд бэлгийн цөөнх хэдэн хүн байдаг вэ? Сүүлийн үед ЛГБИК+ хүмүүс ихсээд байна гэж хүмүүс ярих юм?

Бэлгийн цөөнх нь ямар ч орны хүн амын 10% гэсэн нийтлэг жишиг тоо байдаг. Нийгэм бүрт өөр өөр тоо гардаг нь тухайн оронд хүний эрхийг хэр хэмжээнд хамгаалсан, ЛГБТИК+ хүмүүс хэр нээлттэй амьдрах боломжтой асуудалтай шууд холбоотой. Жишээ нь, 2014 онд Иранд хийсэн судалгаагаар хүн амын насанд хүрсэн хүмүүсийн 18% ижил хүйсийн бэлгийн туршлагатай гэсэн тоо гарсан байдаг. 2000 оны АНУ-ын хүн амын тооллогын үеэр бэлгийн чиг баримжааг анх удаа асуулгад багтаасан байдаг ба 2010 онд дахин багтааснаар тооллогын үр дүнд газар зүйн байршил үл хамааран ЛГБТИК+ хүмүүс бүх нийгэм-эдийн засаг, соёл, үндэстний гаралтай байдаг гэдгийг баталгаажуулсан байдаг. Монголын хувьд сүүлийн үед ЛГБТИК+ хүмүүсийн тоо ихсэж байгаадаа биш, өмнө нь нуугдмал амьдардаг байсан хүмүүс ил амьдарч эхэлсэнтэй холбоотой юм.

ЛГБТИК+ эрхийг сурталчилснаар хүмүүсийг уруу татах юм биш үү? Чимээгүй байж болдоггүй юм уу?

Хүн болгон өөрийн насанд тохирсон мэдээллийг эрэлхийлэх, хүртэх, дамжуулах, түүнчлэн бусдын эрхэд халдсан бус байдлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн пакт болон бусад Монгол Улсын нэгдэж орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан. Нийгэмд байсаар байгаа буруу, ташаа ойлголтыг үнэн, бодит мэдээллээр л зүгшрүүлэх учир ЛГБТИК+ эрхийн тухай, ЛГБТИК+ хүмүүсийн өмнө тулгарч буй бэрхшээлүүд, бодит байдлыг ярих ёстой болдог. Мэдээлэл өгснөөр хүнийг уруу татна гэсэн ойлголт үүсэхгүй, учир нь бэлгийн чиг баримжаа төрөлхийн, өөрчлөгддөггүй зүйл. Харин мэдээлэлгүй байдлын хор уршиг нь маш олон зүйл дээр илэрдэг. Жишээ нь, ЛГБТИК+ өсвөр насныхан гэр орныхондоо бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа илэрхийллээ гэхэд гэр орныхны зүгээс төрөл бүрийн хүчирхийлэл амсаж байгаа нь нийгэмд бэлгийн цөөнхийн талаар мэдээлэл, ойлголт тун бага байгаатай шууд холбоотой.

ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг дэлхийн хэдэн улсад яаж хамгаалсан байдаг вэ?

Дэлхийн ихэнх улсад бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжтой. Үүнд, Европ бүхэлдээ, мөн Латин Америкийн ихэнх орон, Төв ба Хойд Америкийн ихэнх орон болон Африкийн хэд хэдэн орон багтаж байна. Харин Аргентин, Бельги, Бразил, Канад, Дани, Грийнланд, Финлянд, Франц, Исланд, Ирланд, Люксембург,

Мексик, Голланд, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Их Британи, АНУ, Уругвай улсуудад ижил хүйсийн гэрлэлтийн хууль хэрэгждэг бол Андorra, Австрали, Австри, Чиле, Колумб, Хорват, Чех, Эквадор, Эстони, Герман, Унгар, Итали, Япон, Лихтенштэйн, Мальта, Швейцарь, Тайван, Венесуэл улсуудад ижил хүйсийн гэрлэлттэй тэнцэх иргэний гэрлэлтийн зохицуулалт байна. Харамсалтай нь ижил хүйсийн харилцан зөвшилцлийн үндсэн дээр хийгдсэн бэлгийн зан үйлийг Иран, Судан, Саудын Араб, Мавритани, Сомалид болон Нигерийн зарим хэсэгт цаазаар авах ялаар яллсаар байна.

ХДХВ/ДОХ гей залуучуудын өвчин гэх юм билээ, хэр үнэн бэ?

1980-аад оны эхээр барууны орнуудад хурдацтайгаар тархаж байх үед гей болон бисексуал залуучуудын дунд нэлээд ажиглагдсан учир тухайн үед “гей хар тахал” гэсэн буруу нэршилтэй байсан ч сүүлдээ ямарваа эрсдэлт бэлгийн зан үйлээс болж ямар ч насны, ямар ч хүйсийн, ямар ч бэлгийн чиг баримжаатай хүмүүст халдаж болох халдвар гэдэг нь тогтоогдсон ба сүүлийн жилүүдийн судалгаагаар хөгжиж буй орнуудад эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд нэлээд их тархаж байгаа өвчин. Монголын хувьд гей залуучууд байнга сайн дурын зөвлөгөө, шинжилгээнд хамрагдаж буй утгаараа гей залуучуудын дунд нь илүү тархсан мэт харагдаж байгаа нь үнэн.

“Тэгш эрх, бахархлын өдрүүд” үйл ажиллагаа яагаад хэрэгтэй вэ?

ЛГБТИК+ гэдгээрээ бахархах нь битгий хэл нээлттэй амьдарч буй ЛГБТИК+ хүмүүс цөөхөн байсаар байна. Гэтэл хүн бүр эрхээ эдлэх нөхцөл бололцоогоор нь хангах үүргийг төр хүлээсэн ч хүн бүр хүний эрхийг хүндэтгэх үүргийг мөн хүлээдэг. Хүн бүр тэгш эрхтэй гэдгийг ойлгуулах, ЛГБТИК+ хүмүүс Монголын хүн амын түүхэн хэсэг байсаар байсан, байсаар байх болно гэдгийг ийм олон нийтийн хүний эрхийн боловсролыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа чухал.

“Тэгш эрх, бахархлын өдрүүд” Монголд хэд дэх удаа болж байна вэ?

Анх 2013 оны 9-р сарын 22-28-ны хооронд “Бахархлын долоо хоног” нэртэйгээр зохион байгуулагдаж байсан. 2014 оноос “Тэгш эрх, бахархлын өдрүүд” нэртэйгээр зохион байгуулагдаж байна. Энэ жил 2018 оны 8-р сарын 24-нөөс 9-р сарын 1-ний хооронд “Тэгш эрх, бахархлын өдрүүд” зохион байгуулагдах болно.

ЛГБТИК+ хүмүүсийн олон улсын баяр, тэмдэглэлт өдрүүд байдаг уу?

- **2-р сарын 14-өөс эхлэх 7 хоног:** Аромантик байдлыг ойлгох долоо хоног
- **3-р сарын 1:** Ялгаварлан гадуурхалтгүй өдөр

- **3-р сарын 8:** Эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
- **3-р сарын 31:** Транс байдлыг ойлгох олон улсын өдөр
- **4-р сарын 26:** Лесбиян байдлын тухай мэдлэгээ тэлэх өдөр
- **5-р сарын 17:** АЙДАХОТ (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1990 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг олон улсын өвчний жагсаалтаас хассан байдаг. Өвчний жагсаалтаас хассаныг дэлхий даяар 5-р сарын 17-нд Гомофоби, трансфоби, бифобийн эсрэг олон улсын АЙДАХОТ өдрөөр тэмдэглэдэг.)
- **5-р сараас 10 сар хүртэл:** Дэлхийн өнцөг булан бүрд Бахархлын сарууд
- **7-р сарын 14:** Олон улсын нонбайнари өдөр
- **7-р сарын 16:** Дрэг өдөр
- **8-р сарын сүүлийн долоо хоногоос 9-р сарын эх:** Монгол дахь Тэгш эрх, бахархлын өдрүүд
- **10-р сар:** ЛГБТ түүхийн сар
- **10-р сарын 11 эсвэл 12:** Өөрийгөө нээх өдөр (Coming out day)
- **10-р сарын сүүлийн долоо хоног:** Асексуал байдлыг ойлгох долоо хоног
- **10-р сарын 26:** Интерсекс байдлын талаар мэдлэгээ тэлэх өдөр
- **11-р сарын 13-аас 19:** Транс байдлын тухай мэдлэгээ тэлэх долоо хоног
- **11-р сарын 20:** Транс хүмүүсийн гэгээн дурсгалын хүндэтгэх өдөр
- **12-р сарын 10:** Олон улсын хүний эрхийн өдөр

“ЛГБТ Төв” ТББ-ын алсын хараа, хөтөлбөрүүд, ажлууд

“ЛГБТ Төв” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь 2009 оноос хойш бэлгийн цөөнх болох лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүсийн хүний эрхээр дагнан ажиллаж буй Монголын анхны ЛГБТИК+ хүний эрхийн байгууллага юм. Байгуулагдсан цагаасаа өргөн хүрээний нөлөөллийн үйл ажиллагаа авч хэрэгжүүлснээрээ 2010 онд Ардчилсан залуучуудын холбооноос “Хүний эрхийн тэмцэгч байгууллага” шагнал, 2011 онд Олон улсын гей, лесбиян хүний эрхийн хорооноос Фелипа дэ Сузагийн нэрэмжит шагнал, 2016 онд Азийн ЛГБТ эрхийн Asia LGBT Milestone Awards, 2016 онд APAC Insider Legal Awards-ын “Шилдэг хүний эрхийн тэмцэгч байгууллага” шагнал хүртсэн хүний эрхийн, тэр дундаа ЛГБТИК+ хүний эрхийн бүсийн, олон улсын холбоо, байгууллагын гишүүн байгууллага билээ.

Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэх соёлыг үүсгэх, хөхүүлэн дэмжих, ЛГБТИК+ хүмүүс болоод бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар буруу мэдээлэл, ойлголт зонхилсоор байгааг арилгахын тулд олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг өгөх нь нэн чухал байгаа энэ үед соёл урлагийн хэрэгслээр хүмүүст мэдээлэл хүргэх нь маш чухал. Тиймээс “ЛГБТ Төв” нь 2014 оноос урлаг соёлын хөхүүлэн дэмжих стратегийн чиглэлтэй болж, жилдээ нэг удаа визуал уран бүтээлчдийн дунд уралдаан, мөн 2013 оноос эхлэн бүх нийтийн хүний эрхийн боловсролыг сайжруулах “Тэгш эрх, бахархлын өдрүүд”-ийг зохион байгуулж эхэлсэн. “ЛГБТ Төв” нь 2015 оноос эхлэн дотоод бүтцэдээ өөрчлөлт хийн, Эрх зүй, Эрүүл мэнд, Залуучуудын гэсэн хөтөлбөрүүдээр дамжуулан Монгол Улсад бэлгийн цөөнхийн эрхийг ханган хамгаалах асуудал дээр ажиллаж байна.

“ЛГБТ Төв” ТББ 2008 оноос хойш Монгол дахь ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдлын талаарх дараах илтгэлүүдийг бэлтгэн явуулсан. Үүнд:

- НҮБ-ын Хүний эрхийн хорооны Хүний эрхийн тогтмол түгээмэл хэлэлцүүлэгт (2010, 2015 онд)
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай гэрээний хороонд (2008, 2016 онд)
- Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд (2011, 2016 онд)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд (2015 онд)
- Иргэний болон улс төрийн эрхийн хороонд (2011, 2016 онд)
- Хүүхдийн эрхийн хороонд (2017 онд)
- Мөн эдгээрт багтаагүй илтгэлүүд байгааг анхаарна уу.

“ЛГБТ Төв”-д хүмүүс хэр их ханддаг вэ?

Өөрийн болон ах, эгч, дүүгийнхээ бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай илүү ойлголттой болохыг хүсэж буй хүмүүс, мөн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн хүний эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа авахаар хандах нь маш их.

“ЛГБТ Төв”-тэй холбогдох:

Утас: 70110323

Имэйл: info@lgbtcentre.mn

Фэйсбүүк хаяг: The LGBT Centre (Mongolia)

<https://www.facebook.com/LGBTtuv/>

Инстаграм хаяг: [@lgbtcentre.mongolia](https://www.instagram.com/lgbtcentre.mongolia)

Вэб хаяг: www.lgbtcentre.mn

ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

МОНГОЛ ДАХЬ БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ, 2013 ОН

Судалгааны онолын үндсэн аргачлал нь “цөөнхийн стресс”, “чадамжид тулгуурласан шударга ёс”-ны онолууд байв. Цөөнхийн стресс гэдэг нь ямарваа байдлаар ялгаварлан гадуурхалтад өртдөг цөөнх болсон олон нийтийн байнга мэдэрдэг, ужиг стрессийг хэлэх ба нийгмийн дэмжлэггүй байдал, нийгэм, эдийн засгийн чадамжгүй байдал, хүмүүсийн зүгээс ирж буй ялгаварлан гадуурхалт гэх мэт хэд хэдэн гол хүчин зүйлс үүнд нөлөөлдөг. Өнгөрсөн гучаад жилийн турш барууны эрдэмтэд олон судалгаануудаараа цөөнх ба олонх хүмүүсийн эрүүл мэндийн хооронд нэлээд их ялгаа байгааг олж тогтоосон ба энэ нь нийгмийн ялгаварлан гадуурхалттай шууд холбоотойг нотолсон байдаг. Цөөнх болсон хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртдөгөөс болж байнга стрессийн (цусны өндөр даралт, тайван бус байдал гэх мэт) шинж тэмдэгтэй явдаг ба энэ нь урт хугацаанд тэдний сэтгэцийн болон биеийн эрүүл мэндэд нэн уршигтай нөлөө үзүүлдгийг эрдэмтэд олж тогтоожээ. Цөөнхийн стресстэй холбоотой судалгаанаас ялангуяа бэлгийн цөөнх болсон ЛГБТИК+ хүмүүсийн амьдралынхаа хугацаанд туулж амссан ялгаварлан гадуурхалт нь урт хугацаанд амиа хорлох, хорлохоор завдах, архи болон бусад хуульчлагдсан болон хуульчлагдаагүй мансууруулах бодист донтоход хүргэдэг, мөн түүнчлэн төрөл бүрийн хорт хавдраар өвчлөхөд нөлөөлдөг, эдгээр хүчин зүйлс нь цаашлаад ЛГБТИК+ хүмүүсийн дундаж наслалтад ч сөрөг нөлөө үзүүлдгийг олж тогтоосон байдаг.

Цөөнхийн стрессийн анхдагч зарчим нь цөөнх олон нийтийн гишүүн байх нь ялгаварлан гадуурхалтад өртөх боломжийг ихэсгэдэг хэмээх зарчим юм. Хуулиараа бэлгийн цөөнхийг хамгаалсан барууны орнуудад хүртэл энэхүү ялгаварлан гадуурхалт нийгмийн түвшинд байсаар байгаагаас үүдэн бэлгийн цөөнх дистал стрессийн хүчин зүйлсийг мэдрэх нь өндөр давтамжтай хэмээн судалгаанууд баталсан. Ялгаварлан гадуурхалтаас үүдсэн дистал стресс дээр нэмэлт бэлгийн чиг баримжаагаа нуух, хүйсийн баримжаа, илэрхийллээ нуух, өөртэйгөө адилхан хүмүүсийг үзэн ядах гэсэн проксимал стрессорууд нэмэгддэг. Жишээ нь, бэлгийн чиг баримжаагаараа ялгаварлан гадуурхалтад өртөж байсан ЛГБ өсвөр үеийнхэн болоод насанд хүрсэн хүмүүс бусдаас бэлгийн чиг баримжаагаа нуудаг гэсэн судалгааны үр дүн байдаг. Гэтэл өөрийн тухай ийм чухал мэдээллийг нууцлах нь ихээхэн сэтгэл зүйн стресс үүсгэдэг ба үүнээс үүдэн өөрөөсөө ичих, өөрийгөө буруутай хэмээн үзэх, тайван бус байдал мэдрэх, эсвэл өөрийг

нь үгүйсгэж байгаа хүмүүст байнга уурлах, цөхрөх, мөн цөөнх болсон олон нийтээсээ тусгаарлагдсан мэт мэдрэх гэх мэт шинж тэмдгээр илэрдэг ажээ. ЛГБТИК+ хүмүүсийн хувьд нэмэлт стресс үүсгэдэг хүчин зүйл нь нийгмийн гомофобийг хүлээж аван, өөрөө өөрийгөө үгүйсгэх, ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаар нийгмийн сөрөг ойлголтыг өөрийн болгох буюу internalized homophobia үүсгэдэг гэсэн судалгаанууд байдаг.

Чадамжийн онолыг Нобелийн эдийн засгийн шагналт, философич Амартья Сэн анх 1990-ээд оноос эхлэн хөгжүүлсэн ба энэхүү концепц нь хүний хөгжилд суурилсан хөгжлийн бодлогын үндсэн зарчим болсон байдаг. Чадамжийн онол нь тайлбарын гэхээсээ ил норматив буюу тэгш бус байдал, ядуурал гэх мэтийг тайлбарлахаасаа илүү эдгээр зүйлийг тодорхойлоход бидэнд тусалдаг онол. Чадамж гэдэг нь өөрийнхөө үнэт зүйлийн дагуу орших болон үйлдэхийг багтаасан функцээ хүн эдлэх бодит эрх чөлөөтэй байгаа эсэхийг хэлдэг. Өөрөөр хэлбэл Монголын одоогийн нөхцөлд ЛГБТИК+ хүмүүс оршиж байгаа ч, өөрийнх мөн чанараараа буюу ижил хүйсийн бэлгийн чиг баримжаагаа нуулгүй ялгаварлан гадуурхалтад өртөлгүй амьдрах, орлого олох, онцлог эрүүл мэндийнхээ асуудлаар тусламж авах, трансжендэр хүмүүсийнхувьдэрүүлбайхньшуудхүйсийншилжилттэйхолбоотой эрүүл байх, ЛГБТИК+ хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртөлгүй онцлог эрүүл мэндийн асуудлаараа мэдээлэл авах, эрүүл мэндээ хамгаалуулах, ижил хүйсийн хүмүүс гэр бүл болж амьдрах, ижил хүйсийн гэр бүл дэх хүүхдээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүй өсгөх гэх мэт хүн төрөлхтний энгийн үнэт зүйл болсон эрх, эрх чөлөөгөө эдлэх буюу үйлдэхүйн функцээ эдлэх боломж байхгүй байгаагаас ЛГБТИК+ хүмүүс Монголд бүрэн чадамжаа эдлэх боломжгүй байгаа хэмээн үзэх үндэслэлтэй болно. Чадамжийн онол нь хүний сайн сайхныг бий болгохын тулд ямар үйлдэхүй нь байгаа ба ямар нь дутуу учир түүнийг үүсгэх ёстой байна хэмээн бүхэлд нь хардгаараа бусад шударга ёсны онолоос ялгаатай ба илүү практик хэрэглээтэй хэмээн тооцогддог. ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийн хэрэгжилтийн байдлыг дүгнэх нь энэхүү судалгаанд асуулга, фокус группийн ярилцлагууд, ганцаарчилсан ярилцлага гэсэн аргачлалыг хэрэглэсэн ба асуулгад нийт 60 ЛГБТИК+ хүн оролцсоны 76.7% нь Улаанбаатар хот, 20% нь хөдөө орон нутагт, 3.4% нь Монголоос гадна амьдарч буй ЛГБТИК+ хүмүүс байв. Хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд эрэгтэй 50%, эмэгтэй 31.7%, трансжендэр эмэгтэй 11.7%, трансжендэр эрэгтэй 6.7% байсан ба 18-23 насны хүмүүс 28.3%, 24-29 насны хүмүүс 26.7%, 30-35 насны хүмүүс 26.7%, 36 ба түүнээс дээш насныхан ойролцоогоор 18.3%-тай байсан ба 13.3% нь үндэстний цөөнх байв. Оролцогчид боловсролын төвшнөөр 5% нь бага, 26.7% нь

бүрэн дунд, 65% нь дээд, 3.3% нь тусгай дунд боловсролтой байв. Бэлгийн чиг баримжааны хувьд оролцогчдын 35% нь өөрсдийгөө гей (1.7%-ийг эзлэх транс гей хүмүүс багтсан), 25% өөрсдийг лесбиян (3.3%-ийг эзлэх транс лесбиян багтсан), 35% өөрсдийг бисексуал, 5% өөрсдийг гетеросексуал хэмээн тодорхойлсон. Арван есөн асуултаас бүрдсэн асуулга нь Монголын нийгмийн нөхцөлд ЛГБТИК+ хүмүүс хэрхэн нийгэмшилд орж байгаа, ийн сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалуулахад ямар асуудал тулгарч байгааг тодруулах зорилготой байсан.

Хүний эрхээ эдлэх, эрх тэгш байх, хүний эрхээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүй эдлэх, амьд явах, халдашгүй байх эрхүүдийн хэрэгжилт

Судалгаанд оролцсон ЛГБТИК+ хүмүүсийн 28.3% нь бэлгийн цөөнхөд хамаарагддагаа гэр орон, анги болон ажлын хамт олноосоо нуудаггүй гэсэн бол 71.7% нь “нуудаг”, “ойлгохгүй учир хэлэхийг хүсдэггүй”, “доог тохуу хийхээс нь эмээж хэлдэггүй” гэжээ. ЛГБТИК+ хэмээн өөрсдийгөө бүрэн нээгээгүй тохиолдолд шууд ялгаварлан гадуурхалт үүсэхгүй ч ерөнхий байгаа байдлаар нь “охин шиг”, “нялцгай” “эр хүн шиг бай” гэж шууд бусаар гей залуучуудыг, “ямар эршүүд юм, эмэгтэй бол эмэгтэйгээрээ бай” гэж шууд бусаар зарим лесбиян эмэгтэйчүүдийг ялгаварладаг, өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөнд нь халддаг хэмээн фокус ярилцлагын үеэр хүмүүс ярьж байв. ЛГБТИК+ гэдгээ нэг удаа нэг хүнд хэлээд дуусчихдаг зүйл биш, ямарваа нэг нийгмийн харилцаанд орох бүртээ өөрийгөө нээж илэрхийлэх шаардлага гардаг ба энэ нь насан туршийн, өдөр тутмын үйл явц хэмээн зарим хүмүүс онцолсон. Судалгаанд оролцсон ЛГБТИК+ хүмүүс өөрийнхөө үндсэн мөн чанарын суурь хэсэг болсон бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа, илэрхийллийг нээлттэй илэрхийлэхээс айж, эмээж байгаа нь ЛГБТИК+ хүмүүсийн анхдагч хүний эрх болсон “хүний эрхээ эдлэх эрх” нь хаалттай байна хэмээн ойлгож болно. Харин фокус ярилцлагуудын үеэр ЛГБТИК+ байдлаа хэлдэггүй шалтгааныг цааш лавшруулж тодруулахад:

- “Гэр бүлийн нэр хүнд унахаас айдаг.”
- “Нийгэмд эзлэх байр суурьгүй болохоос айдаг.”
- “Монголд эрх зүйн орчин бүрдээгүй байгаа тул өөрийнхөө аюулгүй байдлыг хангах үүднээс нуух шаардлага гардаг.”
- “Миний бэлгийн чиг баримжааг мэдсэнээр ирээдүйн амьдралд минь муугаар нөлөөлнө гэж айдаг.”
- “Хүмүүст бэлгийн чиг баримжааны тухай ойлголт огт байдаггүй, миний эргэн тойрны хүмүүс намайг ойлгохгүй, үзэн ядаж хөндийрөхөөс нь айдаг.”

- “Бэлгийн чиг баримжаанаасаа болж гэр бүл, найз нөхөд, орчин тойрны хүмүүсийн зүгээс ялгаварлалд өртмөөргүй байна.”
- “Трансжендэр гэдгийг манин гэж ойлгодог явцуу ойлголт байдаг. Энэ хүйсийн баримжаа, илэрхийлэл, өөрийгөө мэдэрч буй мөн чанар гэдгийг мэддэггүй учир трансжендэр охидыг хүмүүс “Чи яаж маяглахаараа ийм байдаг байна. Чи ийм байж болохгүй, эр хүн шиг бай” гэдэг.”
- “Өөрийнхөөрөө байж чаддаггүй, өөрийн сонирхсон, сонгосон хувцас, эд юмыг өмсөж чаддаггүй. Учир нь ээж, аав, ах дүү нараасаа трансжендэр хүмүүст хэрхэн хандаж байгааг нь харж өссөн.”

Гэр орныхон болон дотнын хүмүүстэйгээ бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийнхээ тухай нээлттэй байдаг эсэх тухай асуултад 10% нь нээлттэй, 26% нь үгүй, 50% нь зөвхөн дотнын найзууд мэддэг гэж хариулсан бол 14% нь зөвхөн гэр орныхон мэднэ гэж хариулсан байна. “Гэр орны нөхцөлд ялгаварлан гадуурхалтад өртөж байсан уу” хэмээх асуултад 86.7% нь гэр орныхондоо хэлээгүй, хэлэхээс эмээдэг гэсэн хариулт өгсөн ба нээлттэй ЛГБТИК+ хүмүүсийн хувьд буюу хэлсэн 6.7% нь гэр орныхоо нөхцөлд ялгаварлан гадуурхалт, түүгээр зогсохгүй бие махбодын халдлагад өртөж байсан гэжээ. Харин бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанаасаа болж гэр орноосоо хөөгдөж байсан эсэх тухай асуултад оролцогчдын 6.6% хөөгдөж байсан, хаана очих, хэнд хандахаа мэдэхээ больж байсан гэж хариулжээ. Фокус ярилцлагаар энэ асуултыг цааш нь тодруулахад:

- “Өөрийнхөөрөө байж чадахгүй, сэтгэлдээ айдастай, яах бол гэж айгаад хүнтэй чөлөөтэй харьцаж чаддаггүй.”
- “Багаас авхуулаад их хүртэл зөндөө л юм болдог. Үг хэлээр дайрч доромжлохоос эхлүүлээд. “Чи арай тэр гомо энэ тэр нь юм биш биз дээ” гэж ирээд л. Тэр болгоноос халшираад, залхаад, намайг ингээд л төрчихсөн гэдгийг ойлгохгүй байгаа хүмүүстэй ярихыг ч хүсэхээ байсан ч тэднээс санхүүгийн хараат учир, бие даагаад амьдарчих боломжгүй учир өдөр болгон гэртээ орохдоо хөндий хүйтэн, намайг үзэн ядсан мэт хүмүүсийн дунд ордог. Амиа хорлочихвол эд нар уйлах болов уу, намайг алсан гэж бодох болов уу ч гэж хааяа боддог.”
- “Эгчдээ итгээд хэлэхэд эгч надад нэг удаа уурлаад, бид бүгд гэртээ байхад “Аав, таны энэ охин чинь лесби ш дээ” гээд, аав үг дуугүй шууд намайг шанаадаж унагаачхаад “Чи лесби юм уу” гэхээр нь би айсандаа “үгүй” гэсэн. Эгч миний бэлгийн чиг баримжааг одоо хүлээн зөвшөөрч, намайг дэмждэг ч аав,

ах нараасаа бол айдаг, хэлдэггүй. Эгч нар мэднэ, эхлээд бас хэцүү байсан, янз бүрээр гоочилно, гэхдээ одоо арай гайгүй болж байгаа.”

- “Айлын том учир хэлдэггүй. Гэхдээ дүү тэд нарт ярьсан юм шиг байгаа юм. “Эрэгтэй хүнтэй яваад байгаа юм бол ажлынханд чинь хэлнэ” гэж байсан. Өөрийгөө хэлмээр байвч хэзээ ч ойлгохгүй юм шиг санагддаг.”
- “Ээждээ хэлж байсан. Тэгээд намайг ойлгосон юм шиг байдаг ч хааяа найз залуутайгаа уулзаад ирэхэд “Чи хичээл сургуулиа бодсонгүй, боов эргүүлж явлаа” гэж загнадаг. Магад намайг бүрэн хүлээн зөвшөөрөөгүй учир л тэгж загнаж байгаа байх гэж би ойлгодог. Миний төлөө хэлж байгаа ч би өөрөө хичээл сургууль, хайр дурлалын амьдралаа зохицуулаад явчих ухаантай, өөрийн гэсэн толгойтой хүн гэдгийг үгүйсгээд байгаа юм шиг санагддаг.” “Чи яасан ийсэн транс мранс вэ? Охид л чамайг уруу татаад, хар багаас чинь чамд хайрын захиа өгсөөр байгаад ийм болгож байгаа юм гэж ирээд л аймаар загнана, зодно. Ах намайг өмөөрдөг ч ээж үнэхээр намайг ойлгодоггүй. Их хүнд байдаг байсан болохоор би 15 насандаа гэрээсээ явж, ааваасаа жоохон мөнгө авч, тусдаа амьдардаг болсон. Хүнд, их хүнд. Багаасаа хүссэн хүсээгүй биеэ даана гэдэг их хурдан, цагаасаа өмнө том хүн болно гэсэн үг. Үеийнхэн тэгэхэд бодож санах зүйлгүй, эрхлээд явж байдаг байсан.”
- “Би нөхөртөө зодуулаад, тархи хөдлөөд, хөх няц болж байсан. Төрийналбанхаагч, тэгээд ажилдаа сар явж чадаагүй. Намайг эмэгтэй амрагтай болсны төлөө тэгж зодсон. Нөхөртөө хэлсэн нь миний буруу л даа. Нуугаад л хүмүүс яваад байдаг юм билээ, тэгэх даанч совесть байгаагүй. Тэгээд хөл дээрээ босоод шууд шүүхэд салах өрөгдлөө өгч байсан. Би тэр үед “Энэ хүн намайг харгис хэрцгий байдлаар тамлаж зодсон нь миний жинхэнэ бэлгийн чиг баримжаатай холбоотой” гэж хэлээгүй ч үнэндээ тийм л шалтгаантай байсан.”
- “Найз охины ээж дуудаж авчирч байгаад хутга бариад дайрахад “За ингээд алуулж дээ” л гэж бодсон. Б. байгаагүй бол 90 хүрч буй аав маань намайг яагаад ч алуулсныг ойлгохгүй, их л хүнд байх байсан гэж боддог. Тэгээд намайг толгой түрийгүй балбасан.” “Жоохон л юм болвол “Гаж донтон” гээд орилоод над руу дайрдаг. “Чамайг төрүүлсэндээ харамсдаг” гэж ээж ааваасаа сонсох шиг аймаар зүйл байхгүй. “Муу амьд явснаас үхчхээсэй” гэж хоорондоо ярьж байхыг нь ч сонссон. Хааяа дэндүү аймаар санагддаг, харанхуй, бүдүүлэг нийгэмд төрж дээ гэж боддог. Хааяа бүр амиа ч хорломоор үе зөндөө байсан.”

- “Гэр орныхондоо хэлээд гэр орноосоо хөөгдөж байсан, орох оронгүй, бараг л тэнэмэл болсон хүүхдүүд зөндөө л байдаг. Тэгээд тэр хүүхдүүд, хүүхдүүд гэж яах вэ нас биед хүрсэн ч оюутан болохоор нь л хүүхэд гэж байна тэд чинь ямар юмных нь орлоготой байх вэ.
- Тэгээд гэр орноосоо хөөгдсөн, эсвэл эцэг эх нь ойлгохгүй байгаа нөхцөлд гэрээсээ өөрсдөө дайжаад энд тэнд орцонд хоног төөрүүлдэг. Энд тэнд аюултай газар байснаараа улам л их хүчирхийлэлд өртөх эмзэг байдалд хүргэдэг, гэр бүлийн хүчирхийлэл. Гэр орондоо, хамгийн чөлөөтэй байх газраа л өөрийнхөөрөө байж чадахгүй, өөрийгөө илэрхийлэхээс эмээж байна гэдэг нийгмийн бусад бүх орчинд л яг адилхан баригдмал, хаагдмал, өөрийн мөн чанарыг нууна гэсэн үг.”
- “Эхэндээ ойлгохгүй маш их зоддог байсан. “Чи хэндээ уруу татагдаад ийм болчхов?”, “Би зүгээр хүүхэд гаргасан шүү” гээд. “Уруу татсан хүнийхээ нэрийг хэл” гээд. Аав ээжийн ааш зангаас шууд зодох гэж байгаа нь харагддаг байсан. Гэтэл би ингээд л төрчихсөн, ухаан орохоосоо л ийм байсан гэж хэлээд ойлгодоггүй байсан. Сүүл тийшээ арай тайвшраад, тэгэхээ больсон ч бүрэн ойлгодоггүй. Учир нь миний хувийн амьдрал юу болж байна, хэнтэй үерхэж байна, хэнд хайртай болсон, би аз жаргалтай, үгүй нь тэдэнд ямар ч хамаагүй байдаг.”
- “Зайл” гээд хөөхөөр нь би явах ёсгүй гэж боддог ч их хүнд байдаг. Өөрөө бие даагаад амьдарчих боломжтой байсан бол тэгэж хөөгдөн барин суухгүй байх байсан. Хурдан орлоготой болоод бие дааж амьдармаар байна.”

ЛГБТИК+ хүмүүсийн анхдагч эрхүүд болох хүний эрхээ эдлэх, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх, халдашгүй дархан байх эрхүүд нь нийгмийн анхдагч нэгж болсон гэр оронд нь хамгийн их зөрчигдөж, гэр орондоо амсдаг хүчирхийллээс үүдэн хамааралтай бусад эрх болох үзэл бодолтой байх, нийгмийн халамж болон бусад нийгэм хамгааллын үйлчилгээгээр хангагдах эрх, төр гэхээс хувь хүмүүсийн зүгээс эрх чөлөөгөө дур зоргоор хязгаарлуулахаас ангид байх эрх, шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх эрх, шаардлага хангахуйц орон байртай байх эрх, гэр оронгүй болоод явж байхдаа хүн худалдаалах болон хүнийг мөлжих бүх хэлбэрээс хамгаалагдах эрхүүд нь зөрчигддөг, зөрчигдөх үндэс бүрдэж байна.

Ажил хөдөлмөр эрхлэх эрх, олон нийтийн амьдралд оролцох, соёлын амьдралд оролцох, ажлын байранд хүний эрхээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүй эдлэх, хувийн нууц, халдашгүй байдлын эрхүүдийн хэрэгжилт

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд нь үндэслээд ажилд авахаас татгалзаж байсан эсэх тухай асуултад 93.3% нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа нуудаг учир ажил хөдөлмөр эрхлэлт дээр ямарваа асуудалд орж байгаагүй гэсэн бол өөрсдийнхөө бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа илэрхийлсэн хүмүүс буюу

6.7% нь ажил олгогчдын зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөж байсан гэжээ. Харин фокус ярилцлагын үеэр энэ асуултыг цааш нь дэлгэрүүлж тодруулахад:

- “Монгол жижигхэн учир нэг ажил олгогчид ЛГБТИК+ гэдгээ хэлэхэд бусад нь мэдээд намайг ажилд авахгүй тохиолдол зөндөө гарч байсан. Нарийн мэргэжлийн салбараар сураа ч үгүй хүний хажууд би түүгээр нь сурчхаад ирсэн байхад тэр хүнийг мэргэжилтнээр ажилд авсан жишээ хүртэл бий.”
- “Монгол жижигхэн, ажилгүй тиймээс бүр амьдралгүй болохгүйн тулд өөрийнхөө мөн чанарыг нуусаар ирсэн” гэж байв.

“Та бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээсээ үүдэн ажлын байран дээр ялгаварлан гадуурхалтад өртөж байсан уу?” гэсэн асуултад 11.7% нь тийм, 41.7% нь ажлын байран дээрээ хэнд ч хэлдэггүй тул гадуурхагдаж байгаагүй, 40% нь мэдэгдвэл асуудал үүсэх нь тодорхой тул нуусан нь дээр, 3.3% ажил хийж үзээгүй, зөвхөн 3.3% ЛГБТИК+ байдалд нь үндэслэн ажлын байранд ялгаварлан гадуурхалтад өртөж байгаагүй гэж хариулжээ. “Тийм” гэж хариултаа дэлгэрүүлснийг буулгавал “хувь хүний эрхийн асуудал гэдгийг ойлгодоггүй учир ялгаварлаж байсан”, “яасан охин шиг юм бэ гэж үргэлж хэлдэг ба заримдаа чи охин шиг учир хийж чадахгүй гэж ялгаварладаг” гэж хариулсан байна. Фокус ярилцлагын үеэр энэхүү асуудлаар цааш ярилцлага өрнүүлэхэд:

- “Олон улсын байгууллагад хүртэл ЛГБТИК+ байдлаар ялгаварлан гадуурхдаг, жишээ нь эрүүл мэндийн даатгалд ижил хүйсийн эхнэр, нөхрийг нь багтаахаас татгалзаж байсан ба “Танай орны хууль ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй учир ижил хүйсийн эхнэр эсвэл нөхрийг нь эрүүл мэндийн даатгалд хамруулахгүй” гэсэн институцийн ялгаварлан гадуурхалт үүсэж байсан. Өөр орны яг ижилхэн

хүмүүс хамт ажиллаж байлаа гэхэд тэдний ижил хүйсийн гэрлэлтийг улсынх нь хуулиар хүлээн зөвшөөрсөн тул тэдний гэрлэлтийг гэрлэлт гэж үзээд, минийхийг гэрлэлт гэж үзэхгүй байсан нь цаашлаад ажлын хамт олны уур амьсгалаар ч мэдрэгддэг байсан.”

- “Ажлын байран дээр их асуудал гардаг. “Найз охинтой юм уу? Найз охин чинь эрэгтэй байхаа, эр хүн шиг байгаач, яаж яваад байгаа юм, хүүхэн шиг. Гамбуушийн дүү юм уу” гэх мэтээр үг хэлээр доромжилдог.”
- “Ажлын байрны хувьд намайг мэддэг болохоор нэг их асуудал гардаггүй. Гэхдээ л байхгүй хойгуур далдуур ярих, албан тушаал ахихгүй байх, гаднах байдлаасаа болж доромжлуулах асуудал гардаг. Гэвч ажлын байранд үүнийг зөв зохистой шийдвэрлээд өгөх дүрэм, журам байдаггүй, байлгахыг ч хүсдэггүй юм шиг байгаа юм. Тэгэхээр миний хувьд ажлаасаа халагдахгүйхэн шиг, чимээгүй байхаас өөр арга байдаггүй. Энэ бол миний хувьд хамгийн том бэрхшээл.”
- “Янз бүрийн л ялгаварлан гадуурхалт үүсэж байсан, ажлын нөхцөл гэдэг өдөр тутмын орон зай учир ажлаа амар тайван хийх боломжгүй болтол гадуурхахад ажлаасаа гарахаас өөр ямар ч сонголтгүй байдалд олон удаа орж байсан”, “Хүмүүс хань ижлийнхээ, хүүхдүүдийнхээ зургийг ширээн дээрээ тавьдаг ш дээ оффисын ажил хийдэг хүмүүс, гэтэл би тэгж чадахгүй байгаа нь л, хайртынхаа зургийг тавьчихвал намайг яаж нүд үзүүлэх бол гэхээс сэрэмжлэх айдас байгаа нь л ялгаварлан гадуурхалтын уур амьсгал Монголд маш хүчтэй байгааг харуулдаг.”
- “Монгол жижигхэн учир нэг газраас ЛГБТИК+ байдлаараа гадуурхагдаж байгаад гарлаа гэхэд өөр ажлын байр ч олдох нь хүнд, зөндөө л тэгж явж байсан.”
- “Хүний эрхийг дээдэлдэг гэж өөрсдийгөө үздэг, ярьдаг газруудад ч гэсэн ялгаварлан гадуурхалт байдаг. Энэ бол бүхэл бүтэн нийгмийн үзэгдэл учир зөвхөн ганц ажлын байран дээрх асуудал биш. Нийгэм нь нээлттэй, бас хууль, эрх зүйн орчин нь бүрдчихсэн, ялгаварлан гадуурхалтыг хууль бус болгочихсон байсан бол ажлын байранд хэзээ ялгаварлан гадуурхалт үүсэхгүй. Тийм биш байгаа учир хүмүүс нуудаг. Тэгээд нөгөө нийгэм нь ЛГБТИК+ хүмүүсийг энгийн л хүмүүс байдаг гэдгийг олж хардаггүй, нуугаад байгаа юм чинь, тэгээд л нөгөө сөрөг, буруу ойлголттой хэвээр яваад байдаг. Хүчирхийллийн тойрог гэдэг шиг зүйл л дээ.”

- “Бүх хүмүүс эхнэр нөхөр яриад л, үр хүүхдээ яриад л, цайны цагаар ч юм уу, хамт хоолонд орохоор ч юм уу, гэтэл би ус балгачихсан юм шиг л байдаг. Шинэ жилээр хүртэл зарим газар эхнэр нөхрийг нь урьдаг, гэтэл би олон жил хайртай залуутайгаа амьдарч байгаа хэр нь ганц бие гэж явдаг. Тэгээд хүмүүс “эхнэр аваач ээ” л гэдэг, би дотроо “Нөхөртэй шд” л гэдэг. Хэрэв би хайртай залуугаа яриад эхэлбэл, найз залуугаа дагуулаад ирвэл тэд жинхэнэ эвэртэй туулай үзсэн мэт юу гэж хэлж, юу хийх бол доо гэж айдаг”.
- “Хувиараа хөдөлмөр эрхлэхэд хүртэл хүндрэлтэй, ЛГБТИК+ газар гэдгийг мэдээд холбогдох байгууллагуудаас, ялангуяа цагдаагаас илүү ирж шалгаж, дарамт үзүүлэх тал байдаг.”

Ажил хөдөлмөр эрхлэх эрх нь ЛГБТИК+ хүмүүсийн хувьд огт хангагдахгүй байгаа хэмээн үзэх үндэслэлтэй, учир нь ЛГБТИК+ гэдгээмэдэгдвэлажилдагдаггүй, тиймээс хүмүүс ЛГБТИК+ байдлаа нуух шаардлагатай тулгардаг. Эсвэл нуугаад ажилд орлоо гэхэд дараа нь ЛГБТИК+ гэдгээ хэлэхэд, эсвэл өөрөө хүсээгүй ч ямар нэгэн байдлаар ЛГБТИК+ байдлаа мэдэгдлээ гэхэд ажлын байранд нь маш их ялгаварлан гадуурхалт үүсэж, энгийн байдлаар ажлаа хийх боломжгүй болсноор ажлаасаа гарах шаардлага гардаг нь ЛГБТИК+ хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх эрх зөрчигдөөд зогсохгүй, энэ эрхтэй харилцан хамааралтай оршдог шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх, шаардлага хангахуйц орон байртай байх эрхүүд нь шууд зөрчигддөг гэж үзнэ. ЛГБТИК+ хүмүүсийн ажил хөдөлмөрийн эрх нь тодорхой хэмжээгээр хаагдмал байгаа байдлаас үүдэн зарим хүмүүсийн хувьд ядуурлын эх үндэс нээгдэж буйг ч үгүйсгэшгүй. Энэх судалгаанд хувь хүний орлогыг тодорхойлуулаагүй тул ядуурлын асуудал үүссэн байх магадлалтай хэмээн таамаг дэвшүүлж байна. Нөгөө талаас ажил хөдөлмөр эрхэлнэ гэдэг нь насанд хүрсэн хүний олон нийтийн болон соёлын амьдралд оролцох хамгийн том орон зай нь байдаг тул эдгээр ажил хөдөлмөр эрхлэхгүй байх нь эдгээр эрхийг ч хаана гэсэн үг.

Сурч боловсрох эрхийн хэрэгжилт

Сургууль болон боловсролын орчинд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээс үүдэн ялгаварлан гадуурхалтад өртөж байсан эсэх тухай асуултад оролцогчдын 25% нь тийм, 75% нь үгүй гэж хариулсан ба сургууль боловсролын орчинд ЛГБТИК+ байдлаасаа үүдэн халдлагад өртөж байсан эсэх тухай асуултад 6.7% бие 52 махбодын халдлагад өртөж байсан гэв. Фокус ярилцлагаар эдгээр асуултыг задлан тодруулахад:

- “Хэлж байгаагүй болохоор ихэвчлэн зүгээр байдаг байсан. Гэхдээ хүүхдүүд бусад ЛГБТИК+ байж болох хүүхдүүдэд яаж хандаж байгааг хараад жоохон эмээгээд хэлдэггүй байсан. Арван жилээ төгссөн ангидаа шилжиж ирэхэд миний сүүлдээ хамгийн сайн найз болсон Э.-г хүүхдүүд цөм гей гэж мэддэг, “Тэрэнтэй л битгий найзлаарай, гомо” гэж хэлж байсан. Тэгэхэд би өөрөө тэгж хэлүүлэхгүйн тулд 11-р ангиа төгстлөө тэр хамгийн сайн найздаа адилхан гей гэдгээ Э.-д хэлээгүй. Орчин гэж тийм л байгаа ш дээ.”
- “Хөөе охион, хүүхээн, гомо энээ тэрээ гэж дуудах бол энгийн л үзэгдэл. Бүр барьж аваад алгадаж унагаагаад, элэгдчихгүй л бол бараг тоохгүй. Зөвхөн хэлээд өнгөрч байгаа нь яамай гэж боддог. Гэхдээ багш нар бас муухай байдаг. “Энэ нэг юм юун охин шиг юм” гэхээр нь ангийнхан пэр хийтэл инээлдээд, яах вэ тэд нар бол намайг мэддэг болохоороо тийм хорон инээхгүй ч багш хүн байж хүүхдийг тэгж хамт олных нь дунд эвгүй байдалд оруулж, таагүй орчин үүсгэж байна гэдгээ мэддэггүй л юм байх даа.”
- “Сургууль бол эрүүл, аюулгүй орчин байх ёстой гэдгийг материаллаг талаас нь авч үздэгээс хүний эрхийг үл ойшоох, ялгаварлан гадуурхалтад өртөх явдал их байдаг. Үнэн хэрэгтээ багш, сурагч, эцэг эх гээд эргэн тойронд байгаа хүмүүсийг харахад хэнд нь ч миний нөхцөл байдлыг ойлгохгүй байгаа хандлага ажиглагддаг.”
- “Харваас банди шиг, тэгээд банди шиг хувцаслаад явахад их хэцүү байдаг байсан. Сургуулийн гадаа нэг удаа банди нар “Чи эр үү, эм үү?” гээд өмд хүртэл шувталж байсан.” (ЛГБТ Төвийн баримтжуулалт)
- “Яг одоо том болж байгаа, одоогийн залуучуудын хувьд ерөнхийд гайгүй болсон. Гэхдээ мэр сэр мэдрэл, аагиж саагьсан хүүхдүүд байдаг. Тэд нар л янз бүрийн байдлаар дайрч доромжилж байсан гэхээс ер нь хүүхэд залуучууд бас гайгүй шүү.”
- “Хичээл дээр хагас дутуу үздэг, бас телевиз энэ тэр гээд бас гайгүй. Ангийнхан хүлээн зөвшөөрдөг ч параллель ангийнхан ч юм уу, сургуулийнхан ч юм уу, эсвэл янз бүрийн урлаг спортын сургууль хоорондын хамтын үйл ажиллагаа болоход л эмээгээд байдаг. Таньдаг хүмүүс гайгүй, таньдаггүй хүүхдүүд яачих бол гээд.”
- “Хичээл дээр хагас дутуу уншаад өнгөрч байсан. Тэгээд хүүхдүүд бага сага мэдээлэлтэй болчихоод “Чи гомо нь юм уу, манин нь юм уу?” гэж асууж шоолдог 53 байсан. Би өөрийгөө

бүрэн дүүрэн эмэгтэй хүн гэж үздэг учир “Гомо байхдаа яах вэ дээ” гээл өнгөрдөг байсан.”

- “Эрэгтэй эмэгтэй дүрд хувирах тэмцээн болоход багш “Чи ор, үгүй бол дүнтэй чинь ярина шүү” гэж байсан.”
- “ЕБС-ийн орчныг бодвол их дээд сургуулийн орчинд гадуурхах нь харьцангуй цөөн ч нуухгүй бол бас болохгүй. Транс хүмүүс гэтэл нуугдаад нуугдаад нуугдаж чадахгүй, бүр илт байдаг учир.”
- “Арван жилд байхад шоолуулдгаасаа болоод хичээлээ маш их тасалдаг байсан. Бусад гей хүүхдүүд ч сургуулиасаа гарсан зөндөө л тохиолдол байдаг.”

Боловсролын тогтолцоогоор заагдаж буй бэлгийн чиг баримжааны тухай хичээл хэрхэн заагдаж байгаа тухай болон бусад хичээл дээр ЛГБТИК+ хүмүүсийн тухай мэдлэг өгч буй талаар тодруулах зорилгоор сургууль болон боловсролын орчинд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар мэдээлэл авч байсан эсэх тухай асуултад зөвхөн 10% нь “авч байсан”, 1.7% нь “ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа бол сэтгэцийн өвчин гэсэн мэдээлэл авч байсан” бусад нь “бага зэрэг”, “үгүй” гэж хариулжээ. Үүнээс үзэхэд ЕБС-ын хичээлийн хөтөлбөрт зөвхөн бэлгийн эрүүл мэндийн хичээлээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар заагаад зогсохгүй, бусад боломжтой бүх хичээлд энэ талаар шууд болон шууд бус байдлаар оруулах шаардлага байгааг харуулж байна. Фокус ярилцлагаар энэхүү асуултыг цааш задлахад:

- “Багш ч олигтой заадаггүй, бараг “өөрсдөө унш” гээд тэр бүлгийг алгасаж байсан санагдаж байна. Би өөрөө гей болохоороо үхтлээ сонирхоод үг бүрчлэн уншиж байсан.”
- “Бэлгийн эрүүл мэндийн хичээл дээр л хагас дутуу орж байсан. Биеийн тамирын багш тэр хичээлийг заадаг байсан.”
- “Бэлгийн эрүүл мэндийн хичээл дээр заадаг байсан ч хүүхдүүд инээлдээд, “гомо, лесби нарын тухай хичээл орж байна” гээд багшийг ч сонсохгүй, тэгж л заалгаж байсан. Хангалттай гэж хэлэхгүй. Бусад хичээл дээр зааж болдоггүй юм уу. Бусад бүх хичээл дээр л стрэйт хүмүүсийн жишээ байдагтай адил заавал ил түгээмэл ойлголт хэвшинэ гэж боддог.”

Боловсролын агуулгыг суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд боловсролын тогтолцоонд ЕБС-ийн хөтөлбөрт бага ангиас эхлүүлэн боломжтой хичээл бүрт өөрөөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай мэдээллийг шууд болон

шууд бус байдлаар суулгаж өгөх, багш бэлтгэдэг сургуулиудад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар заах, ЕБС-ийнхөтөлбөртбэлгийнчигбаримжаа,хүйсийнбаримжаа, илэрхийллийн тухай мэдээлэл ямар түвшинд, хэрхэн заагдаж буйг хянах тогтолцоотой болох, боловсролын тогтолцоонд ЛГБТИК+ багш болон хүүхэд сурагчдыг ялгаварлахгүй байх салбарын бодлоготой, дүрэм журамтай болохоос нааш ЛГБТИК+ хүүхэд болон залуус таатай боловсролын орчинд сурах эрхээ тодорхой хэмжээгээр бүрэн эдэлж чадахгүй гэсэн дүгнэлтийг хийх ёстой.

Шударга шүүхээр шүүлгэх эрх, түр саатуулагдахдаа хүнлэг харьцаагаар хангагдах эрх, эрүүдэн шүүх ба харгис хэрцгий, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхүүдийн хэрэгжилт

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээсээ үүдэн цагдаа болон хууль сахиулах байгууллагын зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөж байсан эсэх тухай асуултад 8.3% нь “өртөж байсан”, 6.7% нь “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой биш асуудал байсан тул хэлэхийг хүсээгүй” гэсэн ба 1.7% нь “асуудал гарсан ч цагдаад хандахаас айдаг” гэжээ. “Цагдаа болон хууль сахиулах байгууллагын зүгээс ЛГБТИК+ байдлаасаа үүдэн гэмт хэргийн халдлагад өртсөнийг цагдаа үл хайхрах асуудал гаргаж байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 26.7% “заавал өөрийнхөө ЛГБТИК+ байдлыг илчлэх шаардлагагүй гэж боддог”, 11.7% “гарч байсан”, 46.7% өөрийгөө илчилбэл үл тоомсорлох байх гэж боддог”, 15% “тийм нөхцөлд орж байгаагүй” гэжээ. Фокус ярилцлагаар энэхүү асуудлыг цааш нь задалж тодруулахад:

- “Гей гэдгээсээ болоод зодуулчихлаа гээд хандах гэхээр өөрийнхөө бэлгийн чиг баримжааг цагдаад хэлэх хэрэг гарна. Тэгээд яаж ч хандаа билээ, ойлгохгүй гэж бодоод хандаж байгаагүй.”
- “Гэрийнхэндээ бэлгийн чиг баримжаанаасаа болж зодуулчихлаа гээд очно гэхээр гэрийнхнийгээ цагдаад өгч арай чадахгүй, тэд нар намайг хайрладаггүй ч би тэднийг хайрлаад байгаа юм шиг. Гэхдээ цагдаад хандлаа гэхэд заавал зодуулсны учир шалтгаан, ямар нөхцөл байдал байсан гэж асууна, тэгэхээр миний бэлгийн чиг баримжаа асуудалд орох болов уу гэж айдаг.”
- “Эрийн муу цагдаа гэдэг ш дээ. Нийгмийн сэтгэхүй байдаг, цагдаа нараас айдаг, тэдэнд итгэдэггүй. өөрөө хохирогч болчихоод байхад л гэмт хэрэгтэнтэй харьцаж байгаа юм шиг ханддаг.”

- “Үзэн ядалтаас үүдсэн халдлагад удаа дараа өртөж байсан. Хамгийн ноцтой байдлаар 2012 оны 2-р сарын 23-нд өртөөд цагдаад Монголд анх удаа үзэн ядалтаас үүдсэн хэргээ барьж очиж хэрэг үүсгэсэн хүн нь би байх, миний мэдэхийн. Цагдаа нь дажгүй байсан, мэдрэмжтэй. Хэрэг үүсгэхээр Чингэлтэйн 55 цагдаа дээр очиход манай барыг шалгадаг байсан цагдаа дайралдаад “100-ийн залууг бүр таргалтал нь зодож, арай ч болохгүй ээ” гээд хамт явж байсан ЛГБТ Төвийн захирлыг миний найз залуу гэж ойлгоод “Найз залуутайгаа явж байгаа юм уу? Чи найз залуу нь биз дээ” гэхэд нь би хэчнээн гей биш ч, тэр цагдаагийн мэдрэмжтэй хандаж байгаад нь их баярлаж байсан. Хэрэг шалгагдаж байх хугацаанд би хагалгаагаа хийлгэхээр явж ирсний дараа хэрэг өөр прокурорт шилжсэн байсан, тэгээд хэрэг хүлээж авсан байсан Т. Оргил-Очир гэж Чингэлтэйн прокурортой анх уулзахад “Ийм шалдар булдар асуудлаар хөөцөлдөж явдаг эр хүн бол доо чи” гэж ам нээв, үгүй шууд доромжилж эхлэхээр нь өөрөө ч мэдэлгүй элгээ тэвэрчихсэнийг тэр “Чи ямар том, пээдгэр залуу вэ. Чи муу надад пээдэлздэг хэн бэ” гэж над руу дайрсан. Тэрээр хэргийг албаар удаашруулсан, тэгсний ачаар 6 сар өнгөрч, гэмт хэрэгтэн ямар ч шийтгэлгүй явж байгаа. Учир нь ялын төлөвлөгөөг хамгийн хөнгөн зүйл ангиар төлөвлөсөн байсан. Дээр нь үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг одоо хүртэл эрүүгийн хуульд багтаагаагүй учир ЛГБТИК+ хүмүүс үзэн ядалтаас үүдсэн халдлагад өртлөө гэхэд над шиг дэмий л цагаа үрнэ. Энэ хэрэг бол миний шударга шүүхээр шүүлгэх эрх огт хэрэгжээгүйн маш том илрэл. Энэ болгоныг шууд ялгаварлан гадуурхалт л гэж үзнэ. Ялгаварлан гадуурхалтын эсрэг хуультай болчихвол тийм ёс зүйгүй, хувийн үзэл бодлоо ажилдаа тусгасан төрийн албан хаагчдыг шууд ажлаас нь халах эрх зүйн үндэслэл бий болно.”
- “Би гэртээ харьж явахад манай найз залуугийн ах намайг ирж мөргөчхөөд зугтаад гүйсэн. Тэгээд би найз залуугийнхаа гэрт амьдардаг болохоор гэртээ ороод “Тэр ах чинь намайг мөргөж, хамар хугаллаа” гэж уурласан. Ээж нь цагдаа дуудсан. Тэгсэн хохирогч болсон намайг цагдаа нар барьж яваад, элдвээр “Чи муу гомо минь зүгээр байгаарай” гэж хэл амаар доромжлоод намайг цохисон. Би хаана ажилладаг болохоо хэлээд, болсон явдлыг хэлэхэд надаас уучлалт гуйсан. Гэхдээ энэ бол асуудал. Цагдаа нар хохирогч, гэмт хэрэгтэн хоёрыг ялгаж чадахгүй, дээрээс нь хохирогч болсон хүнийг улам бүр хохироох ёсгүй.”

- “Лесбиян хосуудын дунд гэр бүлийн хүчирхийллийн асуудал байдаг. Бие биеэ хардсанаас болоод ч юм уу. Ийм зүйл тохиолдоход хэнд, хэрхэн хандахаа үнэхээр мэддэггүй. Найзуудаасаа хүртэл нуудаг, санаа зовдог. Энд тэндээ хөх няц болчихоод явж байхдаа найзуудтайгаа уулзвал “Юм мөргөсөн, уначихсан юм” л гэж хэлдэг. Цагдаад хандлаа гэхэд тэд ойлгохгүй, бараг л дуртайдаа та нар ингээд явж байгаа биз дээ гэх болов уу гэж айдаг.”
- “Нэг удаа Ханзод байж байхад цагдаа нар ирээд бүх хүмүүсийг баривчлаад явсан, 2012 оны 12-р сарын сүүлээр. Шөнөжингөө буюу шөнийн 23:45-ын үеэс 56 өглөөний 7 цаг хүртэл байлгаж, янз бүрээр дарамталсан. Тэр нь нэг стрэйт залуу гей залуучуудад хүчиндүүлсэн гэж телевизээр яриад, цагдаад мэдэгдсэн юм байна лээ, түүний дагуу хийгдсэн ажиллагаа байсан. Ихэнх маань хэзээ ч саатуулагдаж байгаагүй учир их сэтгэл зүйн дарамтад орж бүр уйлж, их хүнд байсан.”
- “Хоёр жилийн өмнө, нэг бисексуал бас ХДХВ-тэй залуу алуулсан тохиолдол гарсан. Тэгэхэд бас л олон нийтийн дунд ЛГБТИК+ гэдгээрээ илүү бүх хүмүүсийг дуудаж, янз бүрээр дарамталж, мэдээлэл авсан. Тэрнээс өмнө ч бас ЛГБТИК+ хүн амьтан нас барлаа, алууллаа гэхэд бид өөрсдөө ямар их шоконд орсон байгааг үл харгалзан, бид л алчихсан юм шиг их муухай харьцдаг цагдаагийнхан. Гэтэл бид өөрсдөө шоконд орсон, магад дараагийн алуулах хүн нь би юм билүү гэж бодож, айж явааг ойлгодоггүй.”
- “2009 оны турш би эмэгтэй хувцас өмсөж транс найзуудтайгаа гадаа явдаг байсан. Тэгэхэд хүмүүс чулуу, угаадас зэргээ бидэн рүү шиднэ, нэг удаа бүр шээсээр зуурсан шавхай ч бидэнд шидэж байсан. За яах вэ гэж бодоод усанд орчихно, хувцсаа солиод гарна. Гэтэл хэдхэн удаа биднийг зүвзүгээр юм яриад гадаа зогсож байхад биднийг хэдэн залуучууд ирээд зодсон. Тэгээд цагдаа дуудаад, хамт цагдаагийн хэсэг рүү очиход “Та нар чинь эр юм байж яах гэж эмэгтэй хувцас өмссөн юм? Хохь чинь, битгий цаг үрээд бай” гээд гаргаж байсан. Гэтэл би транс эмэгтэй, яах ёстой юм?”

Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийн золиос нь зөвхөн ганц хүн биш, бүхэл бүтэн олон нийт болдог. Тухайн олон нийтийн онцлох онцлогоор нь бай болгож үйлдэгдсэн гэмт хэрэг нь бүхэл бүтэн олон нийтийн эсрэг байдаг утгаараа олон улсын эрх зүйн хэм хэмжээ болоод ихэнх оронд энгийн гэмт хэргээс илүү хүнд ялтай байдаг. 2009 оны 9-р сарын сүүл, 10-р сарын эхээр гарсан трансжендэр охидыг

70 давхар оршуулгын газар аваачиж хүчирхийлсэн явдал нь ЛГБТИК+ хүмүүсийн дунд нэн сэтгэл түгшсэн, тайван бус, айдсын нөхцөл байдал үүсгэсэн байсныг тухайн үед ЛГБТИК+ олон нийт ЛГБТ Төвд хэлж байсан. Тиймээс үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг нэн даруй тодорхойлж, ийм төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн эрх зүйн үйлдсэн гэмт үйлдэлтэй нь буюу бүхэл бүтэн олон нийтийг хүчирхийлсэн гэсэн утгаар хүнд ялтай болгож, нийгэмд томоохон дохио өгөхөөс нааш ЛГБТИК+ залуус ялангуяа нээлттэй амьдарч эхэлж буй Монголын нөхцөлд ийм төрлийн гэмт хэргүүд улам хүндэрсээр байх болно гэдгийг цохон тэмдэглэх ёстой. Цаашлаад үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн сэтгэл зүй болон трансжендэр хүмүүстэй хэрхэн харьцах, трансжендэр хүмүүсийг ойлгох, мэдрэмжтэй ажил үүргээ гүйцэтгэх талаар цагдаагийн байгууллагын албан хаагчдад мэдээлэл сургалт байнгын давтамжтай өгөх, энэхүү гэмт хэрэгт цагдаа, прокурор, шүүхийн зүгээс мэдрэмжтэй хандах, хохирогчидтой зүй ёсны харьцах, давхар, дам хохироохгүйн тулд анхаарч ажиллах ёстой.

Эрүүл мэндийн байж болох дээд жишгийн үйлчилгээг хүртэх, эрүүлийг хамгаалах салбарын буруу, зохисгүй үйлдлээс хамгаалагдах эрхүүдийн хэрэгжилт

Эрүүл мэндээ хамгаалуулах асуудлаар хоёр асуулт багтсанаас эмч, эмнэлгийн байгууллагад хандахад ямар нэгэн бэрхшээл байдаг эсэх асуудал дээр оролцогчдын 61.7% нь “ЛГБТИК+ гэдгээ мэдэгдвэл бэрхшээл тулгарна гээд хэлдэггүй”, 10% нь “бэрхшээл байдаг”, 8.3% нь “ЛГБТИК+ гэдгээ хэлдэггүй учир бэрхшээл байгаагүй”, 20% нь “бэрхшээл байдаггүй” гэж хариулсан. Хоёр дах асуулт болох бэлгийн чи баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөн, эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй тохиолдол байсан эсэх асуултад 8% тийм, 92% үгүй гэж хариулсан байна. Фокус ярилцлагаар энэхүү асуултыг задалж, ЛГБТИК+ хүмүүсийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх хэрэгжиж буй талаар яриа өрнүүлэхэд:

- “ЛГБТИК+ хүмүүсийн эрүүл мэндийн асуудал гээд нийтэд нь яриад байна. ЛБ хүмүүсийн эрүүл мэндийн онцлог асуудал тусдаа, ГБ хүмүүсийн эрүүл мэндийн онцлог асуудал тусдаа, трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн онцлог асуудал тусдаа. Миний бодлоор эрүүл мэндээ дээд зэрэгт хамгаалуулж байгаа гэж хэлэхгүй. Транс хүмүүс л гэхэд ямар нэгэн эмнэлэг дээр очоод дааврынхаа шинжилгээг өгье гэж бодоход тэрийг нь уншаад, шинжлэх ухаанчаар бүрэн тайлбар өгчих мэдлэгтэй мэдээлэлтэй эмч нар хэд билээ. Л

эмэгтэйчүүдийн асуудал байна. Ороход нь л урдаас нь шууд “Нөхөртэй юу?” гэж эхлээд асуучихаар тэд нар яаж бүрэн дүүрэн хариулах вэ, эрэгтэй хүнтэй унтдаггүй хүмүүс. ЛБ эмэгтэйчүүдийн хувьд урьдчилан сэргийлэх гэсэн ойлголт байдаггүй, маш олон төрлийн эмзэг байдал байдаг ч тэрийгээ мэддэггүй. “Хамгийн аюулгүй секс” гээд баясаад явдаг ч бэлгийн замын өвчнөөс ч илүү эрүүл мэндийн эмзэг байдал байдгийг мэддэггүй. ГБ залуусын асуудал бас өөр. Илүү бэлгийн аюулгүй талаас. Гэхдээ ядаж урьдчилан сэргийлэх арга замаа мэдээд, шинжилгээндээ хамрагдаад явдаг. Транс хүмүүсийн асуудал хамгийн эмзэг байгаа.”

- “Хүүхдээ гаргаж байхад найз охиныг минь оруулахгүй байсан. Зөвхөн эцгийг нь оруулна гэдэг юм билээ. Гэтэл хоёр ээжтэй хүүхэд бол яах вэ? Бид гурав шиг л хамгийн нандин үедээ хамт байж чадахгүй.”
- “Эрүүл мэнд гэхээр өвчин зовлон боддог. Гэтэл сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал маш их орхигдсон асуудал.”
- “Гэр бүлээсээ санаа зовсноосоо болоод архи маш их уудаг болсон.” “Эрүүл байна гэдэг бүхэл ойлголт. Одоогоор ЛГБТ хүмүүсийн эрүүл мэндийн онцлог нарийн асуудлуудыг бүгдийг нь ойлгож, нээлттэй, ээлтэй байдлаар зохицуулах тогтолцоо Монголд алга. Архидалт, тамхидалт гээл нийгмийн хувьд байдаг асуудлууд ЛГБТИК+ хүмүүсийн хувьд илүү хурц, хүнд болсон байдаг.”
- “Транс хүмүүс эрүүл мэндээ хамгаалуулах, хувийн нууцаа хадгалах ямар ч боломжгүй байгаа. Наад зах нь хүйсийн шилжилтийн дааврын эмчилгээний тухай мэдлэгтэй эмч нар байхгүйгээс болж трансжендэр эрчүүдийн хувьд ирээдүйд хорт хавдар, трансжендэр эмэгтэйчүүдийн хувьд зүрх судасны өвчин, ясны өвчин гээд өчнөөн олон асуудал үүсэхүйц байгаа. Яах вэ, өөрсдөө мэдээд дэлхийн жишигт нийцсэн дааврыг нь олоод хэрэглэхчлээ гэж бодоход үнэ нь дийлдэшгүй. Үүнийг болон хагалгаануудыг эрүүл мэндийн даатгал уул нь хамардаг баймаар юм.”
- “ХДХВ-тэй амьдарч буй гей, бисексуал залуучуудын хувьд эм нь олдоггүй, байдаг эм нь маш цөөн төрлийн, тэр нь зарим хүмүүст таардаггүй, хор уршиг ихтэй, хордлого их гэдэг, Т-эсийг нь дэмждэггүй. Хэчнээн эрүүл мэндийн байгууллагад байгаа хүмүүс нь бэлгийн чиг баримжаагаар ялгаварлахгүй байлаа ч гэсэн тогтолцооны хувьд хүнийг бүхэлд нь эрүүлийг

нь хамгаалах, хангах орчин үүсээгүй байгаа нь тэгвэл тогтолцооны ялгаварлан гадуурхалт биз дээ.”

Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн дээд зэргийн үйлчилгээ хүртэх эрх ЛГБТИК+ хүмүүсийн хувьд нэлээд хаалттай, ялангуяа лесбиян болон бисексуал эмэгтэйчүүд, трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн асуудал орхигдсон. ЛГБТ Төв нь 2011 оны сүүлээр Гэр бүлийн сайн сайхны төлөө олон улсын нийгэмлэгийн Монгол дахь салбартай хамтын ажиллагааны түншлэлийн санамж бичигт гарын үсэг зуран, ялангуяа лесбиян, бисексуал эмэгтэйчүүд, трансжендэр хүмүүсийн эрүүл мэндийн зарим асуудлыг энэхүү байгууллагатай хамтран шийдэхээр, үйлчилгээ хүргэхээр ажиллаж байгаа ч энэ нь зөвхөн түр зуурын, тогтолцооны хувьд хангалтгүй арга зам юм. Учир нь ЛГБТИК+ хүмүүс хэрэгцээ үүссэн газраа, өөрсдийнхөө эрүүл мэндийг дээд зэргээр хамгаалуулах эрхээ эдлэх ёстой ч энэ нь одоогийн нөхцөлд хэрэгжих үндэслэл багатай байна. Гей, бисексуал эсвэл ЭБЭ залуучуудын БЗДХ-ын тухай мэдээлэл болон үйлчилгээг дан бэлгийн эрүүл мэндийн чиглэлээр дагнан ажиллаж буй ТББ-ууд Глобал сан, НҮБ, ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрөөр санхүүжсэн үйл ажиллагаагаар олон нийтдээ хүргэдэг ч бусад ЛГБТИК+ олон нийтийг бүхэлд нь хамраад байгаа архидалт, тамхидалт болон, лесбиян, 59 бисексуал эмэгтэйчүүд болон транс хүмүүсийн халдварт бус өвчин, эмгэг, эмзэг байдлын тухай, мөн хүйсийн шилжилттэй холбоотой салбарын мэдлэг, бодлого, зохицуулалт огтбайхгүй байгаа нь эдгээр хүмүүсийн эрүүл мэндийн байж болох дээд жишгийн үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа, мөн эмнэлгийн буруу, зохисгүй үйлдлээс хамгаалагдах эрх нь хаагдмал байгааг харуулж байна.

Гэр бүл үүсгэх эрхийн хэрэгжилт

Энэхүү асуултыг асуулгаар биш, фокус бүлгийн ярилцлагаар тодруулсан юм.

- “Ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрчихвөл би найз залуутайгаа гэрлэх юм сан гэж хүсдэг. Бид хоёр сүйн бөгж солилцсон, хамт амьдардаг хос ч хүн болж төрснийх хайрттайгаа, олон жил хамт амьдарсан хүнтэйгээ гэрлэж үзмээр байна. Бүх стрэйт хүмүүс гэрлээд, салаад, дахин гэрлээд байхад бид тэгэх ямар ч боломжгүй байгаа нь томоос том ялгаварлан гадуурхалт.”
- “Олон жил хамт амьдарсан эхнэртэйгээ гэрлэлтээ батлуулчихвал нэг нь бас барлаа гэхэд бидний хамтын эд хөрөнгийн асуудалд хамаатан садан оролцох эрхгүй болно, бас хоёр хүүхдийн асуудалд санаа зовохгүй болно гэж боддог.”

- “Гэр бүлээ үүсгээд явж байгаа хүмүүс зөндөө л байна. Гэхдээ албан ёсоор гэрлэлтээ батлуулах боломжтой болбол гэр орныхон ч гэсэн хүлээн зөвшөөрөхгүй гээд яах вэ. Хүлээн зөвшөөрнө. ЛГБТИК+ хүмүүсийн хувийн амьдрал нь ийм байдлаар тогтвортой боллоо гэхэд ажил, мэргэжлийн хувьд ч илүү үр бүтээлтэй байх болов уу гэж боддог.”
- “Гэрлэхихсэнхос байлаагэхэд бүх зүйлдээ рилүү баталгаатай болох юм шиг санагддаг.”
- “Гэр бүл гэдэг тодорхойлолтоо илүү өргөн болгох шаардлагатай. Хууль нь байсан ч, байгаагүй ч хамтын, гэр бүлийн амьдрал зохиогоод явж байгаа хосууд маш олон байдаг. Эрх зүйн үндэслэлээр баталгаажуулах нь үр хүүхдийн асуудлыг ч шийдэх байх. Ялангуяа гей залуусын хувьд хүүхэд өргөж авъя гэж хүсэхэд хоёр гей хүнд хүүхэд өргүүлэхгүй ч юм уу, тийм асуудал байгаа.”
- “Гэр бүлийн хүчирхийлэл ижил хүйсийн хосуудын дунд байгааг гэр бүл гэдэг тодорхойлолтоор тэлчихвэл нийг шийдэх ч арай дөхөм болно.”

Гэр бүл үүсгэх, өөрийнхөө гэр бүлийг төрөөр хүлээн зөвшөөрүүлэх, гэр бүлээ төрөөр хамгаалуулах, эцэг эх болох эрх нь Монгол иргэн бүрт олгогдсон эрх байдаг ч энэ эрх ЛГБТИК+ хүмүүсийн хувьд огт хангагдахгүй байгаагаас үүдэн ЛГБТИК+ хүмүүсийн хүүхдүүд болон хамтын эзэмшлийн өмч хөрөнгийн хувьд асуудал үүсдэг. Тиймээс үндсэн 60 хуулиар олгогдсон ЛГБТИК+ хүмүүсийн энэхүү эрхийг эдлүүлэх, тэгснээр хүүхдүүдийнх нь эрх ашиг, өмч хөрөнгийг нь хамгаалах асуудал тулгарч байна.

Нийгмийн ялгаварлан гадуурхалт

Монголын нийгэм ЛГБТИК+ хүмүүсийг хэр хүлээн зөвшөөрдөг гэж үздэг тухай асуултад оролцогчдын 3.3% нь “энгийн”, 1.7% нь “ерөнхийдөө сайн”, 95% нь “огт хүлээн зөвшөөрдөггүй” болон “ерөнхийд хүлээн зөвшөөрдөггүй” гэсэн санал өгчээ. Монголын нөхцөлд ЛГБТИК+ хүн байх нь танд ямар санагддаг тухай асуултад 90% нь “маш тухгүй”, “ерөнхийдөө тухгүй” хэмээн хариулсан ба 5% нь “энгийн”, 3.3% нь “ерөнхийдөө тухтай”, 1.7% нь “маш тухтай” хэмээн хариулсан байна. Нийгмийн зүгээс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй холбоотой дарамт шахалттай тулгарч байсан эсэх тухай асуултад оролцогчдын 43.3% нь “байнга тулгардаг”, 36.7% нь “ЛГБТИК+ гэдгээ мэдэгддэггүй болохоор үгүй”, 16.7% нь “ихэнх хүмүүс хүлээн зөвшөөрдөггүй учир ЛГБТИК+ байдлаа нуудаг”, 3.4% нь “амьдрал тодорхойгүй, сэтгэлийн дарамтад явдаг” гэжээ. Фокус бүлгийн ярилцлагаар ямар төрлийн

нийгмийн шахалт, дарамт байдаг талаар, мөн яагаад тухгүй санагддаг талаар тодруулахад:

- “Ялгаварлан гадуурхалт гэж ер нь хүний өөрийгөө илэрхийлж байгаа байдал надад таалагдахгүй байлаа гэхэд түүнийгээ үйл хөдлөл, үзэл бодлоороо илэрхийлж, гутаан доромжилж байгаа байдлыг л хэлдэг.”
- “Жишээ нь намайг эрэгтэй хувцас өмсчихсөн явж байхад “Чи эмэгтэй юм бол эмэгтэй хувцас өмсөж, эмэгтэй хүн шиг байгаач, алхаа гишгээ чинь яачихсан юм” гэж миний дотоод сэтгэлийг ойлгохгүй, өөрийн үзэл бодлоо тулгадаг.”
- “Гетеросексуал хүмүүст ЛГБТИК+ хүмүүсийг ойлгох мэдлэг, мэдээлэл байдаггүй, гадуур явж байхад “гомонууд зайл” гэж хэл амаар доромжлох явдал байнга гардаг.”
- “Насаараа гэрлэдэггүй ээ, гомбын гозон царайлаад, оройтлоо, үр хүүхэд гарга” гэж бүх хүмүүс намайг хэлдэг”.
- “Багаасаа л охин шиг, дандаа охидтой тоглодог байсан болохоор байрныхан янз бүр хэлнэ. Гэртээ харьж явахдаа хаанаас хэн гарч ирээд зодчих бол гэж айдаг байсан.”
- “Зарим үйлчилгээний байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалздаг, харагдах байдлаас минь болж. “Манайх гомо хүмүүст үйлчлэхгүй” гэж хэлүүлж байсан ч удаа нэлээд хэд бий.”
- “Гэр хорооллын нөхцөлд хүмүүс мэдчихээд орой үдэш ажил тараад явж байхад мөнгө салгахын тулд дарамтлах явдал гардаг.”
- “Дэлгүүрт ороод сонголтоо хийхээр явж байтал худалдагч “Хулгайч царайлсан гомо чинь гар гар” гэж хөөж байсан.”
- “Хэт эмэгтэйлэг байна гэж хэлүүлэх нь элбэг байдаг. Гэтэл би өөрийнхөөрөө л байгаа нь энэ. Эршүүд болох гээд хичээгээд хичээгээд чадахгүй.” - “Гэрлэх нас болж буй тухай сануулга аймаар санагддаг, учир нь “гэрлэх нас боллоо, нөхөрт гарах болоогүй юу, нөхөрт гараач” гэх хүмүүс олон байдаг.”
- “Гэр бүлийн гишүүд болон нийгэм эмэгтэй хүнтэй гэрлэхийг тулгаж байна, хамгийн хэцүү нь цаашид ямар хүнтэй амьдрах вэ гэдэг тодорхойгүй байна.”
- “Сэтгэлийн дарамт ихэнхдээ тулгардаг. Хааяа үхчихмээр ч санагддаг.”
- “Гудамжинд сонжиж харах, эсвэл хүүхэн шиг гэж хэлдэг, эхнэр авдаггүй сонин хүү шүү гэж хэлэх нь элбэг”.

- “Нэг удаа амралтад олуулаа явж байхад хэдэн халамцуу ах нар “Эр эм нь мэдэгдэхгүй гомо бандийг алнаа” гээд нэгийг маань зодож байсан.”
- “Заримдаа баар цэнгээний газар орохоор хамгаалагч, ажилчид нь муухай харах, “гомо нарт үйлчлэхгүй, эсвэл хүнгүй газар дээшээ суу” гэх зэргээр ханддаг. Дэлгүүр хоршооноос өөрийн сонирхсон зүйлээ худалдаж авна гэхээр худалдагчид нь бөөгнөрч зогсчихоод шивнэлдэж, шоолж инээх асуудал гардаг. Нэг удаа өсгийтэй гутал авах гэсэн чинь “Чи өөртөө биш биз дээ? Чи гаж донтой юм уу?” гэж асууж байсан.” Нийгэмд ЛГБТИК+ хүмүүсийн өдөр тутам амсаж буй ялгаварлан гадуурхалт нь ЛГБТИК+ хүмүүсийг эх орноо орхин явах тухай хүртэл бодогдуулж байгааг “Та цагаачлах тухай бодож байсан уу?” гэсэн асуултаар мөн хэмжиж болно. Энэ асуултад 73.3% нь “тийм”, 26.7% нь “үгүй” гэж хариулжээ. Фокус бүлгийн ярилцлагаар энэх асуултыг цааш задлахад:
- “Транс хүмүүсийн амьдрал хэцүү байдаг тул явмаар л байдаг. Ядаж байхад Монгол цөөхүүлээ, тэгээд хүн болгон бие биеэ мэддэг болохоор хувийн нууцтай байх ямар ч боломжгүй.”
- “Монголын нийгэмд ЛГБТИК+ хүмүүсийг ялгаварлахгүй гээд хууль гаргуулчихвал явмааргүй байна, гэхдээ хааяа боддог. Байнга сэтгэлдээ нууц тээх хэцүү байдаг тул заримдаа ээлтэй газар руу явах хүсэл байдаг.”
- “Гэр орныхонтойгоо ойлголцохгүй, элдвээр хэлэгдэх үед явмаар санагддаг, үргэлж ганцаардаж байхаар хаа нэг газар очиж эрх чөлөөтэй, өөрийнхөөрөө байх тухай бодогдох үед явмаар л санагддаг.”
- “Монголын нийгэм нээлттэй сайхан бол хэн ч эх орноосоо явахыг хүсэхгүй, гэхдээ нөхцөл байдал хүнд л байна. ЛГБТИК+ байдлаасаа болоод ямар ч шударга 62 ёсыг олж мэдрэхгүй байгаа тохиолдолд цагаачлах ч биш, бүр дүрвээд явмаар санагддаг.”
- “Нийгмийн болон хууль зүйн орчин таагүй санагдах үед, байнга биеэ барих шаардлага үүсдэг нь сэтгэл зүйн хувьд дарамт үүсгэдэг, тиймээс хаа нэг эрх чөлөөтэй газар очихыг хүсдэг”.

Хүний эрхээ эдлэх, хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрхүүдийн хэрэгжилт

“Та ЛГБТИК+ хүмүүстэй ажилладаг байгууллагуудад хэр ханддаг вэ?” гэсэн асуултад 11.7% нь “хандаж байсан”, 26.7% нь “цөөн удаа

хандаж байсан”, “ихэнх тохиолдолд ханддаг” гэж 13.3% нь хариулсан бол ханддаггүй гэж 48.3% хариулсан байна. Эрх нь зөрчигдсөн ч эрхээ сэргээлгэх талаар мэдлэггүй, эрхээ сэргээлгэх гэж яваад ч хэрэггүй, ямарваа үр дүнд хүрэхгүй учир гэсэн хандлага ЛГБТИК+ олон нийтийн дунд байгаа нь илт байв. ЛГБТИК+ хүний эрхийг хангахад төрийн зүгээс ямар арга хэмжээ авах хэрэгтэй талаар судалгаанд оролцогчдын 27% буюу 17 хүн нэмэлт сэтгэгдлээ бичсэнээс түүвэрлэж оруулбал:

- “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл аль болох ёс зүйтэй хариуцлагатай, үнэн зөв, бодит, ЛГБТИК+ хүмүүсийн талаар эерэг мэдээлэл түгээх, авьяас чадварыг нь тодотгосон сайн талыг нь тодотгодог болоосой.
- Бидний талаар янз бүрийн худал мэдээлэл их байдгаас биднийг гаж амьтад гэх сэтгэхүй байгаа нь цөөнгүй ажиглагддаг.” “Хэвшмэл ойлголтыг арилгах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай. Төрийн зүгээс хууль сахиулах байгууллагынханд бэлгийн чиг баримжааны тухай сайн мэдлэг, мэдээллийг өгдөг болбол бид хохирогч, мөн давхар хохирогч болох эрсдэлээс хамгаалагдах боломжтой болно.”
- “Лесбиян хосын амьдралд нэгийгээ хардалтын улмаас хүчирхийлэх явдал гардаг ба үүнийг хэнд, хаана, хэрхэн шийдвэрлүүлэх талаар мэдлэг бидэнд дутмаг байдаг.”
- “ЛГБТИ хүмүүсийн дунд бие биеэ ялгаварлах явдал цөөнгүй гардаг. Ялангуяа лесбиян хосуудын дунд хардалтын улмаас зодох, цохих, дарамтлах үед өөрийгөө хэрхэн хамгаалахаа мэддэггүй. Тиймээс нуугдмал байх биш, нийтийн дунд ил тод чөлөөтэй өөрийгөө илэрхийлж нийгэмшиж амьдрах нөхцөл боломжоор хангаасай гэж хүсэж байна.”
- “Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид өөрсдийгөө сайн боловсруулж чадавхжуулах, хүний эрхийг дээдлэх ухамсарт сэтгэхүйтэй болох ёстой.”
- “Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гардаг буруу зөрүү мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариуцлага тооцдог байгаасай. Мэдээлэл түгээхдээ ЛГБТИК+ хүмүүсийн тухай үнэн зөв ярьдаг болоосой. Монголын нийгэм ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолоос дан ганц бэлгийн чиг баримжаа гэлтгүй анхаараасай гэж хүсэх юм. Төр үүнд чиглэсэн тууштай бодлого баримтлах ёстой гэж бодож байна. 1. Хууль эрх зүйн орчноо ЛГБТИК+ хүмүүст ээлтэй болгоход тууштай бодлого хэрэгжүүлэх. 2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөв, бодитой мэдээллийг хүргэдэг болох. 3. Төрийн байгууллага,

албан тушаалтнууд өөрсдөөсөө эхэлж ЛГБТИК+ хүмүүсийн талаарх хандлагаа зөв тийш нь өөрчлөөсэй гэж бодож явдаг, нөлөөллийн ажлыг нийгмийн бүх давхаргад явуулах хэрэгтэй байна.”

- “Ямар ч тохиолдолд телевиз, сонин, радио, интернет зөв, бодитой, эерэг мэдээллийг өгдөг байх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хэвлэл, мэдээллийн ажилтнуудыг зөв мэдээллээр хангах хэрэгтэй байна.”
- “ЛГБТИК+ олон нийтийн эрх ашгийг хамгаалсан хуультай болох. ЛГБТИК+ хүний эрхийг хамгаалахын тулд эхлээд хуульдаа тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Түүний дараа нийгэмд тайлбарлан ойлгуулах нь хялбар болно, мөн ЛГБТИК+ хүмүүст зориулсан цогц төв байвал төвөөр дамжуулан эрүүл мэндийн болон хүний эрхийн мэдлэг, мэдээллээ гэвэл зүгээр санагддаг.”
- “Нийгэмд хүртээх хүртээмж талаасаа судалгаа, сургалтын үр дүнг хүмүүст байнга ярьж, сонсгож байсан нь дээр байх, гэр бүлийн нээлттэй сэдэв эсвэл насны онцлогоос хамаарч нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг байвал нийгэмд ойлголт илүү хурдан түгнэ гэж бодож байна.”
- “Монголын нөхцөлд ижил хүйстэн болоод төрсөн нь гэмт хэрэгтэн шиг санагддаг. Үргэлж нуугдаж, бусад хүмүүст үргэлж худлаа хэлэх шаардлага гардаг. Тиймээс ЛГБТИК+ хүмүүс бусадтай адил хүн гэдэг талаас нь ойлголт өгөх, ялангуяа өсвөр насныханд илүү их мэдээлэл шаардлагатай.”
- “Эхлээд Монголын иргэдийг ЛГБТИК+ хүмүүсийн талаарх бага ч гэсэн мэдлэгтэй, мэдээлэлтэй болгох хэрэгтэй. Үүний дараагаар эрх зүйтэй холбоотой асуудал ярих хэрэгтэй. Хэрэв шууд хууль тогтоомжтой болбол хүмүүс илүү их үзэн ядалттай болж магадгүй. Энэ судалгаа их таалагдаж байна, би ганцаараа ийм биш гэдгээ мэдэж авлаа. ЛГБТИК+ хүмүүс ялгаварлалд өртдөг шалтгаан нь мэдлэггүй байдлаас болж гардаг. Мөн монголчуудын уламжлалт сэтгэлгээ нөлөөлдөг.”
- “Гол авах арга хэмжээ нь ЕБС-уудад энэ тухай мэдлэг, мэдээллийг олгох, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах шаардлагатай. Мөн урлаг, уран сайхны байгууллагуудтай тулж ажиллах хэрэгтэй байна. Тэдгээр хүмүүс нийгэмд урлагаар дамжуулан нийгэмд буруу дүр төрх, ойлголтыг өгөх явдал элбэгшиж байгаа, хошин шог, кино гэх мэт жишээ бий. Ер нь Монголд ялгаварлах үзэгдэл маш их байдаг. Дан ганц бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл гэлтгүй хүнийг хүн гэдэг үүднээс нь ханддаг

болоосой гэж хүсдэг. Хүмүүс хүний гадаад байдал, зан ааш, хийж буй үйлдэл зэргээс нь хамаарч доромжлон гадуурхаж байдаг. Хүн ЛГБТИК+ ч байж болно, биш ч байж болно тиймээс хүнийг хүнээр нь, надтай адил хүн гэдэг үүднээс хандаж байгаасай гэж хүсдэг.”

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДААС АВСАН СУДАЛГААНЫ ДҮН

Төрийн албан хаагчдаас авсан судалгааны асуумж удирдамжид заагдсаны дагуу нийслэлийн 7 дүүргээс оролцогчдын 60%, 40% нь Дархан-уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-өндөр, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ гэх мэт аймаг сумуудад ажиллаж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, багш, эмч, нийгмийн ажилтнуудыг хамруулсан болно. Нийтдээ 60 хүн хамрагдсанаас эмч 13.3%, хэрэг бүртгэгч 11.7% сургуулийн нийгмийн ажилтан 11.7% мөрдөн байцаагч 26.7%, багш 36.7% байв. Үүнээс эрэгтэй 36.7%, эмэгтэй 63.3%, насны 65 хувьд 18-23 насны 10%, 24-29 насныхан 38.3%, 30-35 насныхан 30%, 36 наснаас дээш насныхан 21.7% хувьтай оролцжээ. Үндэсний болон шашны цөөнх оролцогчдын 11%- ийг эзэлж байсан. Боловсролын түвшнээр 96.7% нь дээд, 1.7% дунд, 1.7% бүрэн дунд боловсролтой гэжээ. Бэлгийн чиг баримжааны хувьд 90% нь гетеросексуал, 3.3% нь бисексуал, 6.7% нь аль нь ч биш хэмээн хариулжээ.

“Ижил хүйсийн бэлгийн харьцааг хүлээн зөвшөөрөх тал дээр таны бодол?” гэсэн асуултад 11.7% нь “хангалттай хүлээн зөвшөөрнө” гэсэн бол 33.3% ерөнхийдөө хүлээн зөвшөөрнө, 11.7% нь “зөвшөөрөх, зөвшөөрөхгүйн аль нь ч биш”, 33.3% нь “ерөнхийд хүлээн зөвшөөрөхгүй”, 10% нь “огт хүлээн зөвшөөрөхгүй” гэж хариулсан байна. “Аль нь ч биш” хэмээх асуултыг бодлоготойгоор оруулсан нь сөрөг сэтгэхүй, ойлголттой байгаа хүмүүсийн үзэл бодлыг шууд бус байдлаар илэрхийлэх арга байсан ба энэхүү хариултыг сөрөгт тооцсон. Төрийн албан хаагчдын дийлэнх буюу 55% нь сөрөг хариу өгсөн.

“Трансжендэр хүмүүсийг хүлээн зөвшөөрөх тал дээр таны бодол?” гэсэн асуултад 8.3% нь “хангалттай хүлээн зөвшөөрнө”, 28.3% нь “ерөнхийдөө хүлээн зөвшөөрнө” гэж үзсэн бол 21.7% нь “аль ч биш”, 29% нь “ерөнхийдөө хүлээн зөвшөөрөхгүй”, 9% нь “огт хүлээн зөвшөөрөхгүй” гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд оролцогчдын дийлэнх буюу 63.4% нь трансжендэр хүмүүсийг хүлээн зөвшөөрөхгүй гэжээ.

“Таны танилын хүрээ (ажлын хамт олон, сургуулийн хамт олон, найз нөхөд болон гэр бүлийнхэн) ЛГБТ хүмүүст хэрхэн ханддаг

вэ?” гэсэн асуултад 13.3% нь “маш муу”, 51.7% нь “ерөнхийдөө муу”, 33.3% нь “энгийн”, 1.7% нь “маш сайн” гэж хариулжээ. Үүнээс зэхэд төрийн албан хаагчдын 65% нь ЛГБТ хүмүүсийн тухай нийгэм бүхэлдээ сөрөг хандлагатай байгааг хүлээн зөвшөөрсөн.

“Таны гэр бүл, дотнын хүмүүсийн дунд ЛГБТ хүн байвал хэрхэн хүлээж авах вэ?” гэсэн асуултад 18.3% нь “маш тухгүй”, 36.7% “ерөнхийд тухгүй байдлыг мэдэрнэ” гэж хариулсан бол 45% “энгийн” гэж хариулсан байна.

“Таны ажлын хамт олны дунд ЛГБТ хүн байвал та хэрхэн хүлээж авах вэ?” гэсэн асуултад 8.3% нь “маш тухгүй”, 30% нь “ерөнхийд тухгүй”, 60% нь энгийн, 1.7% нь “ерөнхийдөө тухтай” гэж хариулсан байна.

“Та ажил олгогч бол нээлттэй амьдардаг ЛГБТ хүмүүсийг ажилд авах уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан 56.7%, “жирийн л хүн учир авна” гэж хариулсан нь 66.3%, “мэдэхгүй” гэж хариулсан нь 3.3%, 1.7% нь “ажиллаж чадаж байвал хүйс хамаагүй” гэж хариулжээ. Эдгээр 60 оролцогчдоос зөвхөн 2 хүн нь буюу 3.3% нь ЛГБТ хүмүүсийг энгийн хүмүүс гэж үзсэн байхад бусад нь “энгийн бус” хэмээн үзсэнийг энэ асуултаас харж болно. “Та ажлын байран дээр ялгаварлан гадуурхалтын эсрэг арга хэмжээ авч чадах уу?” гэсэн асуултад 68.3% нь “тийм”, 30% нь үгүй, 1.7% “мэдэхгүй” гэжээ.

“Таны ажил үүргийн шугамаар ЛГБТ хүн хандвал хэрхэн хүлээж авах вэ?” гэсэн асуултад 5% нь “маш тухгүй”, 11.7% нь “ерөнхийд тухгүй”, 81.7% нь “энгийн” гэж хариулсан бол, 1.7% нь “ерөнхийдөө тухтай” гэж хариулсан байна. Энэхүү асуултыг задлахдаа “ерөнхийдөө тухтай” гэснээс бусад хариултыг сөрөг гэж үзэх үндэслэл дээрх асуултуудаас үүссэн учир судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 98.3% нь тухгүй, эвгүйцсэн байдлаар хандах магадлал өндөр хэмээн үзнэ.

“Танд илт мэдэгдэх ЛГБТ хүний хажууд байх ямар санагдах вэ?” гэсэн асуултад 13.3% нь “маш тухгүй”, 40% нь “ерөнхийдөө тухгүй”, “энгийн” гэж 46.7% нь хариулсан байна.

“Та ажлын бус орчинд ЛГБТ хүнтэй нүүр тулбал танд ямар санагдах вэ?” 10% нь “маш тухгүй”, 23.3% нь “ерөнхийдөө тухгүй”, 65% нь “энгийн”, 1.7% “ерөнхийдөө тухтай” гэж хариулжээ.

“Танд ЛГБТ хүнтэй тулж харьцахад ямар санагдах вэ?” гэсэн асуултад 8.3% нь “маш тухгүй”, 35% нь “ерөнхийдөө тухгүй”, 55% нь “энгийн”, 1.7% нь “ерөнхийдөө тухтай” гэжээ.

“Танд олон нийтийн газар ЛГБТ хүнтэй харьцвал ямар санагдах вэ?” гэсэн асуултад 10% нь “маш тухгүй”, 30% нь “ерөнхийдөө тухгүй”, 58.3% нь энгийн, 1.7% нь “ерөнхийдөө тухтай” байна гэжээ.

“Бусадтай олон нийтийн газар ЛГБТ хүмүүсийн тухай яриа өрнүүлэхэд ямар санагддаг вэ?” гэсэн асуултад “маш тухгүй” 6.7%, 33.3% нь “ерөнхийдөө тухгүй”, 55% нь “энгийн”, 5% нь “ерөнхийдөө тухтай” гэж хариулсан байна.

“Та ЕБС болон боловсролын бусад орчинд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай мэдлэг олж авч байсан уу?” гэсэн асуултад 25% нь “тийм”, 50% нь “үгүй”, 25% нь “бага зэрэг мэдээлэл авч байсан” гэж хариулжээ.

“ЛГБТ хүмүүсийн талаар ямар нэгэн сонин, сэтгүүлээс мэдээлэл авч байсан уу?” гэсэн хариултад 18.3% нь “үгүй”, 58.3% нь “тийм, эерэг сөрөг мэдээллийг зэрэг авсан”, 23.3% “сонирхож байгаагүй” гэж хариулжээ.

“ЕБС-ийн хөтөлбөрт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар тусгаж өгөх нь таны бодлоор?” гэсэн асуултад “хэрэгтэй” гэж 58.3%, “хэрэггүй” гэж 8.3%, “байж болно” гэж үзсэн нь 33.3% байв.

“Танд ЛГБТ олон нийтийн тухай мэдлэг, мэдээлэл бий юу?” гэж асуухад 5% нь “хангалттай мэднэ”, 26.7% нь “мэднэ”, 51.7% “бага зэрэг”, 16.7% нь “огт мэдэхгүй” гэжээ.

“Та ЛГБТ хүмүүсийн талаар өөрөө судалж байсан уу?” гэж асуусан асуултад “тийм” гэж 5%, 90% нь “үгүй”, 5% “бага зэрэг” гэж хариулжээ.

“Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай мэдээллийг яаж, ямар замаар авбал амар вэ?” гэсэн асуултад 5% нь “ЕБС-иар”, 18.3% нь “интернэтээр”, 16.7% нь “хэвлэл мэдээллээр”, 3.3% нь “телевизийн нэвтрүүлгээр”, 15% нь “сургалтаар” гэж хариулсан бол 40% нь энэ асуултад огт хариулаагүй байна.

“ЛГБТ хүмүүс өөрийн дур зоргоор бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээ сонгодог гэж боддог уу?” гэсэн асуултанд 8.3% нь “тийм”, 46.7% нь “үгүй”, 45% нь “мэдэхгүй” гэжээ.

“Та бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа удамшдаг гэж боддог уу?” гэсэн асуултад 25% нь “тийм”, 73.3% нь “үгүй”, 1.7% нь “мэдэхгүй” гэжээ.

“Таны бодлоор Монголын нийгэм ЛГБТ хүмүүсийг хүлээн зөвшөөрч байна гэж боддог уу?” гэсэн асуултад 18.3% нь “тийм”, 36.7% нь “үгүй”, 45% нь “мэдэхгүй” гэж хариулсан байна.

“Таны бодлоор ЛГБТ хүмүүс Монголын нийгмийн нөхцөлд хангалттай аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөл бүрдсэн гэж боддог уу?” гэсэн асуултад 15% нь “тийм”, 78.3% нь “үгүй”, 5% нь “мэдэхгүй” гээд 1.7% нь энэ асуултад хариулаагүй.

“Таны бодлоор бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа гэж юу вэ?” гэсэн асуултад 56.7% нь хариулаагүй, 5% нь “хүйсийн хувьд аль хүйст татагдаж буй асуудал”, 5% нь “багаасаа өөрийн хүйсийг мэдэрч буй асуудал”, 5% нь “аль хүйсийн хүнд татагдаж буйг илэрхийлэх ойлголт”, 10% нь “төрөлхийн зүйл”, 18.3% нь “мэдэхгүй” гэж хариулсан. Энэхүү асуултыг асуулгад оролцогчдын зөвхөн 25% нь ямар нэгэн байдлаар мэдэж тодорхойлж байсан ба 75% нь мэдэхгүй, мэдэхгүйгээсээ хариулаагүй гэж зэх үндэслэл байна.

“ЛГБТ хүмүүсийн талаар таны бодол?” гэсэн асуултад хүмүүс доорх байдлаар хариу бичжээ. Үүнд: 20% нь “хүний эрхийн асуудал”, 20% нь “байх л зүйл, ойлгоно”, 1.7% нь “өөрөө сонгож чадахгүй учир их хэц асуудал”, 1.7% нь “төрөлхийн бол хүлээн зөвшөөрнө, Монголд ихэнх нь олдмол”, 1.7% нь “ижил хүйстнээ сонирхдог хүмүүст их хэцүү байдаг байх”, 1.7% нь “хүмүүс мэдлэгтэй байх шаардлагатай”, 1.7% нь “балайрал”, 1.7% нь “гаж буруу зүйл”, 1.7% нь “мэдээллийг шат шатанд нь өгөх хэрэгтэй”, 1.7% нь “мэдэхгүй”, 46.7% нь энэ асуултад огт хариулаагүй байна.

Үүнээс дүгнэхэд төрийн албан хаагчдын дунд явуулсан судалгаа нь төрийн албан хаагчид бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар мэдлэг мэдээлэл маш бага, ихэнх нь ЛГБТ хүмүүст сөрөг хандлагатай дээр нийгэм ч эдгээр хүмүүст сөрөг ханддаг гэж үздэгээ илэрхийлжээ. Энэ байдлыг арилгахын тулд шат дараалсан олон нийтийг соён гэгээрүүлэх, мэргэжлийн онцлогт нь тохирох мэдлэг, чадавхыг суулгах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх, биелэлтийг хянах ёстой нь харагдаж байна.

ЛГБТИ ХҮМҮҮС БА ЯДУУРАЛ СУДАЛГААНЫ ҮР ДҮН (2014):

ЛГБТ Төв НҮТББ-аас ЛГБТИ хүмүүсийн дунд нийгмийн ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй ядууралд өртөх эрсдэлийг 2014 оны эхээр судалсан. Судалгаанд 17-50 насны 107 хүн оролцсон ба судалгаанд оролцогчдын 46.8% нь 26 хүртэл насныхан байсан ба үлдсэн 53.2% 26-49 насныхан байсан. Үр дүн:

- 18.7% нь ЛГБТИ байдлаасаа ажлаасаа шалтгаангүй халагдсан.
- 10.3% нь ажилгүй болсон тохиолдолд шууд ядууралд өртөнө гэж хариулсан.
- 21.5% нээлттэй амьдардаг бусад нь гэр бүл, найз нөхөд, ажлын байрандаа хаалттай амьдардаг.
- 10.4% нь ажилгүй.
- 8.4% нь ямарваа орлогогүй.
- 14% нь амьжиргааны доод түвшнээс бага орлоготой.

- 22-23% нь амьдралын түвшин нэн ядуу.
- 40% нь эцэг эх, гэр бүлийнхнээсээ санхүүгийн хувьд хараат байдалтай.

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг нь мэдсэн тохиолдолд ажлын байран дээр ялгаварлан гадуурхалтад өртөх, ажлаас халагдах үүнээс болж амьдралын баталгаа алдагдах, ядууралд өртөх гэх мэт эрсдэл бий болж байна. Ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт болон ажлаас халагдах эрсдэл зэрэг айдсаас болж ЛГБТИК+ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа нууцлахыг хүсдэг гэжээ. Энэ нь хувь хүнд сэтгэл зүйн хувд маш том дарамт учруулдаг бөгөөд хэрвээ хөдөлмөрлөх эрх нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанаас үл хамааран бүрэн хамгаалагдсан байсан бол өөрийн мөн чанарыг нуулгүйгээр амьдрахыг хүсдэг гэдгээ илэрхийлсэн.

ЛГБТИК+ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН (2016):

ЛГБТ Төв НҮТББ НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц-д зориулж 18 наснаас доош насны нийт 19 ЛГБТ хүүхэд, залуучуудаас судалгаагаа авсан байгаа (2016 оны 6 ба 7 сард). Үр дүн нь:

- 79% нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа, илэрхийллээсээ болоод ялгаварлан гадуурхагдаж бас бусдаас тусгаарлагдаж байсан.
- 9.4% нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа, илэрхийллээсээ болоод бие махбодын хүнд хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан.
- 45.16% нь гэр бүл дундаа ялгаварлан гадуурхагдаж, хүчирхийлэлд өртөж бас тусгаарлагдаж байсан.
- 42% нь боловсролын орчинд багш болон ангийн хүүхдүүдэд ялагаварлан гадуурхагдаж, тусгаарлагдаж бас хүчирхийлэлд өртөж байсан.
- 21% нь бэлгийн чиг баримжааны тухай мэдээллийг боловсролын орчинд авч байсан.
- 19 хүүхдийн нэг нь л өөрийгөө гэртээ нээлттэйгээр илэрхийлэхдээ айдаггүй.
- 19 хүүхдийн 2 нь л өөрийгөө найзууддаа болно ангийнхандаа нээлттэй илэрхийлэхээс айдаггүй.

Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай зөв, эерэг, хүртээмжтэй мэдээлэл байдаггүй гэдгийг

судалгаанд оролцсон хүүхдүүд хэлж байсан юм. Мэдээлэл байхгүй байгаа байдал нь хүүхдийн мэдээлэл хайх, авах, ба ашиглах эрхийг нь зөрчиж байгаа юм. Тэдний ашигладаг мэдээллийн их сурвалж нь (анхдагчаас эх сурвалжаас буурах дараалалтай):

1. Сошиал медиа (Facebook, Twitter)
2. Хүүхдүүд бие биеэсээ мэдээлэл авах (аман яриа)
3. Монголын ТВ сувгууд
4. Бусад орны ТВ сувгууд

Хүний эрхээ эдлэхэд тулгардаг хамгийн том бэрхшээл нь гэртээ болон боловсролын орчин дахь ялгаварлан гадуурхалт ба хүчирхийлэл. Сургуулийн бүх л ажилтнууд болон нийгмийн ажилтнууд ЛГБТИК+ хүмүүсийн талаарх мэдлэг чадвараа дээшлүүлэх; ЛГБТИК+ хүүхдүүдэд шинжлэх ухаанч мэдлэг олгох ба ялгаатай байдлыг нь ойлгох чадвартай байх. Трансжендэр хүүхдүүд харин эрүүл мэндийн салбараас хангалттай мэдээл ба тусламж авч чаддаггүй нь тэдний хамгийн том бэрхшээл гэж хэлсэн юм. 2015 ба 2016 онуудад трансжендэр хүүхдүүд улсын болон хувийн сэтгэл зүйч нар болон сэтгэл засалч нар дээр очиход, тэдний мөн чанарыг үгүйсгэн энэ мэдрэмжүүд нь бүгд яваандаа алга болно гэж хэлцгээсэн байдаг (*тэр тусмаа христийн сүмийн нийгмийн ажилтнууд*).

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдэд ЛГБТИК+ хүүхэд, залуучуудын тухай сургалт олгох ба бүрэн хэмжээний ойлголттой болгох нь маш чухал бөгөөд ЛГБТИК+ хүүхэд, залуучуудтай харьцахад ёс зүйн болно мэргэжлийн түвшинд байх хэрэгтэй байна.

МОНГОЛЫН СУРГУУЛЬД ТРАНС* СУРАГЧ БАЙХ НЬ (2023):

2023 онд “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэл болон ЛГБТ Төв НҮТББ нар хамтран “Монголын сургуульд транс сурагч байх нь” кэйс цуглуулгын аргаар хийсэн чанарын судалгааг олны хүртээл болгосон билээ. Энэхүү судалгаа нь англи, монгол хэл дээр бий тул та бүхэн эх хувилбарыг нь ЛГБТ Төвд хандан цаасан эсвэл онлайн хэлбэрээр авч болно.

Судалгааны үр дүн

Тус чанарын судалгааны оролцогчид нь 16-18 насны өөрийгөө транс* болон хүйсийн бусад олон янз байдлаар илэрхийлдэг хүүхэд залуус байв. Нийт долоон транс* сурагч энэхүү судалгаанд оролцож дэлгэрэнгүй, ганцаарчилсан ярилцлагаар дамжуулан өөрсдийн туулж буй амьдралын туршлагыг хуваалцсан болно.

Бид ЛГБТИК+ олон нийтийн харилцаа холбооны сүлжээ болон snowball буюу цасан бөмбөг хэмээх аргачлалаар судалгаанд оролцогчдыг сонгож холбоо тогтоосон билээ. Транс* олон нийт нь Монголд хамгийн ихээр гадуурхагдан орхигдсон нийгмийн бүлэг бөгөөд эндээс насанд хүрээгүй оролцогчдыг дээжлэн сонгох нь хүнд сорилт байв. Тиймээс ч цасан бөмбөг хэмээх аргачлал буюу ярилцлагад оролцсон оролцогч нь өөрийн танилын холбоогоор дамжуулан дараагийн оролцогчийг санал болгох нь энэхүү судалгаанд тохиромжтой байв.

Энэхүү чанарын судалгааны үрдүнд гарсандүгнэлтүүд бүгд туйлын хор хөнөөлтэй байсаар байгаа багш сурган хүмүүжүүлэгчдийн хандлага, сургуулийн орчны талаар шүүмжтэй эргэцүүлэмж огт байхгүй байгааг илтгэж байна. Ийнхүү хэзээ ч шүүмжлүүлж үзээгүй үндэсний боловсролын систем дэх хүйсийн хэвшмэл байдлыг өөрчлөх томоохон сорилт транс* сурагчдын өмнө үлдэв. Хүйсээр ангилан хуваах нь сургуулийн орчинд ил тод хэрэгжиж байдаг бөгөөд өдөр тутмын заах аргазүйн үйл явцаас эхлээд сургуулийн анги танхим, материаллаг бааз хүртэл өөрчлөлтөд хариг энэхүү соёл боловсролын системийн бүрдэл хэсэг бүрд нэвчин оршсоор байна. Судалгааны үр дүнд үндэслэн дүгнэхэд сургуулийн орчинд транс* сурагчдад чиглэсэн ямар нэг дэмжлэг тусалцаа үгүй бөгөөд сурагчдад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаар сүүлийн 20 жилийн турш зааж байгаа боловч багш нарын ЛГБТИК+ сурагчдад хандах хандлагад төдийлөн эерэг өөрчлөлт гараагүй байна. Хэдийгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны тухай сэдэв 9 дүгээр ангийн эрүүл мэндийн боловсролын хичээлийн хөтөлбөрт багтсан боловч багш нар ихэвчлэн энэ сэдвийг алгасах, заасан ч заах аргазүйн хувьд зарим талаар сөрөг, ялгаварлан гадуурхах хандлагатай байсаар байна. Цаашилбал, оролцогчдын олонх нь багш, гэр бүлийн гишүүд, үе тэнгийн хүүхдүүд, үл таних хүмүүсийн зүгээс үг хэл, бие махбодын хүчирхийлэл, тэр бүү хэл бэлгийн дарамт амсаж байгаа нь тэдний сэтгэцийн эрүүл мэнд доройтсонтой, ялангуяа сэтгэл гутрал, ганцаардал, өөрийгөө гэмтээх, амиа егүүтгэх зэрэг эрсдэлд өртөмхий байгаатай нягт холбоотой юм. Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ авах боломжгүй байх, сөрөг таагүй үйл явдлууд тохиолдох, түүнчлэн багш, сургуулийн сэтгэлзүйчдэд үл итгэх зэргээс үүдэн дээр дурдсан эрсдэлд өртөмтгий байснаар дийлэнх транс сурагчид тусламж дэмжлэг эрэлхийлэхээс зайлсхийдэг аж. Эцэг эхийн зүгээс дэмжлэг үзүүлдэг хэмээн дийлэнх нь хариулаагүй бөгөөд харин ч трансжендэр хүмүүсийн талаарх гэр бүлийн гишүүдийн хандлага ихэвчлэн сөрөг байдлаар дурдагдсан нь транс* сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд доройтох гол хүчин зүйл болж байна хэмээн дүгнэж болохоор

байна. Цахим орчинд өөрсөдтэйгөө адил олон нийтийг олсноор өөрийгөө тодорхой олон нийтийн нэг хэсэг хэмээн мэдрэх нь, түүнчлэн хамгийн энгийн хэлбэрээр ЛГБТИК+ эрхийн хөдөлгөөнд хувь нэмрээ оруулж, оролцох нь транс сурагчдын эрүүл энх, сайн сайхан аж төрөхийг хамгаалах эерэг хүчин зүйл болдог аж.

Зөвлөмж

Дараах зөвлөмжийг энэхүү кэйс цуглуулгын судалгааны оролцогчдын туршлага дээр үндэслэн бэлтгэн гаргасан болно. Зөвлөмж нь илүү хүртээмжтэй, аюулгүй орчин буюу транс* сурагчдад ээлтэй сургуулийн уур амьсгалыг бий болгох замаар транс сурагчдын даван туулах эрмэлзэл, сэтгэцийн болон биеийн ерөнхий эрүүл мэнд, сайн сайхныг дэмжих зорилготой юм.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГУУДАД

- Хүйсийн тэгш байдлын тухай хуулийг бүх салбар, тэр дундаа боловсролын системд бодитоор хэрэгжүүлэх;
- Транс* хүмүүст зориулсан Үндэсний эрүүл мэнд хамгааллын стандартыг боловсруулж, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр голлон үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн салбарын ажилтан мэргэжилтнүүдийг зохих сургалт, мэдээллээр хангах;
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаарх агуулга бүхий эрүүл мэндийн боловсролын хичээлийн сургалтын хөтөлбөрийн чанарт зохих мониторинг, үнэлгээг хийх;
- Хүйсээр ангилан хуваах сургуулийн бодлогыг халж, транс болон хүйсийн олон янз байдал бүхий сурагчдыг дэмжих нийцтэй бодлого, зааварчилгаагаар сургуулийн бүх нэгдэл хэсгийг хангах;
- Холбогдох хичээлүүдэд, ялангуяа технологи, зохион бүтээх хичээлд хэрэглэгдсээр буй хүйсээр ангилан хуваах үеэ өнгөрөөсөн зохион байгуулалтын арга хэлбэрийг өөрчилж, шинэ зохион байгуулалтын шийдэл танилцуулах;
- Сургуулиудыг дээрэлхэлтийн эсрэг ялангуяа бэлгийн болон хүйсийн олон янз байдлын талаар тусгайлан анхаарсан бодлого, дүрэм журамтай болгох;
- Багш сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч болон сургуулийн бусад бүх ажиллагсдыг үетэнгийн дээрэлхэлт, нийгмийн гишүүдийн олон янз байдал, транс жендер хүмүүстэй холбоотой сэдвээр цогц сургалтад хамруулах.

СУРГУУЛЬ, БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТНУУДАД

- Багш сурган хүмүүжүүлэгчид болон сургуулийн удирдлагуудыг зохих сургалтад хамруулах, үүнд зориулсан төсвийг хангалттай хүрэлцэхүйцээр төлөвлөх;
- Өөрийн эрх мэдлийн хүрээнд транс сурагчдад аюулгүй, ээлтэй уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр ач холбогдолтой үйл ажиллагаа зохион байгуулах, ялангуяа транс*сурагчдын хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй хандаж хүйс онцлон заагаагүй ариун цэврийн өрөөг бий болгох;
- Сургуулийн дүрэмт хувцасны бодлогыг өөрчилж, транс*сурагчид өөрийн хүйсийн баримжаандаа нийцсэн хувцас өмсөх боломжтой дүрэм журмыг шинээр бий болгох;
- Эрүүл мэндийн боловсролын хичээл заах бүтэн цагийн үндсэн багшийн орон тоог бий болгохын зэрэгцээ одоо байгаа багш нарыг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой сэдвийг заах зохих сургалтаар хангах;
- Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйчид транс*сурагчдад зөвлөгөө дэмжлэг үзүүлэхдээ тэдний хувийн нууцыг чандлан хадгалах.

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД

- Хүйсийн олон янз байдал, трансжендер хүмүүстэй холбоотой асуудлаар модуль сургалтын хөтөлбөр боловсруулж сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэгдэж буй, энэ чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн дунд сургалт зохион байгуулах;
- Сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээнд Олон улсын Өвчний Ангилал 11-ийг нэвтрүүлэх;
- Трансжендер хүмүүст тулгамддаг асуудлаар мэргэшсэн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн сүлжээг бий болгож сургуулийн сэтгэлзүйч өөрийн үүрэг, чадавхаас хэтэрсэн нөхцөл байдал үүсэх үед сурагчдад мэргэжлийн сэтгэлзүйн эрүүл мэндийн мэргэжилтэн санал болгох боломжийг бүрдүүлэх;
- Трансжендер болон хүйсийн олон янз байдал бүхий хүмүүсийн нэсрэг ямар нэг зохисгүй авир, үйлдэл гарсантай холбоотой ирсэн гомдол саналд түргэн шуурхай, зохистой байдлаар хариулах, хариу арга хэмжээ авах;
- Трансжендер болон хүйсийн олон янз байдал бүхий хүүхдүүдийн эцэг эхийг хамт олны дэмжлэг, дотоод дахь хамтын бүлэг, тэдгээрийн байгууллагуудын тухай мэдээллээр хангах.

ЦААШ СУДЛАХ НЬ

- Хотын захын хороолол, алслагдмал аймаг суманд амьдран суугаа транс* сурагчдын амсаж туулж буй амьдралын туршлагын талаар нэмж дэлгэрүүлэн судлах;
- Монгол дахь транс залуу үеийн эрүүл мэндийн хэрэгцээ, хамгаалах хүчин зүйлийн талаар тусгайлан судлах;
- Транс болон хүйсийн олон янз байдал бүхий өсвөр залуу үеийн туршлагын талаар эрүүл мэнд, хүний нөөц, нийгмийн ажилтан гэх мэт халамжийн мэргэжилтнүүдтэй хэлэлцэж хамгааллын тохиромжтой загварыг олж тогтоох;
- Транс* сурагчдын амсаж туулж буй гэр бүлийн хүрээний хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар нэмж дэлгэрүүлэх судлах (*Ganbaatar, D., Enkhbold, E., & Munkhbat, O. (2023). Being trans* students at school in Mongolia: Collective case studies. Ulaanbaatar.*)

OUT IN MONGOLIA: THE LIVED EXPERIENCES OF LGBTQI MONGOLIANS (2023), REPORTOUT

2022 онд ЛГБТ Төв НҮТББ нь ReportOUT байгууллагатай хамтран Монгол дахь бэлгийн болон хүйсийн цөөнх олон нийтийн хүний эрхийн зөрчил, хөгжлийн хэрэгцээг судалсан судалгааны багт орж ажилласан бөгөөд энэхүү судалгаанд 18-45 насны, хөдөлмөр эрхэлжбайсан 238 монгол ЛГБТИК+ хүн хамрагдсан нь тухайн үеийн хамгийн олон монгол ЛГБТИК+ хүмүүсийн оролцсон судалгаа юм. Энэхүү судалгааны тайлан 2023 онд боловсруулагдан гарсан бөгөөд судалгааны зарим үрдүнгээс доор хураангуйлан орууллаа.

“OUT in Mongolia” судалгаанд дурдсанаар Монгол Улсад ЛГБТИК+ хүмүүсийн 28% нь 420,000 төгрөгөөс (ойролцоогоор 123 ам.доллар) бага орлоготой амьдарч байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны 2020 оны мэдээллээр Монголын нийт хүн амын ядуурлын түвшин болох 27.8%-тай ойролцоо байна. Ажил эрхлэлтэд гарч буй ялгаварлан гадуурхалт (ажлын байрны ярилцлагаас татгалзах, хамт олон болон удирдлагын зүгээс үзүүлэх дарамт) ЛГБТИК+ хүмүүсийн эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа талаар судалгаанд онцолсон байна.

- Судалгаанд оролцогчдын 42% нь ЛГБТИК+ хүний хувьд Монголын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх нь “маш хэцүү” гэж үзсэн байна.
- Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь (78%) ЛГБТИК+ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал Монголын ажлын байранд байсаар байна гэж үзжээ. Дөрөвний нэг орчим нь

шууд ялгаварлан гадуурхалтад өртсөн.

- Судалгаанд хамрагдагсдын гуравны хоёроос дээш хувь нь сэтгэцийн эрүүл мэндээ 10-аас 6 ба түүнээс доош оноогоор дүгнэсэн бол зөвхөн 29% нь бие махбодын эрүүл мэндээ муу гэж үнэлжээ.
- Судалгаанд хамрагдагсдын 91% нь Монголын шударга ёсны тогтолцоо ЛГБТИК+ хүмүүст шударга бус байна гэж үзэж байна.
- Судалгаанд хамрагдагсдын 88% нь Монголын дийлэнх олонх нь ЛГБТИК+ хүмүүсийг үзэн ядаж, алагчлах нь энгийн үзэгдэл гэж үзэж байна.
- Судалгаанд оролцогчдын 72 хувь нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль Монголд хэрэгжиж эхэлсэн ч тэдний амьдралд ямар ч нөлөө үзүүлээгүй гэж үзсэн.
- Судалгаанд хамрагдсан арван хүн тутмын долоо нь гэр бүлийн гишүүдээсээ ЛГБТИК+ гэдгээ нуун дарагдуулдаг гэв. Энэ нь 2014 оны НҮБ-ын судалгаагаар 87% байсан бөгөөд үүнийг бодвол ахиц гарсан гэж үзэж болохоор байна.
- ЛГБТИК+ монгол хүмүүсийн тал хувь нь эх орондоо байх нь аюулгүй биш гэж мэдэрдэг. Харин хөдөө орон нутагт амьдардаг хүмүүсийн хувьд гуравны хоёр нь аюулгүй байдлыг мэдэрч чаддаггүй байна.
- Ялгаварлан гадуурхалт байсаар байгаа хэдий ч санал асуулгад оролцогчдын тал орчим хувь нь ЛГБТИК+ иргэдийн хувьд Монгол дахь нөхцөл байдал сайжирч байна гэж үзэж байгаа бөгөөд ердөө 21% нь үүнтэй санал нийлэхгүй байна. (*ReportOUT. 2023 OUT in Mongolia: The Lived Experiences of LGBTQI Mongolians.*)

НОМ ЗҮЙ

- Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл, (2011).
- Бэлгийн цөөнхийн хүүхэд, залуусын сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга & дүн шинжилгээ.
- Батхишиг, А., Өлзийтунгалаг, Х., (2009) Гэр бүл хүчирхийллийг судалж нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь
- ЛГБТ Төв, (2013). Монгол дахь бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт.
- ЛГБТ Төв, (2016). ЛГБТ хүүхдүүдийн дунд оролцооны аргаар хийсэн судалгаа.
- Нямдорж, М., Өлзийтунгалаг, Х., Амаржаргал, Т., Энхцэцэг, А., Золжаргалан, Г., (2013) Нийгмийн ажил
- НАБСХ, Онол-Арга ТББ, ЛГБТ Төв, АНУ-ын элчин сайдын яам, (2017).
- Нийгмийн ажил ба ЛГБТ хүмүүс, сургалтын гарын авлага.
- Олон улсын хүний эрх, эрх зүйн Жогжакартын зарчмууд
- Appleby, G.A., & Anastas, J.W. (1998). Not just a passing phase: Social work with gay, lesbian and bisexual people. New York: Columbia University Press.
- Allison R.A, (2012). 10 Things Transgender Persons Should Discuss With Their Health Care Providers
- Asia Pacific Transgender Network, (2015). Blueprint for the Provision of Comprehensive Care for Trans People and Trans Communities in Asia and the Pacific.
- Boehler, D. & Randall, M. (2012). Diversity training and social work: An insight into theory, methodology and practice. ERES web journal, 1/2012.
- Crisp, C., & DiNitto, D.M. (in press). Substance abuse treatment with sexual minorities. In C.A McNeece & D. M. Nitto (Eds.), Chemical dependency; A systems
- Approach (3rd ed.). Boston: Allyn & Bacon.
- Drescher, J. (2015). Out of DSM: Depathologizing Homosexuality. Behav Sci (Basel).
- Jones T. The needs of students with intersex variations. Sex Education. 2016 Mar 11;16(6):602–18
- Ganbaatar, D., Enkhbold, E., & Munkhbat, O. (2023). Being trans* students at school in Mongolia: Collective case studies. Ulaanbaatar.

- Hooker, E. (1993). Reflections of a 40-year exploration. A scientific view on homosexuality. *Am Psychol*.
- ReportOUT. 2023 OUT in Mongolia: The Lived Experiences of LG-BQTI Mongolians.
- Shackelford, T. and Hansen R, ed. (2015) *The Evolution of Sexuality*.
- Van Den Bergh N, & Crisp C. 2014. Defining Culturally Competent Practice with
- Sexual Minorities: Implications for Social Work Education and Practice. *Journal of Social Work Education*
- <http://www.apa.org/topics/lgbt/orientation.aspx>
- <http://www.glaad.org/publications/accelerating-acceptance-2017>

ЛГБТ Төвийн товч танилцуулга

“ЛГБТ Төв” ТББ нь 2009 онд албан ёсоор байгуулагдсан ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, төрийн бус байгууллага мөн.

“ЛГБТ Төв” төрийн бус байгууллагын эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын олон улсын гэрээ, конвенциор баталгаажсан хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, аливаа алагчлалаас ангид байх ардчилсан иргэний нийгмийн үнэт зүйлийг Монголын нийгэмд төлөвшүүлэх, ийнхүү төлөвшүүлснээр бэлгийн болон хүйсийн цөөнх олон нийт болох лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүсийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүний эрхийн зөрчлийг бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хувь нэмрээ оруулах, байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн тулд ижил төстэй зорилго бүхий олон улсын болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын засгийн газар хоорондын байгууллагуудтай хамтран ажиллахад оршино.

“ЛГБТ Төв”-тэй холбогдох:

Утас: 70110323

Имэйл: info@lgbtcentre.mn

Фэйсбүүк хаяг: The LGBT Centre (Mongolia)

<https://www.facebook.com/LGBTtuv/>

Инстаграм: @lgbtcentre.mongolia

Твиттер: @LGBTMongolia

Вэб хаяг: www.lgbtcentre.mn

